




# СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.12.10 №48, 49 (10725, 10726)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

## ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЬЕ!

### ЦАГААН НӨМРӨГТ БААТРУУДДАА БАЯРЛАЛАА

Эрүүл мэндийн яамнаас өдөр бүр шууд хүргэдэг мэдээллийн үеэр Цэргийн төв эмнэлгийн хамт олныг ХӨСҮТ-ийн нэгэн адил үүрэг хүлээн өндөр ачаалалтай ажиллаж байгааг удаа дараа цохон тэмдэглэж талархал илэрхийлснийг уншигч та сонсож цэргийн эмч, сувилагч, ажилтнуудаараа бахархаж бас тэдэндээ баярлаж байгаа биз ээ.

Дэлхий дахинд коронавирусын халдвар дэгдэж, уг халдвар Монгол Улсад зөвөөрлөгдөн орж ирснээс хойш Цэргийн төв эмнэлгийн хамт олон иргэдийг тусгаарлан эмчилж өндөр ачаалал дунд ажилласаар жил орчмын хугацаа өнгөрч байна.

2020 оны 11 дүгээр сарын дунд үеэс эхлэн манай оронд дотооддоо цар тахал голомтлон тархаж, энэ үед ХӨСҮТ-тэй хамтран бэлэн байдал, халдвар, хамгаалалтын журмыг улам өндөр түвшинд сахиууцлагатай үүргийг биелүүлэн ажиллаж байгаа юм. Тодруулбал, Эрүүл мэндийн сайд, Батлан хамгаалахын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хамтарсан "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай" А/5478, А/279 дүгээр тушаалын хүрээнд Цэргийн төв эмнэлэгт ажиглалт, хяналт, тусгаарлалтад байсан жолооч Д-ийн дөрвөн настай хүүхдийн ойрын хавьтал 75 иргэнийг гэрийн тусгаарлалтад шилжүүлсэн юм. Мөн Сэлэнгэ, Дархан, Орхон, Дорноговь, Говьсүмбэр, Архангай аймгууд болон Улаанбаатар хотод "Ковид-19" халдварын голомтод батлагдсан тохиолдлоос нэн хүнд 4, хүнд 8, хүндэвтэр 60 гаруй, хөнгөн 190 гаруй өвчтөнг хүлээн авч эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэн 45 эмч, сувилагч, 17 эмнэлгийн ажилтан халдвартын эмнэлгийн горимоор үүрэг гүйцэтгэж байна.



### Б.Эрдэнэбат: БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАЖ БАЙГАА

Монгол Улсын зарим аймаг болон нийслэлд "Ковид-19"-ийн цар тахал голомтлон тархсанаас шалтгаалан Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжээд буй энэ цаг үед Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэгээр ахлуулсан "Удирдлагын шуурхай бүлэг" томилогдон үүрэг гүйцэтгэж байна.

Тус бүлэг нь Зэвсэгт хүчнээс дэмжлэг үзүүлэх ажиллагааны хувилбар, гүйцэтгэх үүргийг тодотгож, Зэвсэгт хүчний ангиудын үүрэг гүйцэтгэх бэлтгэл, хүн, хүчний тооцоог нарийвчлан гаргах, цэргийн техникийн бэлэн байдалд хяналт тавих, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөц, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн үзлэгийг хийх, энэ чиглэлээр сургалтыг зохион байгуулах, хяналтыг нь өндөржүүлэх талаар холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа юм.

(Үргэлжлэл нь II нүүрт)



### Ц.Анхбаяр: ЦАГ ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛАН ТОДОРХОЙ АЖЛУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Коронавирусийн цар тахал монгол оронд дотооддоо тархаж Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн энэ цаг үед иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалахын тулд удирдлага, зохион байгуулалт чухалд тооцогдох нь зүйн хэрэг. Одоогийн байдлаар нийслэлийн хэмжээнд дүүрэг болгоноор нь бүсчлэн хувааж Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг

хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бид энэ талаар дэлгэрэнгүй тодруулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Анхбаяртай ярилцлаа. Тэрээр хэлэхдээ "Батлан хамгаалахын сайдаас Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудад таван чиглэлийн үүргийг өгсөн. Үүний хэрэгжилтэд бид бүхэн



### Хилийн чанадаас мэдээлж байна

### ХОЁР ХҮНИЙ АМИЙГ АВАРЧЭЭ

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн мотобуудлагын батальон нь тус улсын хамгийн том дотоодын дүрвэгсдийн хуарангийн аюулгүй байдлыг хангах, НҮБ-ын ажилтан албан хаагчид болон иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг сахин хамгаалах үүрэг нэр төртэйгээр гүйцэтгэж буйгаа тодоор батлан харууллаа.

Тодруулбал, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 17.50 цагийн орчимд Юнити мужийн Бентью хотын дотоодын дүрвэгсдийн хуаранд үйл ажиллагаа явуулж байсан "Хил хязгааргүй эмч нар" олон улсын хүмүүнлэгийн байгууллагын хоёр эмэгтэй ажилтан руу орон нутгийн нэг иргэн халдаж, хүчирхийлэхээр завдсаныг харуулын цэгт үүрэг гүйцэтгэж байсан дэд ахлагч Г.Мөнхбат, Г.Ганбаяр нар цаг



Зүүн гар талаас: Дэд ахлагч Г.Мөнхбат, Г.Ганбаяр

алдалгүй таслан зогсоолоо. "Хил хязгааргүй эмч нар" олон улсын хүмүүнлэгийн байгууллагын удирдлага, ажилтнуудын зүгээс манай цэргийн алба хаагчдад чин сэтгэлээсээ талархал илэрхийлж, амжилт хүссэн юм.

Холбогдох албаныхны мэдээлснээр Монгол Улсын

Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн мотобуудлагын батальоны хариуцлагын бүсэд энэ төрлийн гэмт хэрэг, халдлага, хүчирхийлэл цаашид ч үргэлжлэх хандлагатай байна гэв.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАДМИД

үүрэг бүхий байгууллагуудын томилгоот бүрэлдэхүүн 24 цагийн хугацаагаар тасралтгүй үүрэг гүйцэтгэж байна. Тэдгээр тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын нэг нь Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабууд юм. Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабууд нь Батлан хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг орон нутагт тайван болон онцгой нөхцөлийн үед хэрэгжүүлэх, уг асуудлаар нутгийн захираагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд энэхүү үндсэн үүргийнхээ хүрээнд цаг үетэйгээ уялдуулан хариуцлагатайгаар албан үүргээ гүйцэтгэж, тодорхой арга хэмжээг

анхаарч ажиллах хүрээнд "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-нд тодотгол хийж байна. Мөн Нийслэлийн Засаг даргын захирамжаар "Нийслэлийн шуурхай штаб" байгуулагдсан. Тус штабын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хоёр цэргийн алба хаагчийг томилон ажиллуулж байна. Тодруулбал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Батлан хамгаалах хууль тогтоомж хариуцсан ахлах офицер, дэд хурандаа М.Мөнгөнтулга ажиллагааны удирдлагын багт, мэдээллийн аюулгүй байдлын офицер, хошууч Б.Чимэд удирдлагын багт бичиг хэрэг боловсруулалт, нууцын асуудлыг хариуцан үүрэг гүйцэтгэж байна.

(Үргэлжлэл нь II нүүрт)

## О.Энхбаяр: АНАЛОГИ СИСТЕМИЙГ ТООН ҮЙЛДЛИЙН СИСТЕМД ШИЛЖҮҮЛНЭ ГЭДЭГ ТОМ АЖИЛ

Агаарын цэргийн командлалын хамт олон 2020 оны ажлын амжилт ололтоо дүгнэн өнгөрсөн сарын 27-ны өдөр тайлангийн хурлаа хийлээ. Тус хуралд Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал, Хяналт шалгалт, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа С.Алтай болон Агаарын цэргийн командлалын харьяа ангиудын захирагч нар цахимаар оролцжээ. Энэ талаар Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал О.ЭНХБАЯРТАЙ ярилцлаа.



### Агаарын цэргийн командлал энэ онд ямар ажлуудыг хийж гүйцэтгэсэн бэ?

-Бид энэ оны төлөвлөгөөт ажлаа дүгнэхэд 90,1 хувийн хэрэгжилттэй гэсэн тооцоо гарсан. Энэ нь нийт 70 гаруй ажлаас долоо нь хэрэгжээгүй гэсэн үг. Үүний шалтгаан нь цар тахлаас үүдэлтэй хөл хорио болон зардал, мөнгөний асуудал байлаа. Улсын хилийг хааснаас үүдэн гаднын зарим оронтой харилцан ажиллах боломжгүй болсон. Гэвч бид дотооддоо төлөвлөсөн ажлаа хангалттай хэмжээнд хэрэгжүүлсэн. Энэ жил таван удаагийн команд штабын, долоон удаагийн тактикийн хэргийн сургууль болон нэгдсэн тактикийн хэргийн сургуулийг амжилттай зохион байгуулсан. Урьд жилүүдээс онцолж

хэлэхэд, энэ онд бид бүхэн техник, технологийн шинэчлэл, инновацыг өөрсдийнхөө хэмжээнд хангалттай хэрэгжүүлсэн. Мөн Агаарын цэргийн командлал болон харьяа анги, салбарууд албаны хөх өнгийн хувцсаар жигдэрсэн.

### Төлөвлөгөөт бусад ажлын тухайд...

-Бид байнгын жижүүрлэлт, агаарын орон зайн тандалт, хяналтаа сайжруулахын тулд Зэвсэгт хүчний Жанжин штабын дэмжлэгээр нисгэгчгүй нисэх хэрэгслийн туршилтын төвийг байгуулсан. Мөн агаарын цагийн байдлын мэдээ, мэдээллийг боловсруулах ажиллагааг автоматжуулах асуудлыг олон жил хэлэлцэж, төлөвлөн санал, санаачилга гаргаж байгаа. Энэ талаар бид тендер, гаднын

байгууллагуудын дэмжлэг гэлтгүй өөрсдийн боломжид тулгуурлан ажилласан. Үүнийгээ тактикийн хэргийн сургуулиар туршихад боломжтой гэсэн дүгнэлтэд хүрсэн. Хуучин техник, технологийг шинэ зүйлтэй хослуулна гэдэг нь санаснаар болдог ажил биш. Үүний гарцыг хайж ажиллалаа. Аналог системийг тоон үйлдлийн системд шилжүүлнэ гэдэг том ажил. Хөдөө, орон нутгийн салбаруудтай цэргийн радио холбоогоор харьцахад бэрхшээлтэй байдаг. Тиймээс үүрэн холбооны сүлжээг нууцлалынх нь горимыг мөрдөн салбаруудад ашиглах ажлыг бид өөрсдийнхөө хэмжээнд ихээхэн хөрөнгө зарцуулахгүйгээр хэрэгжүүлж байна. Мөн бодлогын чанартай 4-5 баримт бичгийг батлууллаа. Үүнд зөвхөн дотооддоо хэрэгжүүлэх дүрэм, журмыг баталсан. Ажлын хэсэг байгуулагдаж жил бүр уламжлал болсон тэргүүний анги, салбар, тэргүүний офицер, ахлагч нараа тодруулсан. Харин командлал дотроо тэргүүний хэлтэс, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ажилтнуудаа мөн шалгарууллаа. Энэ сарын дундуур шалгарсан анги, салбар, алба хаагчдаа зарлана.

### Ирэх жил ямар бүтээл ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа вэ?

-Ирэх жил анги, салбаруудын командын байруудад засвар, үйлчилгээ хийх ажлыг төлөвлөсөн. Мөн зарим ангиудын техник, хэрэгслийг тоноглох асуудлыг төлөвлөж байна. Энэ жил зохион байгуулсан команд штабын болон тактикийн хэргийн сургуулийг илүү өндөр түвшинд зохион байгуулна. Хорио цэргийн дэглэм суларч хил нээгдэхээр нисгэгчдээ Оросын Холбооны Улс руу давтан сургалтад хамруулж сөнөөгч онгоцоо хөөрөгх бэлтгэлийг хангана. Мөн аэродромуудад болон нисдэг тэрэгнүүдэд техникийн үйлчилгээг хийлгэх ажлууд хүлээгдэж байгаа. Командлалын хувьд тодорхой тооны баримт бичгийг батлуулах ажлыг төлөвлөх зэрэг олон ажил биднийг хүлээж байна.

## Ц.Анхбаяр: ЦАГ ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛАН ТОДОРХОЙ АЖЛУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

(Түрүүч нь I нүүрт)

Нийслэлийн Цэргийн штабын хувьд QR кодтой холбоотой Батлан хамгаалах

орон нутагт дэмжлэг үзүүлж ажиллана" гэсэн журам бий. Энэ журмыг үндэслэн дүүрэг бүрд цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг томилгоожуулж



яамнаас ирж буй баримт бичгүүд, Зэвсэгт хүчний бүтээн байгуулалттай холбоотой автомашинуудыг хотоос гаргах, дамжин өнгөрүүлэх тухай удирдлагын баримт бичгүүдийг үйл ажиллагааны багаар дамжуулан зохицуулах ажлыг хийж байна. Хэрэв бэлэн байдлын дараагийн зэрэгт шилжих тохиолдолд шаардлагатай бэлтгэл ажлын төлөвлөгөөг тодорхойлсон. Энэ ажлын хүрээнд нэгдсэн байдлаар мэдээллийн сан үүсгэж сайжруулсан түлш худалдаалах цэгүүд, худаг, томоохон сүлжээ дэлгүүрүүд, засаг захиргааны нэгжийн байруудыг газрын зурагт тэмдэглэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Нийслэлийн есөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын бие бүрэлдэхүүн хоорондоо нягт уялдаа холбоотой ажиллаж байгаа бөгөөд жижүүр, эргүүлийг тасралтгүй зохион байгуулж, цар тахлын тархалт ихтэй хороонд амьдарч буй хугацаат цэргийн алба хаагчид болон офицер, ахлагч нарын ар гэрийнхний судалгааг гаргаж бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Мөн түлш, хүнсний хэрэгцээг хуваарилан зөөж тээвэрлэхийг хариуцаж байгаа гээд хэдэн ажлыг дүүрэг болгоны Цэргийн штабууд тухайн харьяа байрлалдаа гүйцэтгэж байгаа" гэв. Засгийн газрын 80 дугаар тогтоолд "Цэргийн дүйцүүлэх алба хаагчид хүн, малын гоц халдварт өвчин дэгдсэн үед

тодорхой ажлуудад хуваарилжээ. Жишээ нь иргэдээс цар тахлын шинжилгээ авах үйл явцад зохион байгуулалт хийх, зарим дүүрэгт автомашины хөдөлгөөнд зохицуулалт хийх зэрэг ажилд дэмжлэг үзүүлэх үүрэгтэйгээр ажиллаж байгаа аж. Түүнчлэн нийслэлийн хэмжээнд Цэргийн штабуудын офицер, ахлагч нарын бүрэлдэхүүнийг 100 хувь, цэргийн дүйцүүлэх алба хаагчдын 90 хувийг "PCR" оношлуураар коронавирусийн шинжилгээнд хамруулсан байна. Учир нь эдгээр алба хаагчид олон хүнтэй харьцдаг учир эрүүл байх нь чухал юм. Энэ мэт ажлуудыг нийслэл Улаанбаатар хотын хүрээнд Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудын хамт олон хийж гүйцэтгэж байна. Мөн өнгөрсөн долоо хоногийн Баасан гарагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2020 онд зохион байгуулах сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Цэргийн штабын офицер, ахлагч нартай мэргэжил, арга зүйн сургалтыг цахимаар зохион байгуулсан гэв. Тус сургалт нь офицер, ахлагч нарт Дайчилгааны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэргэжлийн чиглэл олгох, төрийн албаны ёс зүйг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд "Жендэрт суурилсан хүчирхийллийг цэгцэлье" аянд нэгдэхийг уриалж байгаагаараа онцлог аж.

## Б.Эрдэнэбат: БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАЖ БАЙНА

(Түрүүч нь I нүүрт)

Мөн Зэвсэгт хүчний Жанжин штабын "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-ний дагуу томилгоот бүлгүүдийг тодотгон, үүсэж болзошгүй гамшигийн үед гүйцэтгэх үүрэгүүд, харууцах нэгж, гамшигийн үеийн удирдлагын тогтолцоог шинэчлэн боловсруулах ажлыг хийж байна.

Энэ талаар "Удирдлагын шуурхай бүлэг"-ийн штабын дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны у д и р л а г ы н газрын хэлтсийн дарга, хурандаа Б. ЭРДЭНЭБАТААС тодрууллаа.

### Удирдлагын шуурхай бүлэг энэ цаг үед хэрхэн ажиллаж байна вэ?

-Энэхүү бүлэг нь "Онцгой нөхцөл байдал үүссэн үед харилцан ажиллах төлөвлөгөө"-ний дагуу 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар байгуулагдсан. Байгуулагдсан даруйдаа улс оронд онцгой нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх томилгоот бүрэлдэхүүнийг тодотгохын сацуу Улаанбаатар цэргийн хүрээний болон нийслэл хотын орчимд байрлах Зэвсэгт хүчний ангиудаар хорио цээрийн дэглэмд дэмжлэг үзүүлэх ажиллагааны хувилбарыг боловсруулсан. Дээрээс нь, Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлагуудыг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудтай тогтоосон хугацаанд болон шаардлагатай үед цахимаар холбогдох нөхцөлийг нь ханган

ажиллаж байна.

### Бусад байгууллагуудтай хэрхэн хамтарч ажиллаж байгаа вэ?

-Улсын онцгой комисс болон Нийслэлийн онцгой комисст гурван цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа. Мөн Дархан-Уул, Орхон, Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Сүхбаатар, Дорноговь аймгуудын нутаг дэвсгэрт Зэвсэгт хүчний 6 анги, 5 салбарын 14 томилгоот бүлэг, нийт 141 цэргийн алба хаагч төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчидтай хамтран эргүүл хийж, хяналтын цэг, шалган нэвтрүүлэх цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байна. Зэвсэгт хүчний техникийн хяналтын албанаас нийт 10 цэргийн алба хаагч Офицеруудын ордон болон Чулуун овооны тойргийн орчимд 06.30-23.00 цагт замын хөдөлгөөнийг зохицуулах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс 2021-2022 онд НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд цэргийн ажиглагч, штабын офицер, ахлагчаар үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчдын сонгон шалгаруулалтыг 2020 оны 12 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд зохион байгуулна.

Уг сонгон шалгаруулалтад хамрагдах хүсэлтэй цэргийн алба хаагчид 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дотор ЗХЖШ-ын Энхийг дэмжих-цэргийн хамтын ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн ирүүлнэ үү.

Сонгон шалгаруулалтад хамрагдах цэргийн алба хаагч нь дараах үндсэн шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд: 1. Монгол Улс, Зэвсэгт хүчний нэр хүндийг өндөрт өргөн үүрэг гүйцэтгэх ёс суртахууны төлөвшилттэй, цэргийн мэргэжлийн үр чадвартай, ажлын үр дүн, сурлага, сахилгаар тэргүүний, эрсдэлийг ойлгож түүнийг даван туулах чадвар, сэтгэл зүйн бэлтгэлжилттэй, Зэвсэгт хүчний

анги, байгууллагад мэргэжлийн сургууль төгссөнөөс хойш 8-аас доошгүй жил ажиллаж байгаа ахмадаас хурандаа цолтой офицер, ахлах ахлагчаас тэргүүн ахлагч цолтой ахлагч;

2. Эрүүл мэнд, цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандартыг бүрэн хангадаг;

3. Англи хэлний гүнзгий шатны мэдлэгтэй (шалгалтыг яриа, бичиг, сонсгол, унших зэрэг 4 чадвараар авна);

4. Механик хурдны хайрцагтай 4x4 загвар бүхий дунд оврын жийп автомашиныг жолоодох, өдөр тутмын техникийн үйлчилгээ хийх мэдлэг, дадлагатай;

5. Төрийн албан хаагчийн болон цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

6. Энхийг дэмжих ажиллагаанд цэргийн багт үүрэг гүйцэтгэж байсан туршлагатай зэрэг болно.

Сонгон шалгаруулалтад хамрагдах цэргийн алба

хаагч нь дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;

2. Ажил байдлын тодорхойлолт;

3. Анги, байгууллагын даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл (Сонгон шалгаруулалтад хамруулах);

4. Жолооны үнэмлэхний хуулбар;

5. Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаанд хамрагдсан сертификатын хуулбар;

6. Сүүлийн 3 сарын дотор авахуулсан 4x6 хэмжээтэй цээж зураг 2 хувь.

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг Зэвсэгт хүчний Жанжин штабын ЭДЦХАХ-ийн psod@mail.gov.mn цахим мэйл хаягаар тодруулж болно.

**ЗХЖШ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ-ЦЭРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС**

# ҮЛГЭР ЖИШЭЭ ХӨГЖИМГҮЙ ТӨР, ЦЭРГИЙН ЁСЛОЛ ГЭЖ ҮГҮЙ



"Баярлалаа" тоглолт, 2019 оны 12 дугаар сар.

Дайны хүнд жилүүд, энх цагийн бүтээн байгуулалт, хөдөлмөрийн фронтод эр цэрэг, эгэл олонтойгоо хамт яруухан хөгжмийн цоглог аялгуугаар ялалт, амжилтад зоригжуулж ирсэн Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим 70 нас хүрч байна. 1950 онд Монгол Төрийн ёслол, хүндэтгэлийн цэргийн үлээвэр хөгжим байгуулагдаж өнөөгийн ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим болтлоо

туурвижээ. Тухайлбал, Цэргийн хөгжмийн түүхийг харлуулсан баримтат киног бүтээсэн бөгөөд хөл хорио тавигдахаар 70 жилийнхээ ойн ёслол хүндэтгэлийн арга хэмжээний үеэр үзэгчдийн хүртээл болгохоор төлөвлөжээ. Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн хамгийн том илэрхийлэл болсон уран бүтээл нь марш. Тийм ч учраас тус байгууллагын уран бүтээлчид маршийг судалж, үнэт өв болгон хадгалах үүднээс

хамтран зүтгэгчдээ хурцлах, илүү ихийг хийж бүтээхэд урин дуудах явдал байдаг. Үүнийг ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийнхөн нутагшуулах үүднээс төрөл мэргэжлийн уралдаан тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулдаг уламжлалтай. Түүхт 70 жилийнхээ ойн хүрээнд энэ удаад "Бүжгийн хөгжмийн найруулга" уралдааныг анх удаа зохион байгуулжээ. Уралдаанд нийт 11 уран бүтээлч оролцож, 14 бүтээл ирүүлсэн байна. Тус уралдааны онцлог, ач холбогдлын талаар ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн ахлагч, сургагч ахлагч П.Баттогтох "Энэхүү уралдаанд оролцогч нь ямар нэг аяг өөрсдийн мэдрэмжээр найрал хөгжимтэй хоршуулан үзэгчдийн хүртээл болгох юм. Тухайн хүнээс хөгжмийн зэмсгийн өндөр мэдлэг шаарддаг учир ур чадвар нь ямар түвшинд байгааг нь харж болно. Мөн тухайн тэмцээнд оролцохын тулд өөрсдийн ур чадварыг нэмэгдүүлэх талаар ихээхэн ахиц гаргасан ур дүн харгагддаг. Тиймээс энэ төрлийн уралдаан тэмцээнд бүх бие бүрэлдэхүүнийг оролцуулахыг илүүд үзэхийн зэрэгцээ ижил төрлийн уралдаан тэмцээнийг өндөр хэмжээнд, чанартай зохион байгуулахыг

ажлыг энд дурдах учиртай. ҮБХИС-ийн Хөгжмийн сургуулийн төгсөгчид хүрэлцээтэй байж чаддаггүйн улмаас энэ удаад орон нутгийн иргэдээс сонгон шалгаруулж, зохих сургалт, хичээлүүдэд хамруулснаар өнөөдөр тэд ангидаа үүргээ гүйцэтгэж эхэлсэн байна. Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим нь урт хугацааны дадлага, мэргэжил, ур чадвар шаарддаг ч өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тэдгээр хөгжимчдийг бэлтгэсэн бөгөөд одоо ч сургалт нь үргэлжилж байгаа талаар Цэргийн хөгжмийн албаны уран бүтээл эрхэлсэн офицер, хошууч Б.Цэнгэл дурдаж байлаа.

Түүнчлэн энэхүү хөл хорионы үед Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын хөгжимчид нэгдсэн удирдлагаар дадлага болон онолын хичээлүүдэд цахимаар тогтмол хамрагдаж байгаа бөгөөд энэ нь ирэх жилийн "Алтан бүрээ" тоглолтын бэлтгэл гэж хэлж болох юм. Мөн сүүлийн жилүүдэд төр, цэргийн ёслол, хүндэтгэлийн ажиллагаанд ҮЖҮНХ-ийн хөгжимчид гэлтгүй Зэвсэгт хүчний цэргийн ангиудын хөгжимчдийг оролцуулж эхэлсэн бөгөөд энэ нь тэдний ур чадварыг нэмэгдүүлэх, нэг түвшинд байх шаардлагад нийцүүлж буй хэлбэр юм.

нэг хөгжимчин ахлагч магистрын зэрэгтэйгээр тус тус амжилттай сурч төгссөн явдал юм. Мөн 2021 онд тус сургуулийг 14 хөгжимчин ахлагч төгсөхөөр төлөвлөсөн ажээ. Дэлхий нийтэд тархаад байгаа коронавирусын дэгдэлтээ үүдсэн хөл хорионы хугацаанд хүн нэг бүрийн буюу ганцаарчилсан хичээлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулснаар хөтөлбөр, хуваарийн дагуу сургуулилтаа явуулж эхэлсэн юм. Энэ нь ихээхэн үр дүнгээ өгч байгаагийн дээр уран бүтээлчдийн ур чадвар нь нэг шат ахисан хэмээн сургалт, соёл хүмүүжлийн офицер, удирдаач, хошууч А.Алтансүх хэллээ.

## УРЫН САНГИЙН 1000 ГАРУЙ БҮТЭЭЛИЙГ ЦАХИМЖУУЛСАН

Мөн тус байгууллагын бие бүрэлдэхүүний хийж байгаа нэг томоохон ажил нь уран бүтээлийн санг цахимжуулж буй явдал бөгөөд энэ талаарх мэдээллийг ҮЖҮНХ-ийн хөгжмийн зохиолч, найруулагч, удирдаач, ахмад Ц.Биндэръяа өглөө. Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн урын санд 142 орны төрийн дуулал, дэлхийн болон Монголын



Хурандаа Ч.Гансүх

хөгжин бэхэжжээ. Мөн дэлхийн 150 гаруй орны төрийн дууллыг эгшиглүүлж, жилдээ олон арван улсын төрийн тэргүүн, элчин сайдуудыг хүлээн авч, төр, цэргийн хүндэтгэл, ёслолын арга хэмжээнд амжилттай оролцон Монголын үлээвэр найрал хөгжимчдийн ур чадварыг дэлхий дахинд сурталчлахад чухал үүрэг гүйцэтгэжээ.

Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим байгуулагдсанаар Монголын анхны мэргэжлийн хөгжим бий болсон бөгөөд энэ нь Зэвсэгт хүчний нэгэн тод бахархал юм.

Бахархам түүх, байгуулсан гавьяагаа нэр хүндтэй залгамжилж яваа өнөөгийн ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн бие бүрэлдэхүүн түүхт 70 жилийнхээ ойн хүрээнд хийж бүтээсэн ажил арвин ихтэй байна. Бүгдийг дэс дараатай эхэлсэн тэдний бүтээн байгуулалт болон оюуны хөрөнгө оруулалт нь өнөөгийн Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийг "төрөл арилжсан" мэт болгосон нь нүднээ илт харгадана.

Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын хөрөнгө оруулалтаар тэд уран бүтээл туурвихад яг цав нийцсэн тав тухтай танхим, өрөө тасалгааны засвар, тохижилтыг хийж, хөгжмийн зэмсгээ 100 хувь бүрэн шинэчилсэн зэрэг амжилттайгаар 2020 оноо угтаж байсан бөгөөд тэр бүгдийнхээ ид шидийг гарахуйц уран бүтээлийн чанарт анхаарч, ахиц гаргасан жил болжээ.

Цаг үеийн нөхцөл байдал ч мөн үүнд нөлөөлсөн бөгөөд тэд үүнийг бүрэн дүүрэн ашиглаж, хэрэгжүүлж чадсан талаар Зэвсэгт хүчний Цэргийн хөгжмийн алба, Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн дарга, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хурандаа Ч.Гансүх хэдэнтээ дурдаж байсан. Ур чадвартай, мэргэжлийн байх нь хөгжимчний амин сүнс гэдгийг байнга сануулж, түүндээ зүгээ ажиллахад удирдлагын зүгээс анхаарч, ажил хэрэгчээр ханддаг талаар мөн дурдсан юм. Үүнээс гадна тэд түүхт 70 жилийнхээ ойн хүрээнд хэд хэдэн томоохон оюуны бүтээлийг

цомгийг бүтээгээд байгаа ажээ. "Монгол марш" нэртэй тус цомог нь Монголын хөгжмийн урлагт маршийнх гэдгээрээ анхдагч болоод зогсохгүй дотроо 10 CD, 80 орчим маршийн аязыг багтааснаараа томоохонд тооцогдоно. Сонирхуулахад, нийтийн хүртээл болсон 500 гаруй марш байдаг ажээ.

Ирэх 2021 он ҮЖҮНХ-ийнхний хувьд уран бүтээлийн чансааг сорьсон, хэрхэн ахисан, чанаржсаныг илтгэн харуулах жил болох нь дамжиггүй. Учир нь Зэвсэгт хүчний 100, БХЯ-ны 110 жилийн түүхт ойнуудын хүрээнд "Алтан бүрээ" цэргийн хөгжмийн наадмыг зохион байгуулах аж. Тус тоглолтод ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн уран бүтээлчид болон Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын үлээвэр найрал хөгжимчид хамтран оролцох бөгөөд ойролцоогоор 300 гаруй хөгжимчин оролцуулахаар төлөвлөжээ.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ҮЖҮНХ-ийн уран бүтээлчид олон улсын тэмцээн, уралдаануудад амжилттай оролцож байсан багагүй туршлагатай бөгөөд 2019, 2020 онд цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн түр азнаад байна. Гэсэн хэдий ч цаг сайхан болсон үед олон улсын шинж чанартай арга хэмжээнүүдэд уламжлал ёсоор оролцохоос гадна эх орондоо олон улсын цэргийн хөгжимчдийг оролцуулсан наадмыг зохион байгуулах хэтийн биш зорилго ч тэдний төлөвлөгөөнд байгаа талаар энэ үеэр сонирхуулсан юм.

Дараагийн дугаарт Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн үе үеийн ахмадуудтай хамтран зурган цомог хийхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь ихээхэн үр дүнтэй ажил болох юм. Учир нь үлгэр жишээ хөгжимгүй төр, цэргийн ёслол гэж үгүй тул тэднийхний үүх түүх, бахархал энд дэлгэгдэх нь зүйн хэрэг юм.

## ӨРСӨЛДӨӨН ДУНД УРАН БҮТЭЭЛ ЧАНГАРДАГ

Уран бүтээлч хүмүүсийн өсөн дэвших бас нэг хэлбэр нь уралдаан тэмцээнд тогтмол оролцож, өөрсдийгөө болон



Сургагч ахлагч П.Баттогтох

эрмэлздэг" гэлээ. Мөн ирэх жил түүхт ойнуудын хүрээнд зохион байгуулах тэмцээн уралдаануудад Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийнхөн болон Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын хөгжимчид эрчимтэй бэлтгэж эхэлжээ. Үүнээс гадна Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний дийлэнх хувийг эзэлж байгаа ахлагчдынхаа бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл чийрэг байлгах ажлуудыг тогтмол зохион байгуулж байгаа талаар энэ үеэр мэдээлэл өгсөн юм.


## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХОЁР АНГИ ХӨГЖИЙН САЛААТАЙ БОЛСОН



Хошууч Б.Цэнгэл

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын цэргийн хөгжимчдийн ур чадвар чанаржиж байгаа талаар дээр хэдэнтээ дурдсан. Тэгвэл энэхүү оюуны хөрөнгө оруулалтаас гадна Зэвсэгт хүчний 331, 234 дүгээр ангиудыг хөгжмийн зэмсгээр хангаж, хөгжмийн салаа бүрэн бүрэлдэхүүнтэйгээр томилгоожуулсан нэгэн чухал

## ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТ УРАН БҮТЭЭЛЧДИЙН УР ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙНА



Хошууч А.Алтансүх

Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн бие бүрэлдэхүүн нь төрийн үндэсний, дипломат болон цэргийн ёслол, хүндэтгэлийн ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээс гадна тэдний зайлшгүй анхаарч, дээшлүүлэх ёстой зүйлийн нэг нь цэргийн эрхийн мэдлэг юм. Тиймээс өдөр тутмын үйл ажиллагаандаа цэргийн сургалт бэлтгэлийг үе шаттайгаар төлөвлөн, хичээл сургалтыг тогтмол явуулж байдаг. Ангийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөг Зэвсэгт хүчний Жанжин штабын 2020-2021 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан сургалтын хөтөлбөр, түүнд тавигдах шаардлага, стандартад нийцүүлэн боловсруулж, үндсэн бие бүрэлдэхүүн болон хүн нэг бүрийн бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэн, шинээр боловсруулагдаж гарсан нормативын эмхэтгэл, сурах бичгийн дагуу цэргийн сургалт бэлтгэл болон мэргэжлийн сургалт бэлтгэлийг зохион байгуулан явуулдаг. Ангийн удирдлагын зүгээс офицер, ахлагч нарын мэргэжил ахиулах болон дараагийн шатны сургалтуудад байнгын анхаарал хандуулж хэвшсэн бөгөөд үүний нэг илрэл нь 2020 онд Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн 20 хөгжимчин ахлагч Соёл урлагийн их сургуулийн хөгжим урлагийн ангийг бакалавр, мөн



Ахмад Ц.Биндэръяа

хөгжмийн зохиолчдын найрал хөгжимд зориулсан бүтээл, дуу, нийтийн бүжиг болон марш, вальс, гоцлол хөгжим, цөхөөл хөгжмийн хамтлагт зориулсан нийт 5200 гаруй зохиол, бүтээл хадгалагддаг. Эдгээрээс одоогийн байдлаар 900 гаруй уран бүтээл байнга тоглогддог гэнэ. Тиймээс тэдгээрийн мэргэжлийн урлагийн байгууллагуудын баримт бичгийн бүрдүүлэлт, архивын тухай хууль, MNS 5140-1:2011, MNS 5140-2:2011 стандартыг мөрдлөг болгон, үндэсний болон гадаадын соёл, урлагийн ховор бүтээл, урын санд хадгалагдаж буй нот, уншвар, удирдварыг цахим хэлбэрт оруулж, тоглогдож байгаа зохиол, бүтээлийг дуу болон дүрс бичлэгээр хадгалан авч үлджээ. Мөн МҮОНРТ-ийн "Алтан сан" хөмрөгт хадгалагдаж байгаа цэргийн хөгжмийн ахмад уран бүтээлчид, хөгжмийн зохиолчид, удирдаачдын зохиол, бүтээлүүдийг авч шинэчлэн засварлаж, цахимжуулан энэхүү сангаа арвижуулжээ. Эдгээр нь тус байгууллагын түүхт 70 жилийн ойн хүрээнд хийгдэж байгаа томоохон үр бүтээлтэй ажлууд гэж хэлж болох юм.

Ийнхүү түүхт 70 жилийн ойгоо угтаж байгаа ЗХЖШ-ын ҮЖҮНХ, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын үлээвэр найрал хөгжмүүд нь төрийн болон цэргийн ёслол, хүндэтгэлийн ажиллагаанд амжилттай оролцож, хөгжмийн урлагийг сурталчлан таниулах, иргэд, хүүхэд, залуучуудад гоо зүйн хүмүүжлийг олгоход дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ урлагаар үйлчлэх нэр төртэй эрхэм үүргээ үеийн үед, өнө мөнхөд биелүүлсээр байна.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

## ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЧУУЛГЫН 88 ЖИЛИЙН ОЙД

Монгол цэргийн урлагийн манлай, яруу алдрын дайчин замналыг туулан эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцсэн, Ардын хувьсгалын шуурган голын дундаас төрсөн “Шивээ хиагт” дуугаар уухайлан шинэ цагийн театр, хөгжмийн урлагийг анх үүсгэсэн цорын ганц байгууллага нь өнөөгийн Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулга юм. Эрдмийн хэмээхийг тодотговоос, “Академи” гэх грек үгнээс гаралтай.

байна. Энэ жүжгийг комиссар Насанбат найруулжээ. Тус жүжгийг Цэргийн яамны Сурган боловсруулах хэлтсээс хянан шалгаж баталснаар 1921 оны 10, 11 дүгээр сард Цэргийн сургууль, нэгдүгээр морьт дивизийн байранд тоглосон аж. Хоёр дахь удаагаа Нардомын клубт тоглогдох сургаар иргэд баяр наадамд очиж, цам, майдарт мөргөдөг шиг бөөнөөрөө цугларчээ. Жүжгээ цэргийн хүмүүст үнэгүй, энгийн ард иргэдэд нэг

зохиолч” цолыг тус тус хүртсэн нь тус чуулгын алдартнуудын анхдагч болж түүхэнд үлджээ.

ЗХУ-ын Театрын дээд сургууль төгссөн анхны мэргэжлийн найруулагч М.Лувсанжамц 1939-1940 онд Цэргийн театрт найруулагчаар ажиллахдаа Мольерын “Аргагүйн эрхэнд эмч”, Чеховын “Баавгай”, К.Симоновын “Орос хүн” орчуулгын жүжгийг тавьжээ. Тэрээр алдарт “Цогт тайж” киноны Монголын

театр энэ сарын 14-ний өдөр өрхөө татаж үүдээ нээсэн билээ. Театрын нээлтэд БНМАУ-ын Батлан хамгаалах яамны сайд, хурандаа генерал Ж.Ёндон, Ардын Армийн Улс төрийн газрын дарга, дэслэгч генерал Ж.Балжинням, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Батлан хамгаалах яамны нэгдүгээр орлогч сайд, дэслэгч генерал Ш.Жадамба, БНМАУ-ын Соёлын яамны сайд Б.Сумъяа болон Монголын Ардын Армийн удирдах тушаалын

## АЛДАР ГАВЬЯАНЫ ДУУЛАЛ БА ЦЭРГИЙН ЧУУЛГА

Эртний Грекийн философич Платоны гүн ухаантнуудын сургуулийг ийнхүү нэрлэжээ. ОХУ-ын “Большой театр”, “Малый театр”, “Художественный театр” (МХАТ) нь эрдмийн гэх энэхүү эрхэм алдрыг хүртжээ (Театральная Энциклопедия 1961. 104 стр). Тодотговол, жүжигчид нь урлахуйн дээд чадварт мэргэшсэн, урын сан нь дэлхийн түвшинд хүрсэн, өөрийн орны болон дэлхийн сонгодог бүтээлүүдийг тайзнаа тавьдаг их театруудад олгодог хүндэт цол юм. Иймээс энэхүү хүндтэй “Эрдмийн” хэмээх хүндэтгэл цолыг Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн тогтоолоор Бүх Цэргийн Дуу Бүжгийн Чуулгад олгосон бөгөөд өнөөгийн цэргийн чуулгын орой дээр титэмлэн заларсан түүхтэй. Энэ бол асар их хүндэтгэл, өндөр хариуцлага юм.

1921 оны Ардын хувьсгал нь шинэ цагийн театрын урлаг үүсэх үндэс суурийг тавьсан бөгөөд Ардын Засгийн газрын бодлого, шийдвэрийг ард нийтэд сурталчлан таниулах, шинэ соёл, уран сайхны ажлыг эхлүүлэх зорилт тулгарсан байна. Иймд дан ганц аман яриагаар суртал ухуулга хийхээс гадна уран сайхны хэлбэрээр зохион байгуулах нь илүү сонирхолтой, итгэл үнэмшил, үр нөлөөтэй болох тул Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатарын тушаал, Цэргийн яамны Сурган боловсруулах хэлтсээс өгсөн үүргийн дагуу Их даргын сургуулийнхан анхны “Ший янгуу” жүжгийн бүлгэмийг байгуулжээ. Энд жанжин Д.Сүхбаатарын холбогдолтой сонин баримтыг дэлгэхэд, тэрээр 1920 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Иркутск хотод журмын нөхдийн хамт байхдаа Монголын тогтмол хэвлэл болох “Үнэн” сонин анхны дугаарыг хэвлэн гаргажээ. Тэрчлэн 1921 оны 10 дугаар сард Москва хотноо Монголын төлөөлөгчид Зөвлөлтийн засагтай найрамдлын гэрээ байгуулах үеэрээ Оросын нэрт театруудад жүжиг, циркийг үзсэн удаатай. Тус улсын Гадаад хэргийн Ардын комиссаратын газрын ажилтан Л.Берлин дурсамждаа “Монголын төлөөлөгчид Москвагийн “Их театр”-т А.П.Бородин “Игорь ван” дуурь, “Бага театр”-т М.Горькийн “Шаардагдсан хүмүүс” жүжиг бас улсын цирк үзсэн юм. Төлөөлөгчид, ялангуяа Д.Сүхбаатар хүссэн ёсоор циркээс эхлэн Зөвлөлтийн театрын урлагтай танилцсан. Үзэж байгаа зүйлээ Д.Сүхбаатар хичээн шимтэн, сэтгэл хангалуун сонирхож байсныг нь би харж суулаа. Тэрээр сэтгэл нь хөдлөн бахдаж үе үе өндлөж байсан юм” гэжээ.

Монголын театрын анхны тулганы чулууг тавилцагч гавьяат жүжигчин Ёндонгийн Шаравдоо нэгэн цагт “Би багадаа Д.Сүхбаатарын хүү С.Галсантай хамт тоглодог байлаа. Бид байлдах, барилдах зэргээр тоглодог байсан. Д.Сүхбаатар жанжин хааяа бидэн дээр ирж “Чушка” гэдэг орос тоглоомоор хэрхэн тоглохыг зааж өгдөг байсан. Мөн Цэргийн сургууль дээр ший янгуу гарахад биднийг дагуулан явж үзүүлдэг байсан” гэж дурссан байдаг.

Эндээс дүгнэхэд, жанжин Д.Сүхбаатар нь шинэ цагийн театрын урлаг болон үлээвэр хөгжмийн албыг байгуулж, цэргийн спортыг үүсгэн хөгжүүлсэн гавьяатай хүн байжээ. Түүний тушаалаар 1921 оны сүүлчээр Цэргийн яамны Сурган боловсруулах хэлтсээс өгсөн үүргийн дагуу комиссар Н.Насанбат, С.Раднаабазартай хамтран “Гэсэрийн тууж”-аас сэдэвлэн “Гэсэр Богд Ан дулам хааныг дарсан нь” жүжгийг найруулж, Цэргийн сургуулийн жүжгийн бүлгэмийнхэн түүнд тоглосон нь шинэ цагийн хувьсгалт жүжгийн урлагийн эхийг тавьсан тухай Монголын театрын нэрт зүтгэлтэн, театр судлаач С.Дашдондог багш судалгаандаа бичжээ. 1921 оны 10 дугаар сард Д.Сүхбаатар цэргийн газрын дарга нарыг цуглуулан “Та нөхөд ард түмэнд уншуулах, үзүүлэх шинэ уран зохиол, шинэ уран сайхны талаар бүтээл гаргавал их сайн байна. Хувьсгалын үзэл санааг сурталчилсан үндэсний жүжгийн зохиол чухал хэрэгтэй болов” гэжээ. Энэхүү санаа зорилгод нийцсэн жүжгийн зохиол байхгүй учир тухайн цаг үеийн хувьсгалчдын үзэл санаанд “Гэсэрийн тууж” зохиол нийцсэн

мөнгөн төгрөгөөр үзүүлж, олсон орлогоо Цэргийн яамны Сурган боловсруулах хэлтэст оруулж байжээ. Энэ жүжигт гурав, дөрвийн зэрэг хөгжимчид бөгөөд тэр дунд шанз ёочин даргад Монхор Батсүх, Егүүзэрийн Нацаг нар оролцжээ.

1924 оны 11 дүгээр сард Улсын анхдугаар хуралд Цэргийн яамны Сурган боловсруулах хэлтсийн дарга Наваандоржийн Жадамбын тавьсан илтгэлд “Ший янгуу жүжгийг Нийслэл хүрээний ангудад 15 удаа гаргаж нийтэд тоглосон. Энэ нь соёл гэгээрлийн ажлын энэхүү чиглэлийг чухалд үзэж байсны илрэл юм” гэжээ. Ингэснээр тухайн үед Монгол ардын цэргийн дотор намын суртлыг дэлгэрүүлэх тал дээр амжилт олсон ба 1924 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Д.Сүхбаатарын нэрэмжит Цэргийн төв клуб нээгджээ. “Ший жүжиг бүлгэм”-ийнхэн хоёр жүжгийг тоглосон байдаг. Энэ нь “Сумъяа ноён”, “Ушаандар хаан” дуулалт жүжгүүд юм. Бээжин ламд Н.Насанбат, Жуяарт Өлзийханд, Сумъяа ноёнд Ц.Гомбожав нар тогложээ. “Ушаандар хаан” дуулалт жүжгийг зохиолч Д.Нацагдорж “Ушаандар хаан” туужаас сэдэвлэн бичжээ. Цэргийн доторх анхны ший жүжгийн дугуйлан Монголд шинэ цагийн театрын урлаг хөгжих эхлэлийг нь тавьж, үүний эрхэс сайн дурын зохиогчид, тоглогчид нэмэгдэх болсноор энд тэндгүй улаан булан, клуб байгуулагдав.

1932 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Цэргийн доторх намын байгууллагуудын анхдугаар зөвлөгөөнд зориулан нэгдүгээр дивиз, Цэргийн сургуулийнхан анхны концерт тоглосноор эдүгээгийн Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулгын түүх эхэлсэн билээ. 1934 онд Цэргийн төв клубийн дэргэд Цэргийн төв театрыг цөөн хүний орон тоотойгоор зохион байгуулжээ. Ши.Аюуш өгүүлэлдээ “Ардын хувьсгалт цэргийн театр нь шинэ тутам байгуулагдаж, энэ завсар үлэмжхэн бүтээлийг олж, өдий төдий авьяастан мэргэжилтнүүдийг төрүүлж, цэрэг, ардын дунд үндэсний хувьсгалын уран сайхны ажлыг өрнүүлэн өөрийн зорилгыг хангаж, манай соёлын байлдааны нэгэн хүчин зүйл болов” гэжээ.

1934-1940 онд Цэргийн төв театрын тайзнаа А.Санжидын зохиол “Тэнэг Засаг”, “Сохор чавганц”, Ши.Аюуш, Ло.Цэнд-Очир нарын зохиол “Партизан Батхүүгийн зам дээр”, Л.Насанбат зохиол “Өргөмөл Сувд” аялгуут жүжгүүд тогложээ. Энэ үед А.Санжид 22 насандаа Цэргийн театрын анхны даргаар томилогдож, 1926-1930-аад онд Парис хотод зураачийн мэргэжил эзэмшсэн Л.Намсрай найруулагчаар нь ажиллаж байлаа. Ло.Цэнд-Очир нь “Эмээлт морины эзэн ирлээ” алдарт зохиолыг бичиж, Л.Мөрдоржтой хамтран “Залуу жанжин Ж.Лхагвасүрэн”, “Хилээс” зэрэг дууг бичжээ.

1936 онд Ардын хувьсгалын 15 жилийн ойн баяраар Цэргийн театраас 17 настай байлдагч Л.Мөрдорж “Улсын алдарт хөгжимчин”, жүжигчин В.Пунцаг “Улсын алдарт уртын дуучин”, хөгжимчин Ө.Лувсан “Улсын алдарт хөгжимчин, шүлэгч Ши.Аюуш “Улсын алдарт уран

талын найруулагч нь байлаа. Мөн 1950-аад онд Цэргийн театрт жүжигчин байсан алдартнууд буюу “Арслан тайж”-д гавьяат жүжигчин А.Цэрэндэндэв, “Гүен Баатар”-т гавьяат жүжигчин Б.Жигжиддорж, Түвдийн элчид гавьяат жүжигчин Ё.Гомбодорж тоглож, гайхамшигт дүрүүдээ бүтээсэн юм. Харин 1941 оноос Монгол Ардын Хувьсгалт Цэргийн Дуу Танцны Ансамбль болж өөрчлөгдсөн ч жүжиг тоглогдсоор байсан түүх бий.

1945 оны Чөлөөлөх дайнд хошууч М.Хундагаа даргатай Цэргийн ансамблийн 60 гаруй уран бүтээлч, Улаанбаатар хот, Хэнтий, Сүхбаатар аймгийг дайран 2000 километр замыг туулсан ба Их Хянганыг давж, Тэнгэр элсийг гатлан, Өвөр Монголын нутаг Будвал ноёны хошуу, Бандид гэгээний хийд, Зүүн хойд Долоннуур хотод хүрчээ. Улмаар 1945 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр “Дайн дууслаа”, “Бид ялав” гэсэн хоёр баярт мэдээг сонсоод ялалтын баярын концертоо Зөвлөлт-Монголын баатарлаг дайчид, нутгийн иргэдэд толилуулан урлаг, соёлыг түгээн дэлгэрүүлж явсан түүхтэй. Түүнчлэн энэхүү Ардын Армийн Дуу Бүжгийн Ансамбль нь 1955 оноос Ази, Европ тивийн орнуудад өөрийн уран бүтээлийг тоглож сурталчилсан гавьяатай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1962 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн зарлигаар “Ардын цэргийн дайчдыг цэрэг-эх оронч үзлээр хүмүүжүүлэх үйлсэд оруулсан гавьяа шагналыг нь үнэлэн...” Монголын Ардын Цэргийн Дуу Бүжгийн Ансамблийн 30 жилийн ойг тохиолдуулан Байлдааны гавьяаны одонгоор шагнасан.

Ардын Армийн Дуу Бүжгийн Ансамбль байгуулагдсаны 40 жилийн ойг угтаж гавьяат жүжигчин Ё.Цэрэндуламын санаачилгаар тус ансамблийн уран бүтээлчдээс жүжиглэх авьяастай хүмүүсийг сонгон жүжгийн дугуйлагч байгуулж, хошин шогийн үзэгдлийг урлагийн бригадын хөтөлбөрт тоглож эхэлжээ. 1979 оноос ансамбльд миний бие найруулагчаар томилогдсон бөгөөд Д.Наваансүрэнгийн зохиол “Бид дөрөв” үзэгдэлт инээдмийн жүжиг, Ж.Лодойн зохиол “Бүрхэг шөнө” жүжгийг тавьсан юм. Улмаар 1982 онд Ардын театрын цол, мандатыг авсан юм. Мөн 1986 онд Бүх ард түмний урлагийн үзлэгт Э.Оюун, Д.Гармаа нарын “Хэзээ ч мартаггүй” жүжгээр оролцон тэргүүн байр эзэлж, цэрэг-эх орны сэдэвт томоохон жүжгүүд нь тухайн үедээ үзэгч олны талархлыг хүлээж байлаа. Ардын театр нь 10 гаруй жилийн хугацаанд армийн бие бүрэлдэхүүн, залуу үеийнхэнд цэрэг-эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмрийг оруулсан юм. Улмаар 1987 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Армийн Драммын театр хөшгөө нээж, анхны тоглолтоо хийж байсныг “Улаан Од” сонин 1987 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн дугаарт бичин үлдээжээ.

Манай соёл, урлагийн амьдралд бас нэгэн тэмдэглэлт сайхан үйл явдал болсны нэг нь Монголын Ардын Армийн Драммын

генерал, офицерууд, урлаг, соёлын байгууллагын ажилтан, жүжигчид оролцов. Энэхүү театрын анхны тоглолтыг Улс төрийн газрын нэгдүгээр орлогч дарга, хошууч генерал Г.Дугарсүрэн нээж үг хэлэв. Тус театр анхны тоглолтоо “Хэзээ ч мартаггүй” жүжгээр эхлэв. Энэ үеэр жүжигчдийн уран чадварлаг тоглолтыг үзэгчид өндрөөр үнэлж баяр хүргэж байлаа. Цэрэг-эх орны сэдэвт уг жүжгийг тус театрын уран сайхны найруулагч миний бие тайзнаа тавьж, гол дүрүүдийг Д.Батбаяр, Я.Оюунцэцэг, Ц.Энхбаатар, Ш.Батбаяр, С.Болдбаатар зэрэг авьяаслаг жүжигчид бүтээж байлаа.

Ийнхүү “Хөдөлмөрдөд урлагаар үйлчлэх, Ардын Армийн дайчдыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, социалист урлагийг хөгжүүлэх хэрэгт оруулж байгаа хувь нэмрийг нь тэмдэглэж ... ” тус ансамблийн 50 жилийн ойг тохиолдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн зарлигаар Байлдааны гавьяаны улаан тугийн одонг хүртээсэн юм.

2002 онд нийтлэлийнхээ эхэнд дурдсанчлан Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Цэргийн дуу бүжгийн чуулгад “Эрдмийн” хэмээх хүндтэй цолыг хүртээв. Энэ үед тус чуулгын дарга, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хурандаа Ч.Гансүхийн идэвх, зүтгэлээр хөгжимт театрын томоохон жанр С.Тараагийн хөгжим, Д.Ганзоригийн цомнол “Чингис хаан” рок дуурийг 2011 онд, Урлагийн гавьяат зүтгэлтэн Б.Бямбабаярын хөгжим, Соёлын тэргүүний ажилтан, хошууч Р.Өнөржаргалын цомнолоор “Хүннү” дуурь, Урлагийн гавьяат зүтгэлтэн Р.Ганбат, гавьяат жүжигчин Л.Ганчимэг нарын “Нэр төр” бүжгэн жүжгүүд тавигдаж, Цэргийн театрын уламжлалыг баяжуулан театрын урлагийн санд хувь нэмрээ оруулсаар байна.

Сүүлийн жилүүдэд Офицеруудын ордон нь хэн хүний харааг булаасан тохилог агаад соёлтой орчныг бүрдүүлж чаджээ. “Өөдлөх айл үүднээсээ” гэдэгчлэн ЦДБЭЧ-ын дарга, Соёлын төв өргөөний ерөнхий менежер, хурандаа Г.Золзаяа нь тус чуулгын урын санг баяжуулах, уран бүтээлийн хүртээмж, чанар, үр нөлөөг нь дээшлүүлэхэд төдийгүй аж ахуй, тохижилтын ажилд ч ихээхэн санаачилгатай оролцов, өөрийн ур чадвараа зориулан яваад нь ахмад уран бүтээлчид бид туйлын бахархалтай ханддаг.

Тэд Халхын голын байлдааны ялалтын 80, Монгол Улсад эрэгтэй дан найрал дуу үүссэний 60 жил болон Үндэсний найрал хөгжмийн зэрэг түүхт ойнуудыг тэмдэглэж, чуулгын уран санг баяжуулах, уран бүтээлчдийн ур чадварыг нь дээшлүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна. Энэ жил чөлөөлөх дайны 75 жилийн ойд зориулан оны эхнээс “Дайнд оролцсон дайчин чуулга” хөтөлбөрийг хэрэгжүүлж өөрийн тайзнаа “Намар дархалсан ялалт” аялгуут жүжиг, “Ялалтын дууль” баримтат киног бүтээхээр ажиллаж байгаа боловч цар тахлын улмаас түр хойшлоод байна. Тус ансамбль, чуулгын ариун жагсаалаас Төрийн шагналт, Ардын жүжигчин Л.Мөрдорж, Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн Г.Цэрэндорж, Д.Дугарсүрэн, Д.Бадарч, Ц.Сэвжид, К.Хивадалдой, Д.Мяасүрэн, П.Хаянхярваа, төрийн шагналт Ч.Ойдов, Төрийн шагналт, Ардын жүжигчин, Урлагийн гавьяат зүтгэлтэн Ш.Гунаажав, Төрийн шагналт, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн П.Бадарч, Ардын жүжигчин Ө.Баярмагнай нарын 80 гаруй ардын болон гавьяат цолтнууд, алдартнууд төрсөн юм.

Хоёрхон жилийн дараа эрдмийн чуулга маань 90 жилийн ойтойгоо золгоно. Их ойгоо угтаж алдартан, гавьяатнуудаа сурталчилсан баримтат кино бүтээх, чуулгын дурсгалын музейг байгуулахаар төлөвлөдөг байгаад талархал илэрхийлье.

Монгол цэргийн суу алдар мандан бадарч, их цэнгэл, дуу хуур мөнх тэнгэрт ивээгдэж байг.

ЦДБЭЧ-ын ахмад ажилтан, чөлөөнд буй хошууч С.БОЛД



1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчид. Баруун гар талаас: Гавьяат жүжигчин В.Гомбо, Ё.Цэрэндулам, М.Дорж, Г.Дамбийжанцан, Урлагийн гавьяат зүтгэлтэн Ш.Гунаажав, Д.Дэлэжням

# Ч.Долгорсүрэн: ОФИЦЕР, АХЛАГЧ НАРЫНХАА ТӨЛӨӨ ИХ ЗҮТГЭСЭН ДЭЭ, ХАНЬ МИНЬ

**ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч, Улаанбаатар цэргийн хүрээний дарга агсан, хошууч генерал Цэрэнгийн Галсангийн тухай нөхөд нь "Шулуун шударга, хэлсэн ярьсандаа эзэн болдог, үлгэр авахаар сайн дарга байсан" гэж ярилцахыг нь олон удаа сонсож байсан. Түүнийг эргэн дурсаж генералын хань, чөлөөнд байгаа ахмад Ч.ДОЛГОРСҮРЭН гуайтай уулзаж ярилцлаа.**

## Таны уугуул нутаг усны тухай асуултаар ярилцлагаа эхэлье...

-Би 1944 оны 2 дугаар сарын 16-ны өдөр Төв аймгийн Баяндэлгэр суманд төрсөн. 1954-1958 онд Төв аймгийн Эрдэнэ сумын бага сургуульд, 1958-1961 онд Улаанбаатар хотын 16 дугаар дунд сургуульд, 1961-1965 онд Анагаах ухааны дунд сургуульд суралцан бага эмчийн мэргэжил эзэмшсэн. Сургуулиа төгсөөд Батлан хамгаалах яаманд 1965 оны 8 дугаар сард Мотобуудлагын нэгдүгээр бригадэд лазаретын бага эмчээр /энгийн/ томилгогдсон. Энэ үед Эмнэлгийн албаны дарга, хурандаа Дашням, лазаретын дарга, ахлах дэслэгч Ч.Туяа, эмч нар нь ахлах дэслэгч Навчаа, Жаргал, Бямбаа, аптекийн дарга Дашмагван, лаборант Дашзэвэг нарын бүрэлдэхүүнтэй, туршлагатай хамт олон хүлээн авч билээ. Энэ л буянтай хүмүүс ёсолж хүндлэх, алхаж гишгэхээс эхлээд цэргийн хэргийн анхан шатны мэдлэгт сургахаас гадна өдөр тутмын хийх ажлыг минь зааж сургаж эхэлсэн цэргийн хүн болсон.

## Ирээдүйн генералтай хэрхэн танилцаж байв?

-Анги, салбаруудын хэмжээнд зохиогдог хурал, зөвлөгөөн, улс төр, хүмүүжлийн ажил, уулзалт, үдэшлэг зэрэг нэгдсэн ажиллагаанд дарга, офицерууд цэргүүдэд командлаад оролцоно. Тэр бүгдэд Эмнэлгийн албаны дарга маань эмч, ажилтнуудаа дагуулаад орно. Мөн урьдчилан сэргийлэх үзлэг, тарилга хийх үеэр салааны дарга, бага дэслэгч Галсан гэдэг өндөр бор залууг зүс таних болсон. Офицеруудын алаг байранд хамт амьдарч байсан найз Намсрай нь захиа зөөх, намайг ажилтай үед гэрт очоод манай ээжид "Эмч хэзээ ирэх вэ, эмчид хүүхэд үзүүлэх гэсэн юм" гэж худлаа хэлдэг байжээ. Ээж танай хүүхэд яагаад байдаг юм бэ, өөр эмчид үзүүлэх гэж аашлах зэрэг хөгтэй явдлууд тохиолдож байлаа. Ингэж ойртон дотно танилцаар 1966 оны 6 дугаар сард Галсангаа салааны дарга байхад нь ханилан сууж 30 гаруй жил жаргал, зовлонгоо хуваалцан бага дэслэгчээс хошууч генерал, салааны даргаас ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, Улаанбаатар гарнизоны захирагчийн албан тушаалд дэвшин улс, армид үр бүтээлтэй ажиллаж, амьдрахад нь түшиг болж явлаа.

## Залуу офицер байх үеийнх нь сонин дурсамжаас хуваалцана уу?

-1966 оны 5 дугаар сард нөхөр маань салааныхаа цэргүүдтэй хамт армийн идэвхийн малыг Архангай аймгийн Өгийнуур сумаас тууварласан. Тарга хүчийг нь нэмэгдүүлэн тоо бүрэн 11 дүгээр сарын сүүлчээр Улиастай голын

эхэнд ирж "бой" хийн бригадын өвлийн идхийг бэлтгэснээр өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлж байсан. Олон сар мал тууврын ажилд явж ирсний дараа нэг амралтын өдөр бид хоёр кино үзэхээр Багшийн дээд сургуулийн урдуур юм ярьж яваад зөрж өнгөрсөн нэгэн офицерыг анзаарсангүй. Тэгтэл тэрээр "Хоёр бага дэслэгч над руу" гэж дуудаад "Цэргийн дүрэм зөрсөн, ахлах даргад ёсолж хүндэлсэнгүй" гээд цэргийн комендатад хүргэлээ. Нөхөр маань журамлагдсан цэргүүдээр жагсаалын бэлтгэл хийлгэж, би "Цэргийн дүрэм" уншиж байгаад явж билээ. Тэр хүн нь тухайн үеийн цэргийн комендатын хэв журам сахиулах ротын дарга "бөхөөн" Бат-Очир гэдэг хүн байсан юм билээ. Энэ мэт сонин тохиолдлууд олон бий.

## Цэргийн том дарга болох тусмаа гэрийн бараа тоотойхон харж байсан биз?

-Бага насандаа аав, ээжээсээ өнчрөн хоцорсон болохоор ээж маань хүргэнээ их хайрладаг, нөхөр маань ч ээжийг их хүндэлдэг байсан. Салаа, ротын дарга байх үеэс нь өглөө эрт цэргийн бослогод явах, оройтож ирэхэд нь намайг босож цай, хоолыг нь халуун өгч бай гэж сургана. Энэ хугацаанд хоёулаа зав чөлөө багатай, хээрийн сургуульд оролцох, хол ойрын томилот, гадагшаа дотогшоо урт, богино хугацааны сургууль, цугларалтад оролцох зэрэгт ар гэрийг маань харж, хүүхдүүдийг минь өсгөж хүмүүжүүлэхэд ээж маань их тус дэм болж байсан.

## Ц.Галсан генералын ажил, амьдралдаа баримталдаг зарчим юу байв?

-Өнөө маргаашийн амин хувийн ашиг хожоо харалгүй улс, армийнхаа хөгжил дэвшил, цэргийн сургалт бэлтгэлийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэсэн гэж боддог. "Санаа зөв бол заяа зөв" гэсэн үзлийг баримталж өөрийн ухамсарт амьдралынхаа 30 гаруй жилийг цэргийн сургалт бэлтгэлийн төлөө зориулаад 1992 онд цэргийн тэтгэвэрт гарсан.

## Сургууль төгссөн залуухан эмч цэргийн ангид ажиллаж эхлэхэд бүх зүйл сонин содон байсан уу?

-Тэгэлгүй яах вэ, бригадын лазаретад ажиллаж байгаад 1966 оны 6 дугаар сард бага дэслэгч цол хүртэж шинээр зохион байгуулагдсан Ардын Армийн 108 дугаар анхны аптекийн дарга, бага эмчээр томилогдсон. Энэ үед анги маань Улиастайн голын зүүн эрэгт хээрийн байрлалд ангийн штаб болон эмнэлэг нь гэрт, цэргүүд асарт байрлаж, чулуугаар "гортик" татсан. Туг, дарцаг хатгаж, явган хүн явах зам, гарц хаалга гаргасан байв. Дарга, цэрэггүй бүгд тэрхүү замаар л явах бөгөөд өдөр тутмын бүхий л

үйл ажиллагаа нь нарийн дэг журам, цагийн хуваарь, бүрэн дуугаар явагддаг нь их л сонин санагддаг байж билээ.

## Ангийн эмнэлэг гэж...


-Ганц модон ор, эмийн шүүгээ, нэг ширээ, хоёр модон сандал, ийм л эд хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаагаа эхлүүлж билээ. Ингээд цэрэг дайчдад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, эмчилгээнд шаардагдах эм, ороох, боох материалынхаа захиалгыг бичээд албаны дарга, хурандаа Дашням дээр ороход захиалгыг маань нэг бүрчлэн уншиж үзээд "Иймхэн юмаар юу хийх хүн бэ, хоёрхон цэргийн холгосон хөл боож, хатгинд нь наагаад л дуусах юм байна" гэнэ. Арай ахиухан захиалга аваад орвол "Энэ их юмаар яах нь вэ?, мал бордох гээ юу" гээд л хасаад хаячихна. Энэ мэтдээ дүгнэлт хийгээд ахин дахин хянаад захиалгаа бичиж нэлээд эм, ороох, боох материалын нөөцтэй болоод үйл ажиллагаагаа хэвийн явуулж ажилдаа дасаж байтал усны үерт анги маань автас.

## 1966 оны үерээр үү?

-Тийм, тэр үерээр Эмнэлгийн гэр маань байрнаасаа нэлээн урсаад хойшоо хараад үлдсэн боловч гэрийн шал, эд хогшил урссан, анги маань эд материалын ихээхэн хохирол үзсэнийг хараад их айж бас харамсаж билээ. Дарга, захирагч нар маань "Цэргийн эмч хүн бол зөвхөн өвдөөд ирсэн дайчдад эмнэлгийн тусламж үзүүлэхээс гадна урьдчилан сэргийлэх тал дээр анхаарч ажиллах ёстой, цэрэг бүхэн байна, тэнд л байх ёстой, хэвийн л үйл ажиллагаанд оролц" гэнэ. Ингээд л хээрийн сургууль, буудлага хийх үед, цэрэг усанд орсон ч "бюкс"-ээ үүрээд л дагаж явж үзлэг, хяналт хийх, шаардлагатай тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэх зэргээр ажиллаж байсан. Тэр үеийн ангуудын эмч нар зарим тохиолдолд салааны дарга шиг өглөө цэрэг босох үед ирж, цэргийн байранд ариутгал, агааржуулалт хийнэ, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлж ажилладаг байлаа.

## Хүнд амаргүй үе тохиолдож байв уу?

-1966 оны 7 дугаар сарын 13-ны өдөр лазаретын жижүүрээр томилогдсон. Долоодугаар сарын 11, 12-ны өдөр үргэлжлэн орсон их борооны улмаас Улиастайн гүүр нурж олон хүний амь нас үрэгдэж аюул болсон юм. Жижүүрт томилогдоод лазарет руу очиж үүргээ гүйцэтгэж байтал үерт амь үрэгдсэн танкийн хорооны ахмад Р-ийн шарилыг авчирч цэвэрлэгээ, ариутгал хийх, нүүр амьг нь янзлан оршуулахад бэлдэх үүрэг өгөгдсөн. Энэ үед бригадын эмнэлэг маань Улиастайн голын эрэг дээр хээрийн байрлалд



асарт байрлаж байсан. Үерийн улмаас цахилгаангүй болсон асарт лааны сүүмгэр гэрэлд нөгөө шариллаа цэвэрлэн ариутгах үед гадаа бороо орж салхи сэвэлзэн асар маань үе үе салхинд дэрвээд аймшигтай байж билээ. Гэсэн ч хос тангарагтай цэргийн хүний хувьд өгөгдсөн үүргийг биелүүлсэн.

## Генерал маань тэтгэвэрт гараад ЗХЖШ-ын Ахмадын хорооны дарга, Бүх цэргийн офицер, ахлагч нарын эрх ашгийг хамгаалах холбооны тэргүүлэгчээр ажиллаж байхдаа юунд гол анхаарлаа хандуулж байсан бол?

-Өвгөн маань 1992 онд цэргийн тэтгэвэрт гарсан. Удалгүй ЗХЖШ-ын Ахмадын хорооны даргаар томилогдож бас Бүх цэргийн офицер, ахлагч нарын эрх ашгийг хамгаалах холбооны тэргүүлэгчээр ажиллаж эхлэв. Энэ үеэс нийгмийн шилжилтийн үеийн төрийн бодлогын золиос болж наснаасаа эрт цэргийн тэтгэвэрт гарч, бага тэтгэвэр тогтоолгосон офицер, ахлагч нарын нийгмийн баталгаа болсон тэтгэврийг нь нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч тухайн үеийн Ерөнхийлөгч, БХЯ-ны сайд, УИХ-ын гишүүд зэрэг албаны хүмүүстэй уулзаж яриа хэлцэл хийх зэргээр ажилласан. Миний хувьд гэхэд л, 1989 онд цэргийн тэтгэвэр тогтоолгохдоо тухайн үеийн ханшаар 446 төгрөгийн тэтгэвэр тогтоолгосон нь тэр үедээ л өндөр тэтгэвэр байсан. Тэтгэвэр бага багаар нэмэгдсээр 2007 он гэхэд л 100 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг болоход барааны үнэ ханш ч бас нэмэгдсээр л байсан. Ингээд бодоход цэргийн тэтгэвэр ямаршуухан байсан нь ойлгомжтой байгаа биз дээ. Энд зөвхөн Зэвсэгт хүчнээс цэргийн тэтгэвэрт гарсан ахмадууд биш, Хилийн ба Дотоодын цэрэг, Цагдаа гэх зэрэг мөрдөстэй бүхэн хамаардаг шүү дээ. Ингээд нөхрийн маань уйгагүй хөөцөлдсөн

ажлын үрээр 2008 онд цэргийн тэтгэврийн зөрүү болгож нэг сая төгрөгийн тэтгэмжийг олгож байсан. ЗХЖШ-ын Ахмадын хорооны даргаар ажиллаж байх үедээ мөн л ахмадуудынхаа нийгмийн баталгаанд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байсан. Ахмадын хороог өөрийн гэсэн туслах аж ахуйтай болох суурийг нь тавьж Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумаас буюу Зэвсэгт хүчний 232 дугаар ангиас хонь, үхрийг данснаас дансанд шилжүүлэн авч малаа тууж ирсэн. Мөн анги, байгууллага нь татан буугдаад харьяалалгүй болсон ахмадуудыг Зэвсэгт хүчний Жанжин штабын Ахмадын хороонд харьяалуулах, Цагаан сараар 60, 70, 80 нас хүрсэн ахмадууддаа насных нь тоотой тэнцүү мөнгөн урамшуулал өгөх зэрэг ажлыг санаачлан эхлүүлж байсан даа...

## Аавынхаа мэргэжлийг өвлөсөн хүүхэд байгаа юу?

-Яг ч аавынхаа мэргэжлийг өвлөөгүй ч цэрэг армитай ажил, амьдралаа холбосон. Том охин маань Цэргийн оёдлын үйлдвэрт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан. Бага хүү маань энгийн сургууль төгсөж, хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байгаад одоо Зэвсэгт хүчинд ажиллаж байна.

## Сониноор дамжуулан уламжлал санал хүсэлт байна уу?

-Бид хоёр цэрэг армитай амьдралаа холбож 30 гаруй жил ажиллаад зуслангийн байшин ч үгүй хориогоос буцсан даа, өвгөн минь. Сонин хэвлэлээс харж сонсож суухад генералуудад хаус, зуслангийн газар өглөө гэж сонсогддог. Тэр хаус, зуслангийн газар нь болдоггүй юм бол алгын чинээ газар, зуслангийн байшингаар тусалбал хэдэн ач, зээгээ аваад агаар салхинд гарч байвал зүгээр юм даа. Ийм л зүйл хүсье дээ.

## Танд урт нас, удаан жаргалыг хүсэн өрөө!

# ХЭВЛЭГЧ, ХЯНАГЧ О.ТУЯА

Цэргийн хэвлэлийн "Шувуун саарал" компанийн ахмад ажилтан Очирын Туяа гуайг энэ дугаарт онцолъё. Тэрээр Данзангийн Ганжууржав гэх Увс аймгийн Баруунтуруун нутгийн хүний хүүхэд болж төрсөн ч амьдралын хувь тавилангаар ээжийнхээ эгчийнд буюу Очирын хэмээх айлд үрчлэгджээ. Ц.Очир гэж Ардын хувьсгалын партизан, 1939, 1945 оны дайнд оролцогч, Монголын анхны нисгэгч, анхны шүхэрчин зэрэг алдар цуутай хүн байсан юм билээ.

О.Туяа 1964 онд МУИС-ийн Сэтгүүл зүйн ангийг төгсөөд нийслэлийн Сүхбаатарын районы Хувьсгалт залуучуудын эвлэлийн хороонд томилогдов. Залуучуудын байгууллага түүний залуу насны ид хав, эрч хүчийг ирлэж өгсөн нь лавтай. Дараа нь Сангийн яамны архивт хэсэг ажиллажээ. Ингээд 1974 онд ээжийнхээ ажил мэргэжлийг өвлөн Цэргийн хэвлэх үйлдвэрт орж ажиллажээ. Үйлдвэрийн дарга нь хэвлэлийн туршлагатай ажилтан Банзрагч гуай. О.Туяа энд хянагчаар 21 жил ажилласан байна. Хэвлэж буй бүхий л зүйлийг эхтэй нь тулгаж, үг, үсгийн алдааг нэг бүрчлэн хянана гэдэг нь онцгой хариуцлагатай ажил. Түүнийг анх ажилд ороход Цэрэнпагам, Цэржорлоо гэх хянагч нар ажиллаж байсан. Доржийн нуцттай холбоотой материал цөөнгүй орж ирнэ. Ийм ном, товхимлыг голдуу шөнийн



ээлжээр хянадаг байжээ. Үсэг өрж эх бэлтгэдэг байсан үед тугалган дарцаг гэж их хүнд бэлдэж байх. Унагаж асгавал дахиж өрөхөөс өөр арга байхгүй.

Үсгийн алдаа, оргодол цэрэг хоёр адилхан гэж хэвлэлийн хуучуул ярьдаг нь санамсаргүй зүйрлэл биш. Зүгээр ч нэг алдаа хайгаад байхгүй, номын утгыг нь зөв ойлгож унших шаардлага тулгарна. Зарим утгад засвар хийнэ. Зохиогч ирж үзээд ингэж зассан нь зөв юм байна гээд хянагч

нарт талархсан удаа цөөнгүй. Монгол бичиг, орос хэл, томъёоны номуудыг нягтлах их хэцүү байсан гэж О.Туяа өгүүлсэн.

Тэрээр Өрөх цөхөд харьяалагдана. Линтивийн мастер Пэрэнлэйням, гар өрөхийн мастер Цэндсүрэн, сүүлд Загал мастерын удирдлагад ажиллаж иржээ. Түүнтэй хамт ажиллаж байснаас Сайнаа, Уртнасан, Амарсайхан, Оюунбилэг байна. Олон сайхан нөхөд минь бурхны оронд явжээ гэж тэрээр харуусаж сууна лээ.

Өрөгч нар хоёр ээлжээр ажилладаг. Яаралтай номыг өрсний дараа хянагч нарын ажил эхэлнэ. Шөнөжин ном хянаад өглөө харьж байсан удаа олон. Сард дунджаар 4 ном гараас гаргадаг гээд бодоход 21 жилийн хугацаанд олон ном уншигчдын гар дээр очжээ.

Одоогийн зарим нэг ном, сонин уншихад алдаа их болж дээ. Зурагт үзэж суугаад шүүмжилнэ. Зөв бичгийн дүрэм өөр болсон байх, гэхдээ л алдаа их харагддаг. Үг таслах дүрэм их алдагдаж байна. Манай хүүхдүүд ч бас "Ном хэвлэлүүд ямар их алдаатай гардаг юм бэ" гэж хэлдэг юм. Би ажиллаж байхдаа хуваарьтай зарим номоо гэртээ авчирч унших тохиолдол гарна. Хүүхдүүд хувааж аваад үг, үсгийг нь цуг хянаад явчихна. "Ээж ээ үүнийг ингэж бичсэн байна" гээд үзүүлнэ. Би үзээд алдаа байвал зохих тэмдэглэгээ нь хийдэг байв.

Үүний ачаар хүүхдүүд маань алдаагүй, зөв бичдэг болсон шүү гэв.

Түүний хань Сандагийн Намжилцэрэн 17 настайгаасаа эхлэн НАХЯ-нд ажилласан офицер хүн байжээ. Хоёулаа ажил ихтэй, цаг, зав муутай байсан учир томд нь дүү нарыг хариуцуулаад явна. Тэднийх 6 хүүхэдтэй. Аав, ээжийнхээ хөдөлмөрч уламжлалыг нь өвлөж их сургуулийн багш, яамны хэвлэлийн төлөөлөгч, хэвлэлийн газрын эзэн, барилгачин, архитектор болж, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулж явна.

О.Туяа 1995 онд гавьяаныхаа амралтад гарсан. "Шувуун саарал"-ынхан өнөөдөр ч нэг зорилго, нэгдмэл санаатай хэвээр. БХЯ-ны Ахмадын хорооны харьяанд очсон нь туйлын баяртай үйл явдал болжээ. О.Оюунбат Ахмадын хорооны тэргүүлэгчээр ажиллаж цэргийн хэвлэлийн ахмадуудаа сайн харж ханддаг юм. Ахмадын өдөр, Сар шинийн баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлнэ. Өнгөрсөн жил Цэргийн худалдааны ахмадуудтай нийлж Шинэ жилийн баяраа тэмдэглэжээ. О.Туяа гуай Баянгол дүүргийн 14 дүгээр хороонд намын гишүүн 200 гаруй ахмадын даргын сонгуультай. "Ахмадын чөлөөт цагийн байрандаа хөзөр, шатар тоглоод бужигнаж гардаг хүмүүс дээ, бид" хэмээн яриагаа өндөрлөв.

# АЛДАРШИЖ АМЖААГҮЙ "БААТАР"-УУД

Эх орны дайны үед төрийн дээд шагнал болох Зөвлөлт Холбоот Улсын баатар цолыг Улаан Армийн офицер, ахлагч, түрүүч, байлдагч зэрэг 11657 хүнд олгожээ. Үүнээс 3051 хүнд нь нэхэн олгосон байна. Ялалт зөвхөн хуурай газарт байгаагүй ба агаарт, тэнгист, ар талд хүртэл байлаа. Хүмүүсийн тэр бүр мэдээд байдаггүй, алдаршиж амжаагүй баатруудын гавьяат үйлс түүхийн шаргал хуудаснаа бичигдэн үлдсэн ч дурсагдахгүй байсаар байна.

## ТАНКЧИН



Гвардын ахмад Владимир Бочковскийн "Т-34" танк одоо ОХУ-ын Москва хот дахь Ялалтын цэцэрлэгт хүрээлэнд бий

Гвардын ахмад Владимир Бочковский бол танкын тулалдааны "хөзрийн тамга" гэгдэж байв. Ахмад Бочковский нь дайсны 36 нэгж хуягт техникийг устгасны зэрэгцээ дөрвөн удаа хүнд шархдаж, таван удаа танктайгаа шатаж байжээ. 1944 оны 3 дугаар сарын 21-ний өдөр болсон тулалдаанд ахмад Бочковскийгоор удирдуулсан 1 дүгээр гвардын танкын батальон дайсны 20 их буу, 200 гаруй машин, техникийг "овоолсон төмөр" болгосон

нь үлгэр мэт яригдаж байлаа. Маргааш нь буюу 22-ны өдөр германчууд сөрөг довтолгоо хийсэн боловч мөн л маш их хохирлыг амсжээ. Тухайлбал, гурван танк, таван миномёт, 50 гаруй хуягт техникээ жагсаалаасаа алдсан аж. Энэхүү тулалдаанд танкын батальоноо амжилттай удирдаж өмнөө тавьсан байлдааны даалгавраа биелүүлж, гарамгай амжилт гарган эр зоригоо батлан харуулсан тул гвардын ахмад Владимир Бочковскийг ЗХУ-ын баатар цолоор

шагнасан түүхтэй.

1945 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр болсон Висла-Одерын давшилтын үеэр нацистуудын "Барс" танкаар хамгаалуулсан төмөр замын гармыг Бочковскийн танкын батальон сэтлэх даалгаврыг хүлээж авсан юм. Тэрээр "Т-34" танкаар "биелэгдэшгүй" даалгаврыг биелүүлж ЗХУ-ын баатар цолоор дахин шагнуулсан. Гэвч хожмоо тухайн шагналыг нь Суворовын гуравдугаар зэргийн одонгоор сольсон байдаг.

## ИХ БУУЧИН

Ахлах түрүүч Геннадий Барыков дайны эхний жилүүдэд Курскийн чиглэлд тулалдаж байсан мотобуудлагын хороонд алба хааж байгаад 1941 оны 12 дугаар сард хүнд шархдаж 2 жил гаруй хугацаанд эмнэлэгт хэвтсэн байна. Тэрээр 1943 оны 7 дугаар сард жагсаалдаа буцаж ирсэн бөгөөд 753 дугаар явган цэргийн хорооны 76 м-ийн их бууны батареины даргаар томилогдсон юм. Түүний удирдсан их бууны батареин нь Зүүн Герман, Барыковог чөлөөлөх тулалдаануудад амжилттай оролцсон ба Кенигсбергийн тулалдаанд бусад батареинуудаасаа илт илүү байжээ. 1945 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр Варген тосгоны дэргэд болсон тулалдаанд ахлах түрүүч Геннадийгийн

удирдаж байсан тоот дайсны гурван зенитийн зэвсэглэл, таван пулемёт, 20 гаруй амьд хүчийг устгасан аж. Маргааш өдөр нь германчуудын хийсэн танкын сөрөг довтолгооны эсрэг тулалдсан бөгөөд нэг тоотынх нь наводчик хүндээр шархадсан тул ахлах түрүүч өөрөө үүргийг нь давхар биелүүлж хоёр танк, дөрвөн их буг өөрийн галаар устгасан байна. Түүний тоотын галт хэрэглэл дуусахад батареинга удирдан, гардан тулалдаан хийн ялалт байгуулжээ. Дээрх тулалдаанд батареинга амжилттай удирдаж, сүүлийн сумаа дуустал тулалдан, сүм нь дуусах үед гардан тулалдаан хийж ялалт байгуулсныг нь үнэлж 1945 оны 6 дугаар сард ахлах түрүүч Геннадий Барыковог ЗХУ-ын баатар цолоор шагнажээ.

## ЯВГАН ЦЭРЭГ

Гвардын ахлах дэслэгч Михаил Кузнецов дайны эхний өдрүүдээс эхлэн хүнд нөхцөлд тулалдаж байв. Тэр бээр Брест цайзын бүслэлтийг хэдэн цэргийн хамт сэтлэн гарсан нь "гайхамшиг" гэлтэй. Учир нь тус цайзыг германчууд хэдэн давхар бүслэлт хийн өдөр, шөнөгүй галаар бөмбөгөж байсан юм.

Ахлах дэслэгч Кузнецовыг 1941 оны 8 дугаар сараас Баруун фронтын 537 дугаар явган цэргийн хорооны миномётын батареины улс төрийн удирдагчаар томилсон бөгөөд гурван сарын дараа 622 дугаар явган цэргийн хорооны хамтаар баруун өмнөд фронт руу шилжүүлжээ. Тэнд Кузнецов өөрийгөө чадварлаг тагнуулч гэдгээ харуулсан ба маш олон удаа дайсны ар талд гарч хорлон сүйтгэх ажиллагааг зохион байгуулж, амьд хэл олзлон ирсэн аж. 1941 оны 12 дугаар сард ахлах дэслэгч Михаил Кузнецовыг тушаал дэвшүүлэн автоматын ротын захирагчаар томилсон.

Түүний рот 1942 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Средне-Царицинскийн тулалдааны үеэр дайсанд мэдэгдэлгүй тойрон явж Германы их бууны батальоны яг хажуу талаас довтлон 15 минутын дотор нийт бие бүрэлдэхүүнийг нь устгасны зэрэгцээ батальоны захирагчийг нь штабын баримт бичгийн хамт олзолсон байна. Мөн тус тулалдаанаас 43 их буу, 27 хөнгөн пулемёт, дөрвөн миномёт, долоон автомашин, 292 агт хүлгийг олзолсон юм. Энэхүү тулалдааны үеэр Кузнецовын рот нэг ч хүний хохирол амсаагүй бөгөөд түүнийг 1943 оны 2 дугаар сард ЗХУ-ын баатар цолоор шагнасан юм. Баатар цолоор шагнуулах тодорхойлолтод "Удирдсан рот нь амжилттай тулалдсаны зэрэгцээ ахлах дэслэгч Михаил Кузнецов өөрөө нацистын 88 офицерыг устгаж, дайсны ар талаас 64 амьд хэлийг олзолсон болно. Мөн тулалдааны үед таван удаа хүнд, хөнгөн шархадсан" хэмээн бичжээ.

## НИСГЭГЧ



ЗХУ-ын Нисэх хүчний хамгийн шилдэг сөнөөгч онгоц "Ил-2"

Ахмад Анатолий Недбайлогийг ЗХУ-ын Нисэх хүчний хамгийн шилдэг сөнөөгч онгоцны нисгэгч гэж үздэг байв. Тэр бээр "Ил-2" загварын сөнөөгч онгоцоор 220 удаагийн байлдааны нислэгийг амжилттай гүйцэтгэсэн аж. Түүний байлдааны талбар дээр устгасан техник хэрэгсэл, хүн хүч, объектуудын тоог гаргах боломжгүй гэдэг. Учир нь Дэлхийн хоёрдугаар дайны үед явагдсан томоохон тулалдаанууд болох Миусской, Донбасс, Мелитополь, Никополь-Кривой Рог, Крым, Витебской-Оршанской, Минск, Вильнюс, Каунас, Мемель, Зүүн Герман, Конигсбергийн зэрэг тулалдаанд оролцжээ.

Дайны төгсгөл үед түүний онгоцыг дайснууд гурван удаа оносон байна. Онгоц нь удирдлагагүй болсон ч азаар дэлбэрсэнгүй, газардуулж чаджээ. Түүнийг онгоцондоо ухаангүй байх үед Улаан армийн цэргүүд онгоцноос нь гаргасан бөгөөд хэдхэн секундид дараа шатахуун нь асаж онгоц нь бүхэлдээ шатсан аж. Ахмад Анатолий Недбайлогт 1945 оны 4 болон 6 дугаар сард байлдааны талбарт гаргасан амжилтыг нь үнэлж ЗХУ-ын баатар цол олгосон юм.

## УСАН ЦЭРЭГ



Баруун гар талаас дэслэгч Валентин Стариков

Дэслэгч Валентин Стариков Хойд флотын "М-171" загварын шумбагч онгоцны ахмадаар үүрэг гүйцэтгэсэн. Түүний удирдсан шумбагч онгоцны багийнхан 23 удаагийн байлдаанд оролцож, дайсны 13 хөлөг онгоцыг устгажээ. Тодруулбал, тээвэрлэх зориулалтай хөлөг онгоц 7 нэгж, шумбагч онгоц 2 нэгж, мина тээгч 2 хөлөг онгоцыг бүрэн устгасан байна.

Дэслэгч Стариковын удирдсан шумбагч онгоцны багийг "Малютка" буюу "Хүүхэд" хэмээн хочилдог байв. "Хүүхэд"-үүд усан доорх тулалдааны үед хэний ч төсөөлөмгүй байлдааны маневруудыг хийж, шумбагч байтугай завь явахад аюултай газруудад шумбалт хийж, усны

гүйн бөмбөгүүдийг амжилттай тойрон гарч байжээ. Тухайлбал, 1941 оны 10 дугаар сарын 2-ны өдөр дайсны хоёр шумбагч онгоцыг мэдэгдэлгүй даган явж түүшц боомт болох Линахамари руу нэвтрэн орж ихээхэн хэмжээний хохирлыг үзүүлсний зэрэгцээ өөрсдөө амжилттай зугтсан түүхтэй.

Эх орны дайн эхлээд удаагүй байхад буюу 1942 он гэхэд "М-171" дүгээр шумбагч онгоцны баг аль хэдийнээ дайсны долоон хөлөг онгоцыг устгачихсан "Гварды" хэмээх тодотголтой болсон бол шумбагч онгоцны ахмад, дэслэгч Валентин Стариков ЗХУ-ын баатар цол хүртсэн байна.

Ахмад Э.ОЧХҮҮ

## Бурууд нүд хурц

Шинэ цэрэг хувьсгалын өлгий нутаг Алтанбулаг дахь музейг үзэж явахад минь тус музейн тайлбарлагч яриагаа таслан бидний цэрэг шинелийн энгэр лүү цоо ширтээд "Хүүхдүүд ээ цэргийн шинелийн энэ "соёмбо" буруу харчихсан бас өнгө алдчихсан байна. Цэргийн та нар их хувьтай хүмүүс төрийн бэлгэдлээ хайрлан хамгаалж өөд нь татаж явах ёстой шүү дээ гээд нэгний маань доош харсан "соёмбо" тэмдгийг дээш нь харуулж байж билээ. Үнэндээ бол Төрийн далбааг уруу нь харуулсантай ялгаа нь юу байх вэ дээ.

Цэргийн алба хаасан он жилүүдэд байтугай одоо ч энэ үг ямагт санагдаж цэргийн хувцсаа дүрмийн дагуу өмсөх юм сан гэх сэтгэгдлийг бас хэвшлийг суулгаж бусдаас музейн тайлбарлагч адил шаардмаар санагдаж байсан нь олонтоо.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас бүх нийтээрээ хөл хориотой байх энэ өдрүүдэд зурагтын нэвтрүүлгийг үзэж суух нь ээ, "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм" гэж байхаа больсон юм биш байгаадаа гэх эргэлзээ төрөөд бас бухимдаж дархлаагаа унагаж суулаа. Тайван амгалан цагт цэргийн дүрэмт хувцсыг дарга сэтэртэй болгон ялангуяа хээрийн эрэн хувцсыг санаснаараа сольж хольж өмсөн гангарах нь бараг нийтлэг болжээ. Цэргийнхэнд олдохгүй шахуу карауль малгайг тэд духдуулсан шиг бас гангарна. Дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэнэ гэдэг шиг.

Харин Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед нөгөө тайван цагийн гангараа бас л ёс бусаар үргэлжлэв. Тухайлбал, Дарханд ажилласан

## ЦЭРГИЙН ХУВЦСЫГ ӨМСӨӨЛ ДҮРМЭЭР НЬ ӨМС, ҮГҮЙ БОЛ ...

Засгийн газрын төлөөлөгч цэргийн хээрийн хувцас өмсөөд мөрдөс дээрээ алтан саатай соёмбо хатгуулсан бол, Дарханы Засаг дарга бас л цэргийн эрэн хувцас өмсжээ. Сэлэнгийн Засаг дарга хар сүлд бүхий ханцуйн тэмдэгтэй цэргийнхний хээрийн хувцас, Дархан сумын Засаг дарга энгэрийн баруун талдаа "Scot" гэсэн гадаад нэртэй, зүүн талын энгэртээ "U.S.ARMY" гэсэн цөлийн хээрийн эрэн хувцас хаанаас ч юм олоод өмсчихсөн олон нийтийн телевизээр хэв нэг яриад сууж байх юм. Бас Дарханы сурвалжлагч гэх бүсгүй өвлийн урт хар куртикан дээр зуны хээрийн цэргийн хувцасны эрэн саравчтай малгай тавьчихсан Эрүүл мэндийн газрын эмчээс ярилцлага авч харагдав. Нийслэлийн Засаг дарга тусгайгийнхны хар хувцсыг өмсчихсөн ордон дотор захаа босгоод сууж байх юм. Бас Нийслэлийн Засаг даргын ажлын албаны дарга "Онцгой"-гийнхны цагаан саарал эрэн хувцсыг хурандаа цолтой өмсөөд хэд хэд мэдээлэл хийв. Энэ бүхнээс харахаар дүрэм, журамдаа юу гэж заасан юм бүү мэд, онцгой нөхцөл байдлын үед энэ дарга нар ямар ч байсан хээрийн хувцас ч юм уу, ямар нэгэн хувцас өмсөх ёстой юм байна гэж ойлгогдохоор. Түүгээрээ бусдаас ялгарах ёстой юм

байна гэсэн буруу зөвийг бүү мэд, нэг тийм там тум ойлголт төрүүлэхгүйц.

Хуучин цагийн кинонд гардаг шиг цаашдаа багийн Засаг дарга нар хүйтэн болж байна, үстэй дээлэн дээрээ элдэв тэмдэг бүхий мөрдөс зүүчихсэн гарч ирж нүдний булай болох бий гэж эмзэглэж сууна.

Улсын сүр цэрэгтээ, цэргийн сүр нь жагсаалдаа, жагсаалын сүр хувцсандаа, бие чөтгөр, хувцас бурхан ч бил үү тийм нэг үг байдаг сан. Ц.Рагчаагийн хэлсэн цэргийн хувцсыг өмсвөл өмссөн шиг өмсөж, оронцоглох юм бол больсон нь дээр гэх үгийг дайвал яадаг бол.

Дээр дурдсан бүхнийг анхаарах газар, албан тушаалтан байдаг бол энэ бүхнийг эргэн харж нэг мөр болгон журамлах цаг иржээ. Тэгэхгүй бол эмх цэгцтэй цэргийн байгууллагын аливаа үйл ажиллагаанд энэхүү хааш яаш хандлага коронавирүс мэт халдварлаж, тархах вий, цэргийн тогтсон эмх цэгц, дүрэм журам, сахилга бат, хариуцлагыг сулруулах вий хэмээн сэтгэл нэн эмзэглэн дээрх цөөн үг, саналыг тэрлэв.

1976 оны байлдагч Ч.ЭРДЭНЭЧУЛУУН  
(Бэлтгэл хурандаа)

ХӨНДӨХ СЭДЭВ

# ДЭРГЭДИЙН ДАЙСАНД ОЛЗЛОГДОХ

Сэтгүүлч П.БАТНАЙРАМДАЛ

Нийслэл хүрээний унаган хүү Нанзадын Дашзэвэг лам гэж байлаа. Түүний аав нь Богд хааны шадар хиа, ээж нь Богд хааны уран үйлчин байв. Ардын домог зүйч, уламжлалт анагаах ухааны тан тунгаагч, бариа засалч, зурхайч, хүний их эмч, ламтан тэр бээр сонин түүх, содон адал явдал мэдэх, өгүүлэхдээ гаргуун. Н.Дашзэвэг ламтан нэгэн удаа:

-Хол ойрдоо зартай, хосгүй дуучин Гэлэнхүүгийн Поврон Голын ногоон /Богд хааны ордон музей/-д дуулахад хаа байсан Гандангийн дэнжийн лам нар сонсдог байлаа гэж ярьсан сан. Өдгөө сонсоход домог мэт санагдавч өөрийн цаг үедээ гарцаагүй үнэнийг гэрчийн мэдүүлэг мэт өгүүлсэн энэ яриа гурван зүйлийг агуулж, илэрхийлж байгаа юм. Нэгдүгээрт, алдарт дуучин Г.Повронгийн хоолойны чадал, түүний дууны долгионы тархалтын орон зайн алслалт. Хоёрдугаарт, дуучнаас хол зайд буй лам нарын алсаас дуу авиа хүлээн авах буюу сонголын чадамж. Гуравдугаарт, тухайн цагийн хүрээний ажин түжин, амгалан тайван, нам гүм байдал. Эдгээр нь танд ойлгомжтой байгаа биз дээ.

Ардын хувьсгалаас өмнө ба дараа Монгол Улсад хэдэнтэй аялсан Америкийн газар зүйч эрдэмтэн, судлаач Рой Чапман Эндрюс (1884-1960) Америкийн үндэсний газар зүйн нийгэмлэгийн сэтгүүлд хэвлүүлсэн нэгэн тэмдэглэлдээ "Монголчууд маш сонорч, бас маш ажигламтгай хүмүүс. Бидний хөсөг цуваа явж байгааг хэдэн уул, гүвээний цаанаас чагнаж мэдсэн байдаг. Малын дуу авиа, алхаа гишгээ, үнэрээр хэдэн тэмээ, хэдэн морь явааг я хэлнэ. Хүнийг зүс царай, төрх байдал, явдал, нүүрний хувирал, харцаар нь ялгаж танина. Нэг харсан хүнийг хэдэн жилийн дараа ч дээрх ажиглалтаар шууд л танина. Энэ нь малын зүс сайтар ажиг, тогтоодог чадвартай нь холбоотой биз. Нэг зүйлийг онцлон хэлэхэд, монголчуудын сонсгол, дуу авиаг ялгах чадвар гойд содон, гайхалтай даа" хэмээн бичиж үлдээжээ. Энэ хоёр баримт бол зуун жилийн өмнөх л дөө. Тэр цаг дор монголчуудын ийм чадвар, сонголын мэдрэмж гайхуулаад байх зүйлгүй, хэвийн шинж чанарыг илэрхийлж байсан нь ойлгомжтой. Арай хожуу буюу өнгөрсөн зууны 50-аад оны дундуур асга хадат Алтайн уулсын дунд адуучин явсан аавын яриа байх. Дээгүүр нь онгоц нисэж өнгөрөхөд зэлүүд алсад урд өмнө гарч байгаагүй (Тэнгэр дугарах, аянга зэрэг нь байгалийн дуу чимээ шүү дээ) нүсэр дуу чимээнд цочиж үргэсэн адуу тарж бутарч, хоёрын зэрэг нь өндрөөс хад асга руу унаж үхээд адуучнаа өр төлбөрт унагаж байжээ. Онгоц гэнээс өөр нэг тохиолдлыг санаж байна. Анх удаа онгоцон суусан /Царцаа ногоон гэх/ өвгөний чих дүнгэнэж, дүнгэнэж гэртээ хариад ч өнөө дүнгэнээ нь гаралгүй байсаар дүлийрч хоцорчээ. Эндээс үүдэн хөдөөний хүмүүс онгоцон суухдаа чихээ хөвөнгөөр бөглөдөг болсон байгаа юм.

Салхины исгэрээ, дэрс өвсний халиуралт, буга урамдах, тарвага хошгорох, шувуу жиргэх, гол горхины хоржигноон, адуу тургих, тэмээ буйлах, үхэр мөөрөх, хонь ямааны майлалдаан, банкрын хуцалт, цасны будраа, борооны шиврээ гэхчлэн амьд байгалийн бараг л яруу тунгалаг найрал хөгжим сонсдог ард түмний чих сонор, соргог, чихээр дамжин тархи болоод мэдрэлд хүрэх дуу авиа тайвшрал, сэтгэлийн амар амгалан байдалд хүргэж байсан үе ердөө зуун жилийн дотор галав юүлэх шиг солигдсон байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/-ын 2019 онд гаргасан илтгэлд зуун жилийн өмнөхөөс өнөөдрийн хүний сонголын эрхтний чадамж 0,5 хувиар буурсан (дуу, авианы долгионы тархалтыг хүлээн авах алслалт, орон зайн тойрог багассан) гэж дүгнэжээ.

Дурдагдан буй тоон үзүүлэлт тун бага мэт сонсогдож байгаа боловч ихийг багатай нийлүүлэн дунджаар гэж гаргасан үзүүлэлт бөгөөд энэ нь хүн төрөлхтний сонсголын чадамж суларсан гэх таатай бус мэдээлэл, үзүүлэлт юм. Сонсголын эрхтэн хүний тархи, мэдрэлд нөлөөлдөг учраас сул тал нь удамших хандлагатайг ч генетикчид анхааруулсаар байгаа билээ. Таг дүлий буюу сонсголын эрхтний тэг зогсолттой хүмүүсийн тоо дэлхийд 500 саяыг давж мөн төдий тооны хүн хагас дутуу сонсолтой байна. Сонсголын аппаратад найдаад чихээ гаргуунд нь хаях хандлага залуу үе рүү сөвсөлзөж эхлээд байна. Элэг, зүрх, ходоод гэхчлэн голлох эрхтнээ анхаараад чихийг гадуурхаж болохгүй л дээ. Сонсголын эрхтэн тархи, мэдрэлийн системтэй харилцан уялдаа, шүтэлцээтэй байдаг тул сонсгол муудна гэдэг сэтгэлгээ, ой санамжид ямх ямхаар нөлөөлж уямаар тархины саажилт, мэдрэлийн гажигт хүргэж байгаа юм. Хэт хүнд үйлдвэржилт, автомашин, галт тэрэг, суурь машин, нисэх болон усан онгоц, хүнд, хөнгөн рок хөгжим, ахуйн цахилгаан хэрэгслүүд гээд чимээ шуугианы тархалт, чахралт, чарлалт дунд бид амьдарч байна. Цохолбол, цухалдал, мэдрэлийн гажилт үүсгэх хүлээлгийн өрөөнд байна гэсэн үг. Элдэв хов жив, санаанд оромгүй гаж үйлдэл зэргийг мэдээлэл хэмээн эндүүрэн цэнхэр дэлгэцийн бүх суваг, гар утас, гадаа гудамжинд бусдын амнаас сонсоор байгаад бухимдалд гүн хүлэгдсэн залуу нийгмийн амьдралыг ердөө л "Уур хүрээд байх юм, яах вэ" гэсэн ганц өгүүлбэрээр хэлж байгаа юм. Эрүүл, саруул хүний уурыг хүргээд байгаа, тайван бус орчинд дуу, авиа бүрдүүлж буй хэрэг. Сэтгүүлчийн хувьд хэлэхэд, дуулиант (сенсац) мэдээлэл түгээж байна гэж элдэв аллага, амиа хорлолт, хүчирхийлэл, залилан зэргийг дэвэргэн бичиж, ярьж, чихээр нь орж олон нийтийн сэтгэлийг хямраагаад дараа нь уучлал гуйдаг сэтгүүл зүйн ягтаа тулсан арга нь бухимдал (стресс) үүсгэж, хүний тархи мэдрэлийн олон зуун эсийг үхүүлж, хямрааж буй нь сэтгүүлчийн гоо зүй, нийгмийн өмнө хүлээх хариуцлага алдагдаж "таг дүлийрсний" нь илтгэж байна.

Дуу, чимээ хэмжих нэгжийг децибел гэх бөгөөд нисэх онгоц 120, автобус автомашин 80, үйлдвэрийн суурь машин, араа хөдөлгүүр 90 децибел хүртэл хэмжээний их чимээ шуугиан гаргадаг. Хотын дотор автомашин дуут дохио өгөхийг дүрэм, журмаар хориглодог. Учир нь автомашины дуут дохио 100 хүртэлх децибел чимээ гаргадаг аж. Хүний сонсголын эрхтэн системийн чимээ шуугиан хүлээн авах хэвийн хэмжээ 10 хүртэлх децибел аж. Байгалийн өгөгдөл нь ийм юм. 10-аас дээш децибелтэй чимээ шуугиан ямар нэг үл үзэгдэх, үл мэдрэгдэх шижмээр хүний сонсголын эрхтний хэвийн ажиллагаанд нөлөөлж урт удаан цаг дор гажуудал үүсгэх, бага багаар гэмтээх замаар тархи, мэдрэлд сөргөөр нөлөөлдөг. Хүний сонсголын эрхтэн төрөл бүрийн дуу авиаг сонсоод зогсохгүй тэдгээрийн гарал үүсэл, шинж чанар, хаанаас үүдэлтэй, ямар зорилго чиглэлтэй, аюул осолтойг ч ялгадаг. Сонсох эрхтэн бид харагдах байдлаар нь чих л гэж нэрлэдэг. Хүний сонсох эрхтэн гадна чих, дунд чих, дотор чих гэсэн гурван хэсгээс бүрдэх ба цааш алх, дөш, цагирган суваг, эмгэн хумс, мэдрэлийн судлууд гэсэн нэгдмэл, нарийн уялдаа холбоос бүхий тогтолцооны бүрдэл юм. Өнөөгийн хэллэг, ойлголтоор сонсголын эрхтэн маань нано технологи байна шүү дээ.

Хэнгэрэг нь цоорчихсон, дүлий юм гэж ярьдаг. Үнэхээр цоорсон, цоороогүйг эмч л тогтооно. Хүчтэй цохилт, бусад гаднын шалтгаанаар чих дүлийрдэг, сонсох чадвар сулардаг гэсэн тойм (бүдүүвч) ойлголт одоо ч бидний дунд

# ЦАТГАЙН СУУЦДЭЭР

байсаар л байна. Хүний чихээр орсон элдэв чимээ шуугиан сонсголын эрхтэн тогтолцооны хэвийн ажиллагааг алдагдуулж, зарим эд, хэсгийг цочроож улмаар гажилт, гэмтэлд хүргэн хоорондын уялдааг тасалдуулж, тэр гэмтэл согог нь мэдрэлийн судлаар дамжин тархи, сэтгэц, төв мэдрэлийн системд гаж нөлөө үүсгэдэг. Өнгөрсөн зуунд монголчууд мэдэх нь байтугай үг хэллэгт нь үл хэрэглэгдэх стресс (бухимдал) гэх нийгмийн шинж чанарыг агуулсан өвчинд хот хөдөөгүй, их багагүй нэрвэгдээд байна. Стресс гэх сэтгэцийн гаж нөлөөлөл бүхий өвчнийг чих рүү чихсэн солиорол гэвэл зохилтой. Хот, суурин гэлтгүй хөдөөд ч сонсгол муудах нь ихсэж байгааг судалгаа харуулдаг. Морь унаж мал сүргээ хариулах, мотоцикл дээр мордож паржигнуулан мал хариулах хоёрын чимээ шуугианд ялгаа байгаа даа. Ажил, мэргэжлийн онцлогоос үүдэн хүний сонсох чадвар сулрах, сонсголын эрхтэн тогтолцооны гажуудалд орох нь элбэг. Мэргэжлээс шалтгаалах өвчний эхэнд чих, хамар, хоолой, уушгины өвчнүүд бичигддэг.

Монголчуудын сүсэг бишрэл, итгэл үнэмшлийн эрхийн дээд Бурхны шашинд сэтгэлийн амар амгаланг түлхүү номлодог. Амар амгалан, тайван байна гэдэг нь чимээ шуугианаас ангид, хялбаршуулан тодолбол, чих, сонсголын эрхтэн амраана гэсэн үг. Чимээ шуугиангүй орчинд хүний тархины эс, эдүүд зохих байрлалдаа шахцалдаж, түлхэлцэлгүй тайван оршин тогтноно. Даяанчлах, бясалгал үйлдэх нь сонсголын эрхтэн чимээ шуугианаас ангижруулж, оюун санаагаа гаднын нөлөөллөөс чөлөөлж, тайвшруулж буй шашны зан үйлээр илэрдэг эмчилгээний хэлбэр юм. Зөнөсөн гавж (Бурхны шашны эрдмийн хэргэм цол) байдаггүй гэж ярьдаг. Энэ нь насан туршийн бясалгал, нам гүм, амгалан байдалд тархины эс, эдүүд нь хэвийн, сэтгэлгээнд нь гаж нөлөөлөл үзүүлээгүй л илтгэж буй хэрэг. Бясалгал хийж буй лам чихээчээр хөгжим сонсох боломжгүй биз дээ. Цэргийн анги руу томилолтоор явахад нь залуу сурвалжлагчид зөвлөгөө өгчээ. "Адилхан хувцастай хүмүүсийг хэн нь юу хийдгийг ялгахад хэцүү. Ам нь байнга ангалзаж байгаа нь улс төрийн ажилтан. Аан, аан гээд лавлаад байгаа нь их буучид шүү" гэсэн байгаа юм. Сум тэсрэх, дэлбэрэх чимээнд их буучдын сонсох чадвар суларсан нь тэр. Бас бөхчүүдийн чихийг эрхтэнд тооцдоггүй гэсэн явган яриа бий. Бөхчүүдийн гадна чих буюу дэлбээний нимгэн мөгөөрс хугарч хулгар болсон байдаг. Анагаах ухааны тодорхойлолтоор гадна чих чимээ шуугианыг эхэлж хүлээн авах, хэт өндөр авиа намсгах, чихний нүх сүвийг хамгаалах гээд олон үүрэгтэй аж. Гадна чих гэмтэж согогтсон бол дунд болон дотор чихэнд гаж нөлөөлөл үзүүлэх нь эргэлзээгүй юм.

Дэлхийн хамгийн их хог хаягдалтай, утааны хордлоготой, хөрсний бохирдолтой, баталгаагүй хүнстэй нийслэл хот бол Улаанбаатар юм. Механик чимээ, шуугианаараа ч мөн л хамгийн гэдэгт бичигдэж, нэрлэгдэж байна. Улаанбаатарын чимээ шуугиан 67,5 децибел хэмжээнд хэдийнээ хүрсэн. Энэ тоо өдөр өдрөөр, ямх ямхаар нэмэгдсээр л байгаа. Хүний сонсох эрхтний тогтолцоонд буюу эрүүл мэндэд нөлөөлөхгүй

байх зөвшөөрөгдсөн хэмжээнээс нийслэлчүүд даруй 7,5 дахин их чимээ шуугиантай орчинд амьдарч байна. Наанадаж тооцоход 1,5 сая хүн хэт чимээ шуугиантай орчинд, сэдэвтэйгээ уялдуулан тодотгоход хүний

нээс ангижраад зогсохгүй маш том талбай чөлөөлөгдөх байсан билээ. Харь орны тусламж, үнэнийг хэлбэл харь орны хүмүүсийн санаачилга, дэмжлэгтэйгээр нисэх

сонсголын эрхтэн тогтолцоонд гаднын ямар нэгэн гаж нөлөөлөлтэй, цаашлаад гэмтэл согогтой байна гэсэн үг. Манай улсад 200 гаруй мянган хүн дүлий, 10 мянган хүн таг дүлий байгаагийн 80 шахам хувь нь нийслэлд байна. Энэ тоонд төрөлхийн, хөгшрөлийн зэрэг жам ёсны дүлийрэл орохгүй, тэд тун цөөн бөгөөд тусдаа бүртгэлтэй. Саяхнаас телевизийн хэд хэдэн суваг дохионы хэлний нэвтрүүлэгч ажиллуулах болов. Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст хандсан алхам гэдгийг ойлгож, хүндэтгэж байгаа хэдий ч энэ нь дүлий хүмүүсийн тоо хичнээн их байгааг илтгэнэ. Үүнийг дэлхийн жишгээр гэж хаацайлахад учир дутагдалтай л юм.

Нийслэлийн чимээ, шуугианы ихэнх хувийг автомашины дуу чимээ эзэлж байгаа бөгөөд хотын замын сүлжээний 800 гаруй километр зам дээр өдөрт хагас саяас илүү тээврийн хэрэгслүүд шахцалдаан, түгжрэл, нүсэр тасралтгүй чимээ шуугианыг үүсгэн хөдөлгөөн үйлдэж байна. Автомашины утааг багасгана гэж хуучин, шинэ, эдэлгээний хугацаа, моторын чадал, түлшний шаталт, дугаарын хязгаарлалт зэрэг олон зохицуулалт хийсэн ч тусыг эс олов. Тэртээ тэргүй манайд гаднаас орж ирсэн бүх машины тал хувь нь эдэлгээний хугацаа нь дууссан, үлдсэн хагас хувь нь хуучин юм чинь (ямар өөрсдөө үйлдвэрлэх биш) автомашины утаа багасгах боломжгүй юм. Тэгтэл энэ олон жилд автомашины чимээ шуугиан гэж ер ярьсангүй, бууруулъя гэж сэдэж сэхээрсэнгүй. Түгжрэлд хэдэн цагаар гацаж байна гэдэг нь төдий хугацаагаар чихнээ чийртэй чимээ шуугианд олзлогдож байна гэсэн үг. Түгжрэл гэсэн монгол үгийг монголоор орчуулбал уур ундууцал, бачимдал, бухимдал гэсэн утгыг илэрхийлнэ. Энэ үгс хүний тархи, мэдрэлийн системийн амгалан тайван, хэвийн байдалд сөрөг нөлөөлөл бүхий гажуудал үүсгэдэг "дайсан" юм. Ийм "дайсан"-ыг өөрсдөө бэлтгэж, өөрсдөө олшруулж, чихээрээ сорж байгаа юм.

Нийслэл хотын өмнөдийг хажлан Богд хан уулын бэл, хатан Туулын ай сав дагуу хүнд хахир чимээ шуугианыг тодорхой цагийн давтамжтайгаар түжигнүүлэн байдаг төмөр замыг Эмээлт өртөөнөөс Богд хан уулын баруун сугаар гаргаж хотоос холдуулах яриа хэдэн жилийн өмнө гарсан ч хэрэгжүүлж зориглосонгүй. Казахстан улс 30-аад жилийн өмнө нийслэл хотоо эзгүй хээр тал дээр цоо шинээр сүндэрлүүлсний нэг шалтгаан нь олон зуун жилийн турш Алато уулын бэл, хөндийд шавааралдан боссон Алматы хотын их дуу чимээнээс холдсон явдал байв. Энэ улсын шинэ нийслэлийн хот төлөвлөлт нь таруу, сийрэг, нийтийн тээвэр, үзвэр үйлчилгээ, спорт, зугаа цэнгээний газрууд, автомашины замын сүлжээ орон сууцнаас тодорхой зайтай байлгасан зэрэг алхмыг хийж чадсанаараа Казахстан улсын шинэ нийслэл дэлхийн хамгийн чимээ шуугиан багатай хотын эхэнд нэрлэгдэж байгаа юм. Нийслэл хотыг Хархорумд нүүлгэх санаа яригдаж байсан үе бий. Ийм том алхам хийх эдийн засгийн болоод ажиллах хүчний нөөц хомс, шийдвэр гаргах эрхмүүдийн зориг зүрх хүрэхгүй нь тодорхой учраас ядаж төмөр замыг хотоос гаргаж чадсан бол нийслэлчүүд маань нэгэн хахир хүнд чимээ (далан жил дөжиртлөө сонссон)-

онгоцны шинэ буудлыг Хөшигийн хөндийд барьснаар нэгэн төрлийн чимээ, шуугианыг нийслэлээс холдуулж байгаа нь сайшаалтай юм.

Өдгөө 90 насны босго алхаад буй алтай нутгийн нэгэн буурал "Би унтахдаа чихээ хөвөнгөөр бөглөдөг юм" гэж яриу. "Яаж байгаа нь тэр вэ, та дүлий биш шүү дээ" гэвэл "Хотод ирснээс хойш дүлий болчих гээд байна. Хүүгийнх хотын төвд л дөө. Үдэш болохоор хажуугийн гуанз (баар)-наас дуу, хөгжим чахраад шөнөжин чарлачих юм. Аргаа ядаад чихээ хөвөнгөөр бөглөж, хөнжлөө толгой дээгүүрээ нөмөрч унтана шүү дээ" гэж хариу хэлдэг юм. Ийм гомдлыг оршин суугчид олноор нь гаргадаг даа. Гөлгөн нохой хуцаж л байна, жингийн цуваа хөвөрч байна гэдэгтэй агаар нэгэн буюу усанд хаясан чулуу гэдэг л болно. Хот төлөвлөлтийн үндсэн шаардлагын эхэнд дуу чимээний саармагжилт ордог, манайд бол мартагдаж гээгдсэн шалгуур юм.

Бидний бүтээн байгуулж, амьдрал буй эрин зуун маань мэдээллийн зуун гэдэг нь маргаангүй. Аливаа хөгжил дэвшил, шинжлэх ухааны ололт бүхэн сөрөг үр дагавартай байдаг. Тиймээс сайн бүхнийг дэлгэрүүлэн хэрэглэхдээ хоруу чанарыг нь эхэлж мэдэрч, хамгаалах арга замыг эрэлхийлэх нь чухал. Хүн төрөлхтний хөгжил дэвшил ийм л замаар явж ирсэн шүү дээ. "Техник, технологийн ололт амжилт бүхэн байгаль дэлхий, хүний эрүүл мэндийн эсрэг байдаг" гэж нэгэн цуутай эрдэмтэн бичиж, анхааруулж үлдээснийг санаж байна. Ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгслүүдийн дуу чимээ л хүний мэдрэл сэтгэхүйд нөлөөлсөн өөрчлөлтүүдийг ил, далд бий болгосоор байдаг. Кавказын өндөр ууланд амьдардаг, булчин шөрмөс нь зангирсан чечень эр нэгэн төрлийн харшилтай болжээ. Мэргэжилтнүүдийн судалгаагаар өдөр бүр сахлаа цахилгаан машинаар авдаг нь нөлөөлсөн байна. Тодолбол, чихээргээний харшил гэх нэршлийг гаргажээ.

Эргэн тойронд чихээр орж, чиний миний сэтгэц, мэдрэлд гаж нөлөөлөл үүсгэх тун сэжигтэй орчинд бид дасан зохицож, өөртөө харх шиг дархлаа тогтоож чадахгүй. Харин хамгаалах, урдчилан сэргийлэх, чимээ шуугианы хоруу чанарыг сурталчлах, иргэн бүр мэдвэл зохих бүхнийг хэлж анхааруулах нь чухал болоод байна. Ахуйн хэрэглээний чимээ шуугиан, сөрөг мэдээлэлтэй холилдон мэдрэл, сэтгэцэд нөлөөлөхүйц өөрчлөлтүүдийг бий болгосоор байгаа нь эргэлзээгүй үнэн. Кабелийн суваг, чихэвч, гар утас зэргээс элдэв хов живийг чих рүүгээ хөгийн сав мэт чихсэнээс дээр хэлсэнчлэн бухимдалд орж улмаар бууруу, зөрүүг ялгах чадвараа алдан, тархины эд, эсүүд нь таталцал, түлхэлцэл, тэнцвэрт байрлалаасаа гажиж адаглаад мартаж санадаг, цаашлаад солиоролд хүргэж байгааг илэрхийлэх бодит биелэл нь амиа хорлох үйлдэл юм. Сэтгэц, мэдрэлийн эмнэлэгт хандагсад, хүргэгдэгсдийн дийлэнх хувь нь чихээр дамжин тархи, мэдрэлийн үйл ажиллагаанд нөлөөлсөн өвчлөлтэй байгаа юм. Дэргэдийн дайсан дуу, чимээнд бид олзлогдох биш өөрсдөө санаатайгаар өртөж, санаатайгаар эрүүл мэндийн сүйрэлд өртсөөр л байх юм гэж үү. Дэргэдийн дайснаа дэргэдээсээ үргээх болсон дог шүү.

Хобби болгон тухайн хүний зан чанарыг илтгэн харуулдаг. Түүн лүгээ сонгосон мэргэжилдээ хөтөлгөдөн өөрийн цуглуулгаа бий болгодог хүн ч цөөнгүй. Тэдний нэг нь Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Материал, техникийн хэлтсийн техникийн хангалтын ахлах офицер, дэд хурандаа С.ДАШДОНДОГ юм.

### Та өөрийн цуглуулгаа танилцуулна уу?

-Миний цуглуулга нь цэргийн зориулалтын автомашины загваруудаас бүрддэг. Өөрөөр хэлбэл, ОХУ-д үйлдвэрлэгддэг, манай Зэвсэгт хүчинд ашиглагддаг автомашинуудын загвар гэсэн үг. Мөн БНМАУ-ын маршал Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал гуай нар болон тэр үеийн дарга, сайд нарын унаж байсан суудлын автомашинуудын загваруудыг цуглуулдаг хоббитой.

### Анх яагаад цуглуулах болов ...

-Ерөнхийдөө өөрийн мэргэжлээ хобби болгосон гэсэн үг. Би хүүхэд байхын л машин, техник сонирхдог байсан. Тиймээс өөрийн мэргэжлээ ч мөн авто техникийн салбартай холбосон. Миний цуглуулгын нэг онцлог чанар нь би өөрөө Зэвсэгт хүчний 089 дүгээр ангид засварчин, жолооч байсан үеэсээ эхлээд цуглуулдаг байгаа автомашинуудаа бодитоор нь жолоодож, засвар, үйлчилгээ хийж байсан. Энэ ч утгаараа илүү үнэ цэнтэй санагддаг. Улмаар Цэргийн их сургуулийг авто техникийн инженер мэргэжлээр 2001 онд төгссөн. Төгссөнөөсөө хойш 20 орчим жил мэргэжлээрээ ажиллаж, алба үүргээ гүйцэтгэж

байна. Энэ нь миний анхнаасаа л сонгосон салбар учир хобби маань нь ч үүнтэй салшгүй холбоотой. Анх 2011 оноос эхэлж цэргийн зориулалт бүхий автомашины загваруудыг сонирхож нэг, нэгээр нь цуглуулж эхэлсэн. Тухайн үед энэ төрлийн загварууд ховор байсан. Харин орчин үед олдоц нь элбэг болсны зэрэгцээ зориулалтын засварын газрууд ч нээгдсэн. Дээрээс нь ганцхан ОХУ-д үйлдвэрлэгдсэн автомашинуудаар өөрийн цуглуулгаа төрөлжүүлсэн. Жишээ нь "ЗИЛ-114", "ЗИЛ-117" зэргийг захиалгаар хийдэг, хуяглагдсан автомашинуудын загварыг цуглуулгадаа багтаасан. Манай Зэвсэгт хүчинд ашиглагддаг ихэнх автомашины загвар надад бий. Харин суудлын автомашины хувьд бүгд хар өнгөтэйгөөрөө онцлог. Учир нь 1950-аад оны үеийн улс төрийн удирдагч нарын суудлын автомашинууд бүгд хар өнгөтэй байсан. Мөн л захиалгаар хийлгэдэг, тоноглогдсон автомашинууд гэсэн үг. Тухайлбал, "Чайка", "ГАЗ-М1", "ГАЗ-А" зэрэг загвар миний цуглуулгад бий.

### Цуглуулгаа яаж баяжуулдаг вэ?

-Би ОХУ-ын Санкт-Петербург хотын Цэргийн материал, техникийн хангалтын академид гурван жил суралцаж төгссөн. Тэр хугацаанд цуглуулгаа багагүй арвижуулсан. Орос улсад иймэрхүү төрлийн автомашины загваруудыг зардаг дэлгүүр



их байдаг. Хувь цуглуулагчид ч багагүй. Манай оронд байдаггүй загварууд тэнд төрөл төрлөөрөө байдаг учир гар таталгүй худалдаж авдаг байсан. Одоо ч гэсэн ОХУ-д суралцаж байгаа монгол сонсогч нарт захиж авахуулах тал бий. Тэгэхдээ ямар ч хамаагүй үйлдвэрийн биш заавал зориулалтын, хүлээн зөвшөөрөгдсөн загваруудыг нь худалдаж авдаг. Миний цуглуулгын загварууд бүгд 1:43

хэмжээтэй. Хэмжээ тус бүрээр нь төрөлжүүлж, цуглуулж болдог гэсэн үг. Үнийн хувьд хамгийн багадаа 30, дээд тал нь 180 гаруй мянган төгрөгөөр зарагддаг. Харин ховордсон загварууд бүр ч үнэд хүрнэ. Жишээ нь миний авахаар хайж байгаа автомашины загвар 400 орчим мянган төгрөгөөр үнэлэгддэг.

### Нийт хэдэн автомашин цуглуулсан бэ?

-50 орчим загвар байгаа.

Цаашдаа цуглуулгаа илүү өргөн хүрээнд төрөлжүүлнэ гэж боддог. Зарим нэг эвдэрсэн зүйлсийг нь өөрөө засаж сэлбэх үе бий. Их л нандигнаж цуглуулдаг даа. Манай бага хүү надтай адил автомашин, техник сонирхдог хоббитой. Хүүхдээсээ харамлах тохиолдол цөөнгүй гарна. Цуглуулгын загваруудаа хүүхдүүддээ тоглоом биш гэдгийг нь ойлгуулахыг хичээдэг.

### Өөр ямар цуглуулгатай вэ?

-ОХУ-ын хот болгоныг дүрсэлсэн зоосон 10 рублиуд цуглуулдаг. Олдоц нь тун ховор. Оросдоо ч ховор үйлдвэрлэгддэг зооснууд. Энэ цуглуулга маань дуусах болоогүй. Тэдгээр зоосоо зориулалтын цуглуулгын хавтаст хийдэг. Хот бүрийг дүрсэлсэн байдаг болохоор зориулалтын хавтаст хотынх нь талаар тодорхой тайлбар бичээд цуглуулдаг. Одоогоор нийт 30 орчим зоос бий.

### Таны хамгийн үнэ цэнтэй цуглуулга юу вэ?

-Хамгийн үнэ цэнтэй нь нэрлэвэл "ЗИЛ-131МТО-АТ" гэдэг засварын хөдөлгөөнт автомашины загвар. Яагаад хамгийн үнэ цэнтэйд тооцож байгаа вэ гэвэл өмнөх будаг нь сааралдуу өнгөтэй байсныг би өөрөө ноогоон өнгөөр будаж янзалсан хэрэг. Ер нь автомашины загварыг будахад тусгай будаг ашигладаг. Тэр будаг нь будсан. Багагүй хөдөлмөр зарсан учир миний хувьд үнэ цэнтэй.

Дэд ахлагч Т.ИДЭР

## ВОЛОДИН ГЭЭЖ ХЭН БЭ?

### "Алт хэдий хиртэвч өнгө нь үл хувирах Алдарт хүн үхэвч нэр нь үл мартагдах" (Халимаг ардын зүйр үг)

Октябрийн хувьсгалын түүхийг өнгөцхөн бадарч үзэхэд Володин хэмээх хувьсгалч гэмээр эрмэг, зоримог нэгэн эрийн нэр сонирхол татна. Тэрээр 7 насандаа малчин, ажилчин, 12 настайдаа уурхайчин болж улмаар Луганский мужийн Василевский дүүргийн сургуульд 3 жил суралцжээ. Мөн Оросын хувьсгалчидтай танилцан Троцкийгийн байгуулсан Социал демократ намд гишүүнээр элсэж тэдэнтэй хамтран ажиллаж эхэлсэн байна. Тэдний үйл ажиллагаа төдий л таалагдаагүй учир нам, сургуулиа орхиж, Оросын большевик хэмээгдэх Ленин, Сталин нартай танилцан 19 насандаа энэхүү намын гишүүн болжээ. Тэр үеийн Оросын хувьсгалчид бүгдээрээ нууц нэртэй байсан учир Ленин түүнийг Володин гэх нэрээр хувьсгалын ажилд оролцуулах болсон байна.

Володин Мужийн намын хорооны товчооны гишүүн болж улмаар уг намын хороог удирдаж эхлэв. Түүнчлэн 1906 оноос хувьсгалын үйл хэрэгт идэвхийлэн оролцож, тус намын суртал ухуулгын ажлыг эрхлэх болсноор зохион байгуулах авьяас, чадвар нь улам бүр өсөж, хувьсгалын хэрэгт сэжиглэгдэн баривчлагджээ. Мөн Орос, Финляндийн дайнд гарамгай байлдан цэргийн авьяаслаг дарга болохоо ч харуулсан байна. Октябрийн хувьсгалын үеэр нөхөр Сталины хамт Царицыногийн хамгаалалтыг сайн зохион байгуулан иргэний дайнд биечлэн оролцож, олон удаагийн тулаанд шалгарсан бөгөөд хожмоо Оросын цэрэг, армийн нэрт удирдагч төдийгүй ирээдүйн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга мөн Батлан хамгаалах ардын комиссаратыг толгойлох болсон юм.

Энэхүү авьяаслаг жанжин бол бидний сайн мэдэх Климент Ефремович Ворошилов байв. Тэрээр 1881 оны 2 дугаар сарын 4-ний өдөр Екатеринбург хотын дээд сууринд эргүүлийн хэсгийн ядуу ажилчны гуравдугаар хүү болон мэндэлжээ. Гэр орон нь туйлын ядуу байсан учир багаасаа хүнд хүчир ажилд нухлагдан тэсвэр тэвчээртэй нэгэн болж өсөв. Хувьсгалын дараа 1920-1924 онд



Коминтернийн Алс Дорнод (Монгол)-ыг хариуцан ажиллаж байлаа. Энэ үеэс Ворошилов Монголын нийгэм, улс төрийн амьдралтай холбогдож эхэлжээ. Тэр бээр коминтернийн бусад нөхөд шиг Монгол Улсад сөрөг үйл ажиллагаа явуулаагүй бололтой. Харин Улсын онцгой комисст ажиллаж байхдаа Феликс Эдмундович Дзержинскийтэй хамтран хувьсгалын эсрэг бүлгийг устгах ажлыг хүчтэй явуулж, тухайн нийгмийн шаардлагаар олон мянган сэхээтэн, гэмгүй хүмүүсийг шорон, гяндан, цөллөгт явуулсан бөгөөд үндд 18000 хүн өртөж, 200 шахам хүн буудуулан нас барсан мэдээ байна. Нөхөр Ворошилов 1930-аад оны дунд үеэс Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Батлан хамгаалахын ардын комиссаратыг даргалах болжээ. Энэ үеийн Монгол Улсад Халхын голын байлдааны эхлэл ид өрнөж Япон, Манж баргын хороод хилийн зэвсэгт мөргөлдөөний үеэр үе үе уулгалан довтолж Номун хан, Халхын гол орчмын хэсэг газрыг таслан эзэмшсэн байв. Ардын комиссаратын газарт Халхын голын байлдааны үйл явцын тухай мэдээ, рапорт өдөр алгасахгүй ирсээр байжээ. Климент Ефремович Ворошилов Зөвлөлт Холбоот Улсын анхны маршал (1935) Иосиф Виссарионович Сталин, Вячеслав Молотов нартай хамтран тухайн үеийн бүхий л асуудлыг шийдвэрлэж байсан нь Оросын Холбооны Улсын Холбооны архивын агентлаг, Оросын цэргийн

түүхийн төв архив, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Архивын Ерөнхий газар, Монгол Улсын Батлан хамгаалахын төв архиваас эрхлэн хэвлүүлсэн "Халхын голын орчим дахь зэвсэгт мөргөлдөөн 1939 оны 5-9 дүгээр сар" номноос дэлгэрүүлэн үзэж болно. Климент Ефремович Ворошилов энэхүү байлдааны үйл явцын талаар 1939 оны 5-9 дүгээр сард өдөр тутам холбоотой байсан нь уг номд дурдсан баримт бичиг, илтгэл, мэлээллээр нотлогдож байна. Баримт бүрийг тоолж үзэхэд, нөхөр Ворошиловын нэр орсон, хүлээж авсан баримт, мэдээлэл, илтгэл 126, корпус командлан захирагч Г.К.Жуков 119, штабын (Ворошиловын) Шапошников 95, дивиз командлан захирагч Никишев 82, Молотов 29 байх жишээтэй. Үүнээс хэн нь хэрхэн үүрэг гүйцэтгэснийг нь харж болох юм. Зарим баримтыг авч үзвэл, Баянцагааны район дахь байлдааны явц ба агаарын ажиллагааны талаар К.Е.Ворошилов шууд холбоогоор Я.В.Смушкевичтэй хийсэн ярианы бичлэгээс ... 1939 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 14.40 цагт (Москвагийн цагаар) Ворошилов: -Сайн байна уу? Аппарат дээр Ворошилов ирээд байна. Танай тэнд юу болж байна?

Смушкевич: -Дөнгөж сая фронт дээр ирлээ. Штабын дарга нартай ярилаа ...

Ворошилов: -Энэ өдөр агаарын байлдаан болсон уу? Хэрэв болсон бол ямар үр дүн гарав?

Смушкевич: -Фронтын районд гурван удаа агаарын богино хугацааны байлдаан болсон, эсрэг этгээд гурван онгоцоо алдсаныг нь би мэдэж байна (Уг номын 171-173 дугаар хуудас) хэмээжээ.

Ийнхүү нөхөр Ворошилов фронтын байдалтай өдөр тутам танилцаж, үүрэг өгч байжээ. Монголын талаас сумангийн даргаас эхлээд дивизийн комиссар Д.Пэлжээ, орлогч жанжин Лувсандоной нартай харилцаж, зохих арга хэмжээг авч байсан нь баримтаар батлагдаж байна. Бид Халхын голын байлдааны ялалтын ойг тэмдэглэхдээ энэ хүний тухай огт дурддаггүй нь хөлөөр орооцолдоод толгойгүй мэт болгосон байна. Гэтэл монгол түмэн үүнийг нь аль хэдийн мэдээд

Хүрэн халзан тоомсгоороо Хүрээд ирдэг Ворошилов Хүчтэй олон цэргүүдээ

### Ганцаараа командалсан Ворошилов Хар халзан тоомсгоороо Хатируулаад ирдэг Ворошилов Хамаг олон цэргүүдээ Ганцаараа командалсан Ворошилов

хэмээн түүний үйл ажиллагааг бахдан алдарт жанжин болохыг нь дуу хуурт оруулан дуулж байсан аж.

Климент Ефремович Ворошилов Орос орондоо туг ч мандуулж, тугал ч хариулан ээдрээт замыг туулсан ба Оросын төр, засгийн өндөр дээд албан тушаалд 35 жил зүтгэн улс төрийн товчооны гишүүнээр тасралтгүй сонгогджээ. Харин 1960-аад оны үед Никита Сергеевич Хрущев түүний нэр хүнд, албан тушаалыг нь ашиглан Оросын нэр нөлөө бүхий удирдагчид (Булганин, Маленков, Каганович, Микоян)-ыг албанаас нь буулгажээ. Эцэст нь түүнийг ч мөн муучлах байдлаар буулгасан байна.

Ийнхүү Ворошилов 1969 онд тэнгэрт хальсан бөлгөө. Тэрээр Зөвлөлт Холбоот Улсын хоёр удаагийн баатар, мөн социалист хөдөлмөрийн баатар байжээ. Түүний алдар гавьяаг нь мөнхжүүлэн Луганскт мөн Орос-Туркийн харилцааг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан учир Истанбулд хөшөөг нь босгожээ. Тухайн үеийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төр, засгаас маршал Ворошиловын алдар гавьяаг нь өндөрөөр үнэлж Сүхбаатарын одонгоор хоёр удаа мөн Байлдааны гавьяаны улаан тугийн одон, 1957 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар цолоор тус тус шагнасан юм. Ворошилов Орос-Монголын найрамдал, нөхөрлөлийг бэхжүүлэх, харийн түрэмгийлэгчдээс хамгаалах тэмцэлд оюун ухаан, хүч, авьяасаа харамгүй зориулж байсан нь олон баримтаар батлагдаж байгаа тул манай цэргийн судлаачид гүнзгийрүүлэн судалж, зохих байр суурийг нь илтгэн гаргана гэдэгт итгэж байна.

Ирэх онд түүний мэндэлсний 140, Орос-Монголын найрамдлын 100 жилийн ой тохиох билээ.

Монголын Ахмадын холбооны дэргэдэх Дайнд оролцогчдын Монголын хорооны хариуцлагатай нарийн бичгийн дарга асан нийтлэлч Д.ДЭМБЭРЭЛ

# ОНЦЛОХ ХҮМҮҮС

“Онцлох хүмүүс” буланд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга нарын тухай бичсэн дурсамж минь олны талархлыг багагүй хүлээж сайхан үгэнд урамшаад дахин бяцхан дурсамжуудыг уншигч тантай хуваалцахаар шийдэн бичиж сууна. Би цэргийн даргын бусдаас ялгарах онцлогийг “цэргээ хайрлах ухаан”-д оршдог гэж боддог. Энэ гуравхан үгэнд мэргэжлийн ур чадвар, харилцааны соёл, удирдахуйн ухаан, хүн чанар гээд маш олон ухагдахуун багтдаг. Бараг л биеэ даасан шинжлэх ухаан гээд хэлчихвэл хэтрүүлсэн болчихдог юм болов уу. Миний дор өгүүлэх жишээ танд байдаг л энгийн нэгэн тохиолдол шиг санагдаж магадгүй. Гэхдээ энгийн бүхнээс эгэл бий мэдрэгдэх нь элбэг шүү дээ. Бид чинь харилцааны нийгэмд урмаар ташуурдаж, ташуурдуулж ажиллаж амьдарвал амжилт бүтээл ар арасаа ундрах нь дамжиггүй. Хүний сэтгэлийн утсыг олж хөглөнө гэдэг хэрийн хүний чадах зүйл биш нь ойлгомжтой. Гэхдээ хичээл л хэрэгтэй.

## “БӨМБӨГ” ДЭЛБЭРВЭЛ АЮУЛТАЙ

1980-аад оны сүүлч үед аав маань Дархан хотоос багагүй зайд орших Ширээ нуруунд байрладаг Зэвсэгт хүчний 134 дүгээр ангид ажилладаг байлаа. Луужингийн анги гэдгээр нь хүмүүс сайн мэдэх байх. Ангиас тийм ч хол биш зайд нэг давхар хэдэн цагаан байшинд ангийн алба хаагчдын гэр бүл амьдардаг байсан юм. Тухайн үед ангийн штабын даргаар Эрдэнэцог гэдэг дэд хурандаа ажилладаг байв. Ширээ нурууныхан хөгшин залуу, ангийн цэргийн гэлтгүй бүгд л “Бөмбөг” гэж дуудан айж, эмээнэ. Хүүхдүүд хүртэл хажуугаар гарахад нь номхон зогсдог байлаа. Штабын даргыг байхад анги нам гүм, бүгд эмх цэгцтэй байдаг гэсэн томчуудын яриаг одоо эргээд санахад ангийг ёстой “атгадаг” байсан нь ойлгомжтой. Ямар сайндаа л “Бөмбөг дэлбэрвэл аюултай” гэж үг гарах вэ дээ. Зургаа, долоохон настай балчирхан надад их л аймаар хүн шиг санагддаг байлаа. Айлгаж, загнасан тохиолдол байхгүй ч томчуудыг дагаж л эмээдэг байсан байх. Угтаа бол зарчимч, шударга, сайн цэргийн дарга гэдгийг нь хожим хоино ухаарсан. Тэр жил өрнөсөн нэгэн явдлын тухай яриа, миний там тум ойлголт санаанаас огт гардаггүй юм. Ангид цэргийн

алба хаагч, цэргүүдийн амь нас, эрүүл мэндтэй холбоотой томоохон асуудал гарч, нэлээд газар авсан ба цагдаа сэргийлэхдээ тулан хамаг хэрэг штабын дарга дээр бууж бараг л орон шоронгийн асуудал яригдаж эхэлжээ. Гэтэл цэргийн прокуророос штабын даргыг дуудаж “Та цэргүүддээ баярлаж яваарай. Ийм тохиолдол өмнө нь гарч байсангүй” гээд даргынхаа буруугүйг нотолж, өмөөрч бичин гарын үсгээ зурсан сэтгэгдлээр дүүрэн дэвтрийг өгсөн гэдэг. Тэр үед штабын даргын эхнэр нь “Өдөр шөнөгүй, гэр орноо мартаж шахуу цэргүүдээ гэдэг байсных нь ач буян гарлаа” гээд уйлж байна гэж аав, ээж хоёрын ярихыг нь сонссон. Энэ явдлыг би хагас дутуу ойлгосон хэдий ч үүнээс хойш штабын даргаас айхаа больж харин ч сайн хүн шиг санагддаг болсон юм даг. Энэ бол амьдралд минь бахархах сэтгэгдэл төрүүлсэн анхны цэргийн дарга, дарга нь цэргээ, цэргүүд нь даргаа хайрлагдгийн хамгийн эхний жишээ байсан юм. Хэлбэр агуулгыг илэрхийлэхгүй гэдгийг ойлгуулсан бодит явдал ч гэж хэлж болно. Хожим нь өөрөө цэргийн салбарт хөл тавьж олон ч сайн, сайхан цэргийн дарга нарыг бахархан хүндэтгэж, даган дуурайхыг хичээж яваа билээ.

## ТАВАН ДОЛЛАР



нэгэн юм боллоо гэхэд хүүхдүүдээ яаж буцааж татах юм. Энэхүү үүргийн талаардахин ярилцах шаардлага тий гэж билээ. Мань мэтийн өнгөцхөн бодолтой амьтад бол магтаалын үгсэнд булуулаад нэг их мундаг хүн болохыг хичээж аягүй бол хүн хүч нэмнэ гэж “мэдрэлтэх” байсан биз. Дараа өдөр нь бид “Мармал” баазыг зориллоо. Очоод хамгийн түрүүнд харуулын цэгүүдээр тойрсон юм. Тухайн үед нутгийн иргэд хамт харуулд гардаг байсан. Үндэсний хувцастайгаа буу мөрлөн зогсоо тэдэнтэй Молор хурандаа энгийн сайхан яриа өрнүүлж “Цэргүүдэд маань тусалж, дэмжиж байгаарай” гээд гар барихдаа ямар нэгэн зүйлийг атгуулаад байгааг анзаарсан юм. Сониуч зан хөдөлж дараагийн харуулын цэгээс гар барин холдоход нь үлдээ хийн хэрэг болгон харлаа. Ядруухан царайтай афган харуул гараа дэлгэхэд эвхсэн 5 доллар харагдав. Тэр эрийн харц баяраар гэрэлтэж бас их л хүндлэнгүй хойноос нь ширтэж байж билээ. Дотроо “Баярлалаа, баярлалаа” гэж дахин дахин хэлсэн байх. Би даргаас яагаад гэж асуугаагүй ээ. Угаасаа ойлгомжтой. Дайны хөлд нэрвэгдэн ядарч зовсон хүнд жижиг сажиж бэлэг, дурсгалын зүйлээс хамаагүй илүү хэрэгтэй нь ойлгомжтой. Мөнгө төгрөг авсандаа биш монгол цэргийн даргын сайхан сэтгэлд нь талархаж цэргүүдэд маань сайн хандана гэдэгт эргэлзээгүй.

2011 онд Афганистан улсад Цэргийн багийн ээлж солилцуулах комисст багтаж ажилласан юм. Комиссын дарга нь Зэвсэгт хүчний Жанжин штабын Энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Ж.Молорболд. Чамгүй урт замыг туулж очсон бид 10 гаруй хоног хурал, уулзалт гээд өглөөнөөс үдэш хүртэл ажилласан юм даг. Нэг удаа Афганистаны Иргэний нисэх рүү явах боллоо. Учир нь тэнд манай цэргийн хоёр алба хаагч хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байсан юм. Тэдний үүрэг гүйцэтгэж байгаа байдлыг очиж үзнэ гэж комиссын дарга шийдэж нэлээд урт замыг тууллаа. Биднийг очихтой зэрэгцэн тэндхийг хариуцсан удирдлагууд, ажилтнууд цэргүүдийг маань магтаж “долоох” нь халаг юм болов. Харин Молор хурандаа магтаалын үгийг тоож байгаа ч юм алга, нэг л дүнсгэрдүү. Ингэсгээд буцлаа. Замд хурандаа “Хамгийн гол нь цэргүүдийн маань аюулгүй байдал. Ямарваа

## ЗАХИРАГЧИЙН "НАРИЙН БИЧИГ"



Ажилд ороод удаагүй нэгэн удаа Зэвсэгт хүчний 016 дугаар ангид сурвалжлах ажлаар ахлах сурвалжлагч, дэд хурандаа П.Батнайрамдалын хамтаар очсон юм. Тухайн үед ангийн захирагч нь хошууч генерал Ч.Магсар байсан. Захирагчид хэрэг зоригоо илтгээд энэ тэрийг ярилцаж байтал “Орох уу” гэсээр өндөрдүү, болхи байрын байлдагч цай барьсаар орж ирлээ. Магсар генерал бидэнд хандан “Миний нарийн бичиг” гэж цаанаа л ёжлонгуй танилцуулав. Бидний яриа ч цааш үргэлжилж энэ хооронд нэлээд хэдэн удаа “Хэнээ” (одоо нэр нь мартагджээ) гэж нарийн бичиг байлдагчаа дуудаж нөгөөх нь “Би” гээд орж ирэхээр нь “Аан, чи ашгүй байна уу” гээд л шоолоод ч байгаа юм шиг инээв. Би бүр гайхаад “Та яагаад нарийн бичгээ байн байн дуудаад байгаа юм бэ” гэсэн чинь Магсар генерал “Наад золиг чинь 4 удаа оргох гэж оролдоод. Нэг харахад л шалган нэвтрүүлэх байрын үүдээр гараад алчихдаг гэж байгаа. Манай хэд ч хойноос нь очиж авчирдаг. Аргадаж загнахыг хослуулаад ч нэмэргүй байна гэхээр нь би дуудаж уулзсан юм. Тэгсэн чинь мань хүн “Би ээжтэйгээ хоёулхнаа амьдардаг. Цэрэг татлагын комисст шалтгаанаа хэлж, явмааргүй байна гэхэд “За ямар ч байсан комиссоор орчих. Явуулахгүй байх” гэсэн мөртлөө тэнцүүлээд цэрэгт татчихсан. Ээждээ санаа зовоод байна. Би дахиад ч оргоно” гэдэг байгаа. Тэгэхээр нь би ээж рүү чинь хүн явуулж сураг чимээ авчирна, харин чи миний үүдэнд сууж надад тусла гээд хажуудаа байлгаж байгаа юм. Ээж нь сайн гэсэн мэдээ сонсоод мань хүн тайвширчихсан. Та хэдээр далимдуулан сайн ичээж авах гэсэн юм” гэж үнэн сэтгэлээсээ инээж билээ. “Захирагчийг эмнэлэгт хэвтсэн хойгуур ганц, хоёр офицер, ахлагчаас шалтгаалсан асуудал гарч тухайн үед энэ тухай ам нээхгүй байсан цэргүүд захирагчийгаа хашаагаар орж ирэв үү, үгүй юу гүйн очигцгоож болсон явдлын тухай илтгэл өгсөн гэнэ” гэсэн үлгэр домог шиг яриа ч ам дамжин яригдаж байсныг санаж байна. Миний мэдэх цэргийн бас нэгэн мундаг дарга нарын нэг дээ.

## НҮД ХУДЛАА ХЭЛДЭГГҮЙ

Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид сурвалжилга хийхээр очсон юм. Шинэ цэргүүд ирээд нэг их удаагүй байсан үе. Байлдагчидтай ярилцаж суутал захирагчийн орлогч, дэд хурандаа С.Энхтайван (БХИС-ийн Сэтгэл зүйн тэнхимийн дарга асан, бэлтгэл хурандаа) намайг дуудаж “Чи тэр байлдагчаас “Яагаад оргосон тухай нь асуугаадхаарай. Саяхан хэрэг тарьсан нөхөр байгаа юм” гээд “Хөөе Жоохоноо” гэж цэргийн байраар нэг хашгирав. Бусдаасаа нуруугаар намхан, насанд хүрсэн юм уу гэмээр жаахан хүү хүрч ирлээ. Энэ тэрийг ярилцаж хэсэг хугацаа өнгөрсний дараа яагаад оргосныг нь асуутал “Ангийн хашааны гадаа цэвэрлэгээ хийж байтал автобусны буудалд хот руу явах автобус ирж зогссон. Тэгээд гэнэт ээж минь санагдаад гүйчихсэн” гэж билээ. Дараа нь дэд хурандаа Энхтайванаас мань хүнийг шийтгүүлсэн эсэхийг асуухад



хөдөлмөрөөр хүмүүжүүлнэ гэдэг чинь их чухал юм шүү. Одоо их додигор, Жоохоноогүй юм байхгүй. Бүр цэргийн хүн болохоор шийдчихсэн. “Дарга аа, намайг захирагчийн орлогч, дэд ахлагчийн албанд авахгүй юм биш байгаа” гэж байн байн асуугаад их идэвхтэй гэж билээ. Үүнээс хойш Тайван багшийг сайн мэддэг болсон. Үе үе орж ирэн урам хайрлана. Бас шүүмжлэх зүйлээ ч хэлж л орхино. Хэдэн жилийн өмнө редакцаар дуу шуутайхан орж ирлээ. Ах нь хөөрхөн бэртэй болсон. Удахгүй ачтай болох нь гэж хөл нь газар хүрэхгүй баярлаж байгааг нь хараад энэ хүн алба, амьдралын алинд ч дотоод сэтгэлийн угаасаа хандаж чаддаг хүн юм гэсэн бодол төрсөн. Одоо ч тэр бодол минь хэвээрээ. Өнгөц дүгнэлт гэж битгий бодоорой. Цаанаасаа эерэг гүн мэдрэмж төрүүлдэг тийм хүн байдаг шүү дээ. Тийм л хүн бас цэргийн дарга гэж боддог юм.

## ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭР, АТГА ЧИХЭР

Батлан хамгаалахын сайд Л.Болдыг Дархан, Эрдэнэт, Хялганатын цэргийн ангиудад ажиллахаар явахад дагаж сурвалжилга хийж байсан юм. Тухайн үед сайдыг дагалдан явсан албаны хүмүүсийн нэг нь хошууч генерал Р.Сүхбат. Ангиудад ажилласаар нэлээд оройхон Зэвсэгт хүчний 234 дүгээр ангид ирлээ. Одоо санахад ангиуд ерөнхийдөө багагүй шүүмжлэл сонсож генерал ч үүрэг чиглэл өгч, “хатуухан” хандаж байсан санагддаг юм. Маргааш нь тус ангиас хөдлөхөөр болж машиндаа сууцгааж байтал Сүхбат генерал үдэн өгч буй бие бүрэлдэхүүнийг харж зогсоноо “Уг нь энэ муу хэд маань л хөдөө хөхөрч, гадаа гандан ажлын хүндийг үүрч байгаа юм” гэж хэлчихээд машиндаа сууцхаж билээ. Хэлсэн үг нь чихэнд биш сэтгэлд хүрсэн. Зам зуур хэсэгтээ нээрээ л тийм дээ гэж хөдөө, орон нутагт ажилладаг хэдийгээ өрөвдөж, хайрлаж байснаа тод санаж байна. Цэргээ хайрлах сэтгэл юм даа. Хал нь гаднаа, хайр нь дотроо гэж л үүнийг хэлэх байх. Генералыг Ерөнхий зоиулалтын цэргийн



командлагчаар ажиллаж байхад байс хийгээд л хийж буй, хийхээр төлөвлөж буй ажлууд энэ тэр гээд л ярилцлага, мэдээлэл авах гэж орно. Ямар ч завгүй байсан цаг гаргана. Нойтон хамуу шиг чаргууцалдах юм аа гэж хошигноно. Өгсөн ярилцлагаа буцааж хянана энэ тэр гэхгүй ээ. Товч тодорхой, их цэгцтэй ярьдаг болохоор нь бичихэд ч их амар. Нэг удаа оны эцсээр дарга дуудуулж байна гэхээр нь яваад очлоо. Хаалгыг нь тогшоод шагайтал хуралдаад дууссан бололтой хэдүүлээ сууж байв. Зөвшөөрөл аваад ортол “Энэ нэг юм ярилцлага авна гэж энэ жилжингээ миний өрөөний босгыг элэгдтэл орж ирсэн. Чамайг ер нь хөдөлмөрийн аваргаар шалгаруулна аа гээд хүд хүд инээн тэмдэглэлийн дэвтр бэлэглэж, тавагтай чихрээсээ атгаад өгч билээ. Миний хувьд энэ үг, атга чихэр хоёр ямар ч гавьяа шагналаас илүү үнэ цэнтэй, хийж бүтээх урам хайрласан шагнал болсон юм. Цагаа олсон урам, нүдээ олсон шагнал, шагнал шиг шийтгэл гэдэг ажил, амьдралын хамгийн чухал хөшүүрэг гэж би боддог. Олон ч хүнээс энэ хүний тухай магтаалын үг сонсож байсан. Хүндэтгэж явдаг цэргийн дарга шиг дарга нарын нэг нь билээ.

## ТӨРСӨН ӨДРИЙН БЭЛЭГ

... дугаар ангид салааны захирагчийн алба хашдаг нэгэн танил дүү маань өрөөгөөр минь хальт ороод гарсан юм. Гартаа Орнфлемийн амыг нь зангидсан тортой зүйл барьчихсан явахаар нь “За, чи чинь гоо сайхны бараа зардаг болоо юу” гэтэл “Миний төрсөн өдрийн бэлэг байгаа юм аа” гэж инээд алдан задаллаа. Хөмсөгний харандаа, нүүр цэвэрлэдэг хөвөн, крем түрхдэг порлон, нэг удаа хэрэглэхэд зориулсан тос, үсний жижигхэн боолтоос эхлээд юу юу ч байгаа юм. “Чи үүгээр яадаг юм” гэсэн чинь “Цэргүүд маань өгсөн юм аа. Эхнэр, охиндоо өгөөрэй гэсэн. Хамгийн гоё нь энэ” гээд өврөөсөө 4

нугалсан бичгийн цаас гаргаж өгөв. Нээгээд үзтэл дундуур нь нугалаад нүүрэн талд нь зүрх зурчихсан дотор нь “Даргадаа төрсөн өдрийн мэнд хүргэе. Хайртай шүү” гээд 3 ширхэг анхаарлын тэмдэг тавиад доор нь гарын үсгээ зурцаачихаж. Гарын үсэг ч гэж дээ нэрнүүдээ биччихсэн бас “нухсаар” байгаад халтайчихсан тэр цаасыг хараад ямар их хайр хүрсэн гээч. Ёстой хөөрхөн. “Миний төрсөн өдөр гэдгийг хэн нэгнээс сонссон тэр үед нь нэгнийх нь найз охин эргэлтээр ирж таарч. Орифлемийн бараа зардаг тэр охины цүнхэнд

байсан хамаг зүйлийг нь хамсан юм шиг байгаа юм, тэд. Нэг нь надад ам алдсан” гэж залуухан дэслэж өхөөрдөнгүй ярьж, хүүхэд шиг баярлаж байгаа нь илт. “Цэргүүдээ өөртөө ийм сайн хандтал ажиллана гэдэг цэргийн сайн даргын хамгийн чухал шинж дээ. Чи ч мундаг дарга болох нь тодорхой” гэж би ч бас урмын үг хэлсэн. Цэргээ гэсэн дарга, даргаа гэсэн цэргийн сэтгэл, халуун дулаан мэдрэмж ямарч хатуу чанга дүрэм, журмаас илүү гэж би боддог.

# МИНИЙ "НӨХӨР"

## БОЙТЛОГНЫ ХОНХ ШИГ ДАТАЖ ЯВДАТ ЭД ...

**М**эргэжил бүхэнд хөдөлмөрийг нь хөнгөвчилж, ажлыг нь нугалдаг ойрын туслагч гэж бий. Түүнийг бид нөхөр ч гэж нэрлэдэг. Хөгжимчинд зэмсэг, цагдаад бороохой, эмчид чагнуур, гагнуурчинд алх гээд нөхөр мундахгүй. Тэгвэл тооны машин хэний нөхөр байж болох талаар нэг эргэцүүлэе.

Дорно зүгээс гаралтай сампин бол тооцоолуурын хамгийн түгээмэл дэлгэрсэн эртний хэрэгслийн нэг аж. Мөн Антикитерийн механизм гэх тооны машиныг дурсахгүй байхын аргагүй юм. Түүнийг Грекийн Антикитер арлын



ойролцоо эртний Ромын живсэн хөлгөөс 1902 онд олж байжээ. Энэ механизм нь тэнгэрийн эрхсийн хөдөлгөөнийг тооцоо үүрэгтэй ч хуваах, үржүүлэхийн хялбар үйлдлүүдийг хийдэг байсан гэнэ. Эрдэмтэд үүнийг хоёрдугаар зуунд бүтээгдсэн гэж тогтоогоод тооны машины өвөг гэж нэрлэсэн байна. Хүн төрөлхтөн тооны машинтай нэн эртнээс "нөхөрлөж" ирсэнд гайхах зүйлгүй. Гагцхүү хэлбэр дүрс, хөгжил, цаг хугацаагаараа л жишигдэнэ.

Бидний хувьд шаардлагатай гэхээс бусад үед төдийлөн тооны машин хэрэглэдэггүй. Тооны машинтай хамгийн их нөхөрлөдөг хүмүүс бидний амьдралд тодорхой нөлөөг үзүүлдэг гэвэл маргах зүйлгүй биз. Мэдээж таны бодсончлон санхүүх, нягтлан бодогчдын талаар л хэд гурван өгүүлбэр ядмагхан эвлүүлж суна. Тэд болон тооны машины оролцоогүйгээр та бидний ажлын хөлс эздэдээ хүрэхэд тун хэцүү шүү.

Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа Д.Ганбат Цэргийн сургуулийн Ар тал, эдийн засгийн тэнхимийг нягтлан бодогч, цэргийн эдийн засагч мэргэжлээр 1997 онд төгссөн. Тэрээр энэ талаараа "Биднийг төгс боловсорсон төгсөгчид гэж хэлж болно. Ар талын аль ч алба, мэргэжил рүү хөрвөх чадвартай боловсон хүчнүүд төгсөж байсан" гэлээ. Үргэлжлүүлэн ажил амьдралын гараагаа хэрхэн эхлүүлж байсан тухайгаа цухас дурслаа. Зэвсэгт хүчний 310, 072 дугаар анги бол түүний хувьд ажлын анхны талбар юм. Харин тухайн үе нь ажлын дөр сууж, олонтойгоо нөхөрлөж, залуу хүний эд хав, эрч хүчээр цалгисан дурсамжтай он цагуудын хэлхээс аж. Эндээс л түүний нөхрийн талаар түүхийг сөхлөө.

**Ажлын анхны томиллоото эргэн санахад ямар дүр зураг буудаг вэ?**

-Одоо бол программаар ажилтнуудынхаа цалинг бодчихдог болсон цаг үе. Санхүүгийн төрөл бүрийн програмууд бий. Тухайн үед анги, байгууллагад очиж ажиллахад компьютер байхгүй учраас цалинг бодохдоо 939 дүгээр маягтад ангийн захирагчаас эхлээд бүх хүний нэрийг бичиж эхэлнэ. Гараар бодно. Тэгэхэд л тооны машин миний ганц туслах болдог байлаа. Туслах нягтлан бодогч гэж байсангүй. Тооцооны нягтлан бодогч гэж байсан ч санхүүгийн дарга, ахлах нягтлан бодогч цалинг өөрөө л бодох учиртай. Яг тэр үед л үүнийг төгс эзэмшсэн. Одоогийнх шиг амар байгаагүй болохоор залуу байхад шөнө оройн цагаар их суудаг байж дээ. Ажил дээрээ сууна, гэртээ ирээд ч ялгаагүй ширээтэйгээ тохой нийлүүлчихдэг байлаа.

Хурандаа Д.Ганбат энэ зуур урдаа байсан цаасыг нэг харснаа тэр даруй тооны машинаа тачигнуулав. Дэлгэцэн дээрх тоо нүдний өмнүүр жирс, жирс гээд л өөрчлөгдөнө, тэгснээ алга болчихно. Тогтож харна гэвэл нүдний хурд гүйцэхгүй. Гол нь тэр цааснаасаа нүдээ огт салгалгүй, тооны машин руу хяламхийж ч харалгүйгээр тоо бодох нь сониуч занг минь хэсэгтээ л хөдөлгөж орхив. Гарандаа нүдтэй гэмээр юм. Ёстой л гарт нь орно гэж энэ байх даа гэсэн бодол төрдөг юм билээ. Гэхдээ алдах үе цөөнгүй гэдгийг хэлнэ лээ. Тиймээс баталгаажуулах үүднээс их няхуур ханддаг бололтой.

**Таны ажил мэргэжлийн онцлог амьдрал ахуйд тань хэр тусгалаа олдог вэ?**

-Санхүүч хүн гээд л өрх гэрийн төсвийн асуудалд давамгайлж оролцоод байдаггүй. Орлогоо хэрэгтэй зүйлдээ цаг тухайд нь зарцуулна. Түүнээс биш хуримтлалтай болно, үүнийг цааш нь хийе гэсэн айттар төлөвлөгөө, тооцоо барагтаа үгүй. Хань маань л тэр үүргийг гүйцэтгэж, гэрийнхээ төсвийг ерөнхийд нь мэддэг. /Инээв/

**Хүн бүрд ажил, амьдралдаа баримталдаг алтан дүрэм гэж бий. Таны дүрмийг сонирхож болох уу?**

-Миний хувьд цагтаа эхэлсэн бол цагтаа дуусах ёстой гэж боддог. Ажилтнууддаа тавьдаг шаардлага ч бас тэр. Цагт нь ажлаа амжуулаад хэвшчихвэл бидэнд л хэрэгтэй.

Санхүүч хүнд тооны машин гэдэг зүйрлэж хэлбэл хөлд орж байгаа хүүхдэд зүүдэг бойтогны хонх шиг л дагаж явдаг эд аж. Бөх хүний гутал тэсдэггүй гэдэг шиг л юм бодож суусан би эдэлгээнийх нь талаар асуухад янз бүр л гэж хариуллаа. Сая товчлуурддаг нь аваад жил гаруй болж байгаа гэнэ. Бас ширээнийхээ нүдийг онгойлгоод хөдөө гадаа явахдаа хэрэглэдэг гээд өөр нэг "нөхрөө" ч харууллаа. Бүгд л энгийн хэлбэр, хийцтэй. Хурандаа Д.Ганбат тооны машин худалдаж авахдаа хэд хэдэн зүйлийг анхаарч хардаг юм байна. Жишээлбэл, аль ч өнцгөөс харсан дэлгэцэн дээрх тоо тод, гаргацтай, товчлуурууд нь гүйцэд, жигд дарагддаг, хурууны өндгөнд таарсан байх ёстой. Тэрээр үргэлжлүүлэн "Би тооны машиныг цуглуулах хэмжээнд сонирхож, хорхойсдог хүн биш. Өдөр тутамдаа л ажлын хэрэгцээ, шаардлагаар ашигладаг. Харин манай хэлтсийн Амаргаа хурандаа тэр талдаа их баялаг түүхтэй хүн шүү, сонирхлыг чинь татна даа" гэж их л уриалгахан хэллээ. Ийнхүү хурандаа Д.Ганбаттай ажил, мэргэжлийнх нь талаар цухас хөөрөлдсөн аяны богцтойгоос гадна хурандаа М.Амаржаргал гэсэн "үүц"-тэй буцсан юм даг.

## Д.Норжмаа: УНГАР, СОЛОНГОСЫН НУМАА ХАДГАЛДАГ

Үндэсний сурын спортоор яагаад, хэзээнээс хичээллэх болов. Сурын спортынхон ихэвчлэн удам дамжсан хүмүүс байдаг. Танай удамд харваачид бий юу?

-Хамт ажилладаг багш маань санал болгосноор 1998 оноос сурын харваагаар хичээллэж эхэлсэн. Анх сурын харваагаар хичээллэж байх үед бусад тамирчдын маань хувьд гэр бүлээрээ шахуу энэ спортын хорхойтнууд байлаа. Бүр удамд нь ямар нэгэн байдлаар харваач хүмүүс ч байсан юм билээ. Манай удамд харваач хүмүүс байгаагүй. Удам угсаандаа мэргэн харваачдыг бэлтгэж төрүүлэх эхлэлийг тавих нь миний үүрэг гэж боддог.

**Бусад спортоор харьцуулбал нэг их хурд шаарддаггүй ч хүч, мэдрэмж, техник нэхдэг спорт шиг санагддаг. Онцлогийг нь хэлж өгөхгүй юу?**

-Биеийн болон сэтгэлийн хүч, мэдрэмжийг дээд зэргээр шаардана. Анхнаасаа маш зөв, оновчтой техникийг эзэмшээд байнгын бэлтгэл сургуулилтаар түүнийгээ олон жил хадгалж чадвал амжилтын үндэс болох болов уу. Эвэр нумаар харваадаа цаг уурын өөрчлөлт, халуун, хүйтэн, агаарын чийгшил, хур бороо, салхи жавар гээд бүхий л байгалийн үзэгдэлтэй уялдуулах учиртай. Ингэж нумаа мэдэрч харвах нь харваачаас ухаан, чадвар, бэлтгэл гээд их л зүйлийг шаарддаг даа. Тэсвэр хатуужилтай, сэтгэн бодох чадвар сайтай, мэдрэмж өндөртэй, өөртөө итгэлтэй, бие бялдрын хөгжил сайтай байвал болно.

**Халх, Буриад, Урианхай нум гэж байдаг. Хийц, загвараас нь өөр ямар ялгаа байдаг вэ?**

Урианхай харваа нь 30-45 метрийн зайнаас харвадаг, бай нь 380-420 грамм орчим жинтэй. Сураар сүлжиж хийсэн бөөрөнхий байтай. Битүү суран сүлжмэл нь хүнд учир зай нь ойр ч гэсэн хатуу нумаар, 100-120 грамм орчим сумаар харвана.

Харин Буриад харвааны бай нь ноос чихэж хийсэн даавуун бүрээстэй, 8x8 см хэмжээтэй. Зай нь ойрхон, бай нь хөнгөн болохоор зөөлөн нумаар /18-25 кг өргөхтэй дүйцэх/, 70-80 грамм орчим сумаар харвадаг. Үндэсний сур харвааны хувьд эрэгтэйчүүд 75 метр, эмэгтэйчүүд 65 метрээс харвадаг. Сумын жинг 55 граммаас дээш байхаар дүрэмдээ зааж өгсөн. Нумыг нь харваач бүр өөртөө тохируулан сонгодог.

**Сумын тухайд ч бас онцлогтой байх. Жишээлбэл, нэг**

сумаар олон удаа харваж болдог шүү дээ ...

-Сумыг голдуу хус модоор хийдэг. Сумын модыг аль болох бат бөх, эвдрэл хугарал багатай байхаар тооцож сонгож хийдэг. Сумын жин болон нисэлт нь жигд байвал хэдэн жил ч харваж болно. Сумын жин, нумын хүч хоёр зохистой байвал ончтой байдаг. Өрсөн хасааны дундуур сум сүвлэж гарах эсвэл зурхайд туссан боловч хасааны дээгүүр нь харайж гарах зэрэгт оноо

нум эвдрэх вий гэж болгоомжилдог болохоор нэг нумаар хэт удаан харваад байга гэж боддоггүй.

**Бас үнийн хувьд ямархуу вэ, хийц загвар, үүрэг, зориулалт, чанараасаа шалтгаалах уу?**

-Эвэр нум 1-2 сая төгрөгийн үнэтэй. Хэлбэр хийц, зориулалт, загвар, хэв маягаасаа шалтгаалаад харилцан адилгүй.

**Ямар нумыг эдэлгээ сайтай эсвэл муутай гэж хэлэх вэ?**

-Нумын эдэлгээ нь хийцээсээ



тооцдоггүй дүрэмтэй.

**Харваачид ихэвчлэн нэг итгэл даасан хүнээрээ нумаа байнга урлаж хийлгүүлдэг гэх юм билээ. Энэ нь амжилтад ч эергээр нөлөөлдөг гэсэн. Таны хувьд ...**

-Урлаач бүрийн нум, сумыг цуглуулаад, түүнээсээ сонгоод харвадаг хүмүүс ч бий. Миний хувьд Өмнөговь аймгийн Номгон сумын харьяат Монгол Улсын Даяар дуурсах мэргэн Ж.Баттөмөрийн урласан нумаар голдуу харвадаг. 2010-2018 онд харваж, олон сайхан амжилт авчирсан нумаа өнгөрсөн жил төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Ю.Цэдэнбалын нэрэмжит Увс аймгийн музейд байрлуулж хүндэтгэсэн. Нумаа хайрлаж, дээдлэн гэртээ байлгаснаас илүү музейн үзмэр болгон алдаршуулсандаа баяртай байна. Харин сумны хувьд 2008 оноос хойш манай "Алдар"-ын харьяат, Монгол Улсын Гоц харваач, ахлах ахлагч Д.Мөнхгэрэлийн хийцийн сумаар харваж байна.

**Удаан нөхөрлөж, үүргээ ч сайн гүйцэтгээд "гавьяаныхаа амралтад" гарч дээ. Танд хамгийн их удсан нум уу?**

-Тийм ээ. Түүнээс гадна 10 гаруй жил хадгалсан Унгар, Солонгосын нум бий. Энэ спортоор 20 гаруй жил хичээллэхдээ дөрвөн удаа нумаа сольж, шинэчилсэн. Чухал, шийдвэрлэх харвааны үед

гэхээс илүүтэй тухайн эзний хадгалалт, хамгаалалт, хадгалах орчин нөхцөлийн байдал, тээвэрлэлт зэргээс шалтгаална. Бид тэмцээн, харваанд явах бүрдээ хамгийн эхлээд нум, сумаа өөрөөсөө илүү ая тухтай авч явахыг хичээдэг.

**Өнгөрсөн хугацаанд гаргасан амжилтуудын тухайд ...**

-1999 онд анхны цолоо хүртэж спортын мастерын болзол хангаж байлаа. Түүнээс хойш 2007, 2018 онд Үндэсний баяр наадамд дараалан түрүүлж Монгол Улсын мэргэн, Даян мэргэн цол хүртсэн. Мөн 2004, 2005, 2014, 2015 онд Үндэсний баяр наадмын түрүү байрын төлөө харван үзүүрлэж, 3 удаа шөвгөрлөө. Олон улсын тэмцээн буюу Дэлхийн уламжлалт харвааны их наадам (300-аас дээш харваач оролцдог)-д хувийн болон багийн дүнгээр 3 удаа өндөр амжилт үзүүлж оролцсон тул 2015 онд ОУХМ цол хүртсэн. Миний амжилт ч яах вэ. "Алдар"-ын багийн амжилтаараа бахархдаг. Бид 2000 оноос хойш Үндэсний их баяр наадамд 6 түрүү, 10 үзүүр хүртсэн. Таван улсын мэргэнтэй хоёрхон баг бидгийн нэг нь манайх. Бидний бахархам амжилт бүхэн "Алдар" спорт хороо, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний маань ач, буян шүү дээ.

## 20 ЖИЛ ЭЛТЭНДЭЭ ТЭВЭРЧ БАЙНА

"Амьдралынхаа 20 гаруй жилд энэхүү хөгжмөө энгэртээ тэвэрч байна" гэсээр яриагаа эхлэх түүнийг ахлах ахлагч З.Төгсбаяр гэдэг. Зэвсэгт хүчний Жанжин штабын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн гоцлол хөгжимчин юм. Хүүхэд байхаасаа нөхөрлөсөн түүний хөгжмийн зэмсэг нь Корнет буюу нарийн бүрээ юм. Үлээвэр найрал хөгжимд аялгууны бүлэгт багтдаг бөгөөд үндсэн аялгуу нь эгшиглүүлдэг хөгжим аж.

Тэр бээр анх 12 настайдаа энэхүү хөгжмийн зэмсэгтэй нөхөрлөж эхэлжээ. Хөгжимчин болох хүсэл мөрөөдөлтэй хүүгийнхээ авьяасыг нь дэмжиж түүнийг эзж нь нэг сарын цалингаараа буюу 5 мянган төгрөгийг хоёр хуваан төлж, Оросын хуучин хөгжим авч өгсөн ажээ. Түүнийгээ өнгө нь хувирч, хуруу хүрдэг хэсгүүд нь цоортол 10 жил хэрэглэсэн гэнэ. Тэр цагаас хойш өнөөг хүртэл таван хөгжим сольсон бөгөөд эдгээрээс хамгийн үнэ цэнтэй бөгөөд нандин нь түүний эзжийнх нь авч өгсөн анхны хөгжим нь. Удаах нь одоо хэрэглэж байгаа нь аж. Учир нь одоогийн хэрэглэж байгаа хөгжим нь өөрийнх нь гарт ирээд жил ч болоогүй, бараг шинээрээ шахам. Бүр дэлхийд алдартай хөгжмийн брэндээр овоглосон юм байх. Сониуч зан минь түүн рүү "довтолж" хэдэн төгрөгийн үнэтэй болохыг нь асуухад "За нэг машины үнэтэй эд шүү дээ" гэв.

Овор хэмжээний хувьд хамгийн жижиг хөгжимд тооцогддог учир ачаанд өгдөггүй, хаана ч явсан энгэртээ тэвэрчиддэг гэнэ. "Би хүүхдээ ч ийм удаан энгэртээ тэвэрчгүй, харин хөгжмөө 20 жил энгэртээ тэвэрч байна" гэсэн. Түүнчлэн нэг сараас дээш хугацаанд хэрэглэхгүй байх тохиолдолд тосолгоо, арчилгаа нь холдох гээд байдаг учир урт хугацаанд орхиж болдоггүй юм байна. Тиймдээ ч ээлжийн амралттай үедээ дундуур нь заавал нэг удаа ирж



хөгжимдөө салхи оруулахаас гадна тосолгоо, арчилгааг нь хийгээд явдаг гэсэн. Биднийг Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжимчдийн ажлаар очих үед хөл хорионы улмаас уран бүтээлчид амарсан, эзгүй байсан хэдий ч тэрээр дээрх шалтгаанаар ажил дээрээ ирсэн байж таарсан юм. Унасан морьтойгоо уясан эзэн нь ээнгэшин дасдаг. Тэгвэл хөгжимчин хүн ч мөн хөгжмийн зэмсэгтэйгээ ийнхүү дотносдог аж.

# ЛТЧУХИЙН ЖИМ

## ЗӨВЛӨЛТИЙН АНХНЫ ЭНХИЙГ САХИУЛАГЧИД. ЯАГААД 36 ГЭЖ ...



47 жилийн өмнө Каирт Зөвлөлт Холбоот Улсын 36 офицер НҮБ-ын цэрэг буюу энхийг сахиулагчийн цэнхэр берет малгайг ёслол төгөлдөр гардан авсан. Энэхүү үйл явдал нь ОХУ-ын төдийгүй ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улс орнуудын хувьд энхийг сахиулах ажиллагаанд цэргээ илгээж эхэлсэн он цагийн эхлэл юм. Тухайн цагт цэнхэр берет өмсөж НҮБ-ын нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэсэн Анатолий Иванович Исаенкогийн дурсамжийг та бүхэнд сонирхуулъя. Тэрээр Египетийн Синай хотод гурван жил, Израйл-Сирийн маргаантай бүс болох Голаны өндөрлөг ууланд хоёр жил үүрэг гүйцэтгэжээ.

### УРЬДАЧ НӨХЦӨЛ

1973 оны 10 дугаар сарын дундуур Египетийн арми Синай хойгт байлдааны ажиллагааг эхлүүлсэн. Эл дайныг түүхэнд Араб-Израилын дөрөвдүгээр дайн буюу "Дайны шүүлтийн өдөр" хэмээн нэрлэдэг.



Египетийн арми Суэцийн сувгийг гаталж байгаа нь

Тус байлдааны ажиллагаа нь Сирийн иргэдийн дэмжлэгийг авч Египетийн арми ч амжилттай давшиж байв. Удалгүй Израилын тал хариу давшилт хийж Голан өндөрлөгөөс Сирийн иргэдийг хөөж, Суэцийн сувгийг гатлан Суэц хотыг бүслэн авсан юм.

Дээрх нөхцөл байдлаас үүдэн 10 дугаар сарын сүүлчээр НҮБ-ын Аюулгүйн зөвлөл яаралтай хуралдаж хурцадмал байдлыг намжаах зорилгоор

цэрэг оруулахаар шийдвэрлэсэн. Уг үйл явдал болохоос өмнө энэхүү бүсэд 16 орны энхийг сахиулагчид үүрэг гүйцэтгэж байв. Зөвлөлтийн анхны 36 энхийг сахиулагчийг оруулах чухал үүргийг дипломатууд гүйцэтгэсэн бөгөөд сөргөлдөгч талуудыг хэлэлцээрийн ширээнд суулгах хамгийн боломжит улс нь тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улс байсан юм.

Яагаад заавал 36 энхийг сахиулагчийг явуулсан нь их сонирхолтой. Суэцийн бүсэд Шведийн 36 энхийг сахиулагч үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд энэ нь хамгийн олон нь аж. Иймээс ЗХУ-ын зүгээс НҮБ-ын ажиглагчаар үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчдын тоо нь хамгийн олон гэсэн тодотгол зөвлөлтийнх байх ёстой гэх нэг ёсны "шантааж"-ыг хийсэн түүхтэй. Хурцадмал байдлыг хурдан намжаахын тулд тэдний саналыг зөвшөөрч Суэцийн сувгийн бүсэд 18, Голаны өндөрлөг бүсэд 18 ажиглагчийг тус тус илгээжээ.

Дээр хэлсэнчлэн Зөвлөлт Холбоот Улсын дипломатууд маш чухал үүргийг гүйцэтгэсэн. Нэгдсэн Үндэстний Байгууллага энхийг сахиулах ажиллагаа явуулж эхэлсэн энхий үед Зөвлөлтийн мэргэжилтнүүд оролцох эрхгүй байсан. Дараа нь Зөвлөлтийн удирдлага яг юунаас болсныг нь хэлж мэдэхгүй ч өөрсдөө татгалзсаар 1973 оныг хүргэсэн аж.

### ОЙРХ ДОРНОДОД ИРЭХЭД

Миний хувьд Москва хот дахь Гадаад хэлний цэргийн дээд сургуулийг төгсөж Иракт нэг жил, Египетэд гурван жил үүрэг гүйцэтгэсэн туршлагатай ахмад цолтой залуу байсан. Надтай хамт анхны цэргийн ажиглагчаар явсан хүмүүсийн ихэнх нь араб хэлийг янз бүрийн түвшинд сайн мэддэг байв. Тиймдээ ч биднийг Ойрх Дорнодын ажиллагаанд оролцуулах аар сонгосон юм. Гэхдээ хэнийг ч албадаагүй, бүгд сайн дураараа явсан. Энэхүү ажиллагааг эх орныхоо даалгавар гэж хамтрагчид минь үзсэн юм. Бид цаашлаад санхүүгийн талаар ч яриагүй, гол нь эх орныхоо өгсөн өндөр хариуцлага бүхий даалгаврыг амжилттай биелүүлэх ёстой. Учир нь бидний үүрэг гүйцэтгэлтээс Зөвлөлтийн дараа дараагийн энхийг сахиулагчдын хувь заяа хамаарах байлаа.



Бид Каирт цугларсан бөгөөд Иерусалимд үүрэг гүйцэтгэж байсан Австралийн офицер эл хотод ирж бүртгэл хийсний зэрэгцээ өдөр тутмын амьжиргааны тэтгэмж олгосон. Мөн энхийг сахиулахаар ирсэн цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг шалгадаг байсан. Тэр дундаа америкчууд илүү хатуу шаардлага тавина. Хэрвээ шаардлагыг нь хангахгүй бол нутаг буцаах журамтай ба бүхэл бүтэн цэргийн багийг эх орон руу нь буцааж байхыг хүртэл харсан. Тухайн үед бидэнд бүхий л зүйл шинэ, содон байв. Цаашлаад хамтран үүрэг гүйцэтгэх бусад орны цэргийн алба хаагчдын тавьж байгаа асуулт нь хүртэл сонин байлаа. Жишээлбэл, Төв

байранд байрлах удирдах албан тушаалын офицер биднээс "Улсдаа авдаг цалин чинь хэдэн америк доллартой тэнцэх вэ?" гэхэд бид цэрэг шахуу мөрөө хавцсан юм. Учир нь тухайн үед доллар-рубллийн харьцааг мэдэхгүй байсантай холбоотой. Одоо сонсоход итгэмээргүй зүйлс олон бий. Тухайн үед НҮБ-ын цэргийн ажиглагч, штабын офицерууд үүрэг гүйцэтгэж байгаад амь эрсдвэл 20 мянган ам.долларын нөхөн олговрыг олгодог байсан. Одоо 100 мянга орчим ам.доллар болжээ. Хожим нь сонсоход хэрвээ бид амь эрсдэх юм бол нөхөн олговрыг гэр бүлд минь биш улсад өгөх байв. Мөн НҮБ-аас бидэнд өдөр бүр тэтгэмж олгож байсан боловч Зөвлөлтийн Засгийн газар биднийг тэр долларыг ямар нэгэн хэлбэрээр зарцуулахыг хориглоно. Харин батальоны захирагчийн зөвлөх гэсэн орон тооны цалинг бид улсаасаа авдаг байлаа.

### ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЛТ

Надтай хамт ажиглагчаар очсон хүмүүсийн олонх нь байлдааны ажиллагаанд оролцсон туршлагатай байлаа. Үүний зэрэгцээ дэлхийн 16 улсад үүрэг гүйцэтгэсэн хүн хүртэл байв. Тэрээр Алжирт алба хааж байхдаа ерөнхийлөгчтэй нь хамт нисэж, орчуулга хийж байсан тул бидэнд Ойрх Дорнодын орнуудын соёл, зан заншил, харилцааны онцлогийн талаар багагүй мэдлэг олгосон.

НҮБ-ын ажиглагчаар ирж байгаа офицеруудыг хүлээж авах албан ёсны үйл ажиллагаа дууссаны дараа бидний дундаас нэгийг нь сонгон үндэсний ахлах

Египетийн арми байрлаж байгаа бүс бол нөгөө тал нь Израилынх. Хэрвээ ямарваа нэгэн буудалцаан болохыг сонсох л юм бол Ажиллагааны хяналтын төвд мэдэгдэх учиртай.

НҮБ-ын нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчид унтахдаа хүртэл хөх ороолтоо тайлдаггүй байв. Учир нь ороолтоо өөрсдийнх нь сахиус гэж үздэг байсантай холбоотой.

Египетийн болон Сирийн иргэд бидэнд их сайн хандана. Дайны хөлд нэрвэгдсэн улсын иргэдийн дийлэнх хувь нь энхийг сахиулагчдын хийж байгаа ажлыг маш сайхнаар хүлээж авдаг. Аюул



буюу ажиллагааны газар оронд удирдах захирагчийг томилсон юм. Энэхүү үндэсний ахлах нь бидний өмнөөс амьдрах ахуй нөхцөл, ажил үүргийн хуваарийн тодотгол зэргийг удирдлагатай ярилцаж шийдвэрлэдэг байв.

Аль улсаас ирснээс үл хамааран энхийг сахиулагчид нь НҮБ болон Олон улсын хамтын нийгэмлэгийг төлөөлдөг. Би "ЗХУ-ын Засгийн газар болон түүний аливаа нэг албан тушаалтны тушаал, даалгаврыг гүйцэтгэхгүй, зөвхөн НҮБ болон Олон улсын хамтын нийгэмлэгийн тушаал, даалгаврыг биелүүлнэ" гэх агуулгатай баримтад гарын үсэг зурсан.

Миний үүрэг гүйцэтгэсэн эхний гурван цэг маань Синай, Суэцийн сувгийн дагуу майханд байв. Жилийн дараа бидэнд "фургон" загварын машин өгсөн бөгөөд анх хөргөгч, хийн зуухтай болсон юм. Гэхдээ нөхцөл нь дээрдэж шалихгүй. Цэг бүрд ажиллагааны туршлагатай хүнийг ахлахаар томилно. Миний үүрэг гүйцэтгэсэн цэгт Францын цэргийн алба хаагч ахлахаар ажиллаж байсан. Тэр бээр ажиллагааны үеийн олон туршлагаасаа бидэнд зааж зөвлөдөг байлаа.


Бидний ажил өглөө 07.00 цагаас эхэлдэг. Ажиглагчид сэрсэн даруйдаа хяналтын төвтэй холбоонд орно. Үүний дараа өглөөний цайгаа өөрсдөө бэлтгэх бөгөөд эргүүлийн үедээ идэх хүнсээ ч энэ үед бэлтгэдэг. Ажиглагчид өдөр бүр эргүүлд гарна. Хамгийн ойр зай нь гэхэд 5 километрээс ойргүй байх ёстой юм. Эргүүл үйлдэх хязгаар нь нэг талдаа

занал ихэвчлэн зэвсэгт бүлэглэл, террористуудаас ирдэг. Тиймээс тэдний үйл ажиллагааг тодорхой хэмжээнд хязгаарлаж байдаг тул орон нутгийн удирдлага, хууль хүчний байгууллагууд ч хамтран ажиллах дуртай байлаа.

Мэдээж ийм төрлийн үүрэг гүйцэтгэлтийг дагаад эрсдэл үргэлж дэргэд явдаг. Биднээс эргүүл хийх үедээ тодорхой шалгалдсан замаар явахын зэрэгцээ ажиллагааны тогтоосон зааврыг хатуу чанд мөрдөхийг шаарддаг байсан. Учир нь шалгаж, баталгаажуулах замаар явснаас үүдэн энхийг сахиулагчид амь эрсдэх тохиолдол цөөнгүй гардаг байсантай холбоотой юм. Зөвлөлтөөс ирсэн энхийг сахиулагчдын хувьд азаар ийм зүйлсээс холуур өнгөрсөн. Ганц л удаа эргүүлд яваад бааз руугаа буцаж явахдаа эсрэг урсгалаар ирж явсан ачааны тэрэгтэй мөргөлдсөн бөгөөд машинд сууж явсан Зөвлөлтийн энхийг сахиулагч хүнд бэртэл авч эмнэлэгт хүргэгдэж байлаа. Өөрөөр аюул биднээс холуур өнгөрсөн.

Ажиллагаа бүр өөр байдаг. Зарим нь унадаг дугуй унаж Киприйн далайн эргээр эргүүл хийж байхад 2000 километр үргэлжлэх Баруун Сахарын элсэн дунд явганаар, машинаар, бүр цаашлаад тэмээгээр эргүүл хийдэг хэсэг ч бий. Мэдээж НҮБ-ын ажиглагч офицерууд зэвсэгтэй явдаг. Гэхдээ зэвсгийг зөвхөн өөрийгөө болон хамтран үүрэг гүйцэтгэж байгаа нөхрөө, энгийн иргэдийг хамгаалахын тулд л ашиглах эрхтэй. Энэ бол энхийг сахиулагчдыг ердийн цэргээс ялгарах гол ялгаа нь юм.

### БИ ОДОО ХҮРТЭЛ СИНАЙД БАЙГАА



хоногийн урт хугацааны ээлжийн амралт эдэлсэн. Ээлжийн амралтын дараа Цэргийн техникийн талаарх ном, сурах бичгийг гадаад хэлнээ хөрвүүлэн хэвлүүлдэг газар томилогдон цэргийн тэтгэвэрт гартлаа ажилласан. Энэ хугацаанд энхийг сахиулах ажиллагаатай холбоотой 100 гаруй өгүүлэл, нийтлэлийг хэвлүүлсэн юм. Синай-Миний залуу нас.

# СОНИРХУУЛБЯ

## Адмирал Виллиам МагРавен: ХЭРВЭЭ ЧИ ДЭЛХИЙГ ӨӨРЧЛӨХИЙГ ХҮСВЭЛ ЭХЛЭЭД ОРОО ХУРААЖ СУР

Адмирал Виллиам МагРавен 2014 оны 5 дугаар сарын 17-ны өдөр АНУ-ын Техасын Их Сургуулийг төгсөгчдөд зориулж дараах үгийг хэлжээ.

Их сургууль маань “Энд эхэлсэн зүйл дэлхийг өөрчилдөг” гэсэн уриатай. Би энэ урианд дуртай. Өнөө орой Техасын Их Сургуулийг бараг 8000 оюутан төгсөж байна. Аугаа их мэдэгч “Ask.Com”-ийн судалгаагаар



Америкийн иргэн амьдралынхаа туршид дунджаар 10 мянган хүнтэй уулзаж, учирдаг гэжээ. Энэ тун олон хүн шүү. Гэхдээ энэ сургуулийн төгсөгч болгон 10 хүний амьдралд нөлөөлж, тэдний өөрчилж чадвал, тэр 10 хүн дараагийн 10 хүний амьдралыг, тэд нь дараагийн 10 хүнийг гэх мэтчилэн үргэлжилбэл таван үе буюу 125 жилийн дараа 2014 оны төгсөгчид 800 сая хүний амьдралыг өөрчилж чадах болно. 800 сая хүн гэдгийг нухацтай бодоод үзээрэй. Дахин ганц л үе өнгөрвөл та бүхэн дэлхийн бүх хүн буюу 8 тэрбум хүний амьдралыг өөрчилж чадах нь ээ.

Хэрвээ чи 10 хүний амьдралыг өөрчлөх нь хэцүү бас боломжгүй гэж бодож байвал, таны энэ бодол буруу байна. Ийм зүйл боломжтой, амьдрал дээр бодитоор болдог гэдгийг би Ирак, Афганистанд үүрэг гүйцэтгэхдээ өдөр бүр харж байлаа. Багдад хотын төвд тасгаа удирдан явган эргүүлгийн үүрэг гүйцэтгэж байсан залуу офицер цэргүүдээ гудамжны баруун зүгт бус зүүн тийшээ эргүүлэх шийдвэр гаргаснаар урьдчилан бэлтгэсэн ойрын зайн отолтод өөрийн 10 цэргээ орохоос хамгаалж чадсан. Афганистаны Кандахар мужид эмэгтэйчүүдтэй харилцах тусгай бүлгийн нэг ахлагч гудамжинд ямар нэгэн зүйл буруу байгааг мэдэрч, явган цэргийн салааг 250 килограмм жинтэй гар хийцийн тэсрэх бөмбөгөөс холдуулсан нь хэдэн арван цэргийн амь насыг аварч байх жишээтэй. Энд зөвхөн нэг хүний шийдвэрээс эдгээр цэргийн амь нас аврагдаад зогсохгүй, хараахан төрөөгүй байгаа тэдний хүүхдүүд нь мөн адил аврагдсан гэдгийг бодоод үзээрэй. Тэдний хүүхдийн хүүхдүүд мөн адилхан аврагдсан, бүхэл бүтэн нэг үе ганцхан хүний гаргасан шийдвэрээс шалтгаалан аврагдаж байна. Зөв явбал хэн ч, хаана ч дэлхийг өөрчилж чадах юм. Хэрвээ та бүхэн надад хэдхэн хором зарцуулаад хөгшин далайчны үгийг сонсвол, илүү сайхан дэлхийг бий болгоход чинь нэмэр болж магадгүй хэдэн зөвлөгөө байна.

Энэ бүхэн миний цэргийн амьдралын туршлага, сургамжаас үүдэлтэй хэдий ч энэ нь та дүрэмт хувцас өмсөөд цэргийн алба хаасан, хааж буй, үгүй эсэхтэй огт хамаагүй юм. Мөн миний өгөх зөвлөгөө таны хүйс, угсаа гарал, итгэл үнэмшил, шашин шүтлэг, үзэл бодол, нийгмийн гарал үүсэл ямар байхаас үл хамаарч бүгдэд нь тус дэм болох болов уу. Дэлхийд бидэнтэй учирдаг бэрхшээл, зовлон хаана ч адилхан, эдгээр бэрхшээлийг давган гарсан, хичээл, сургамжид үндэслэн амьдрал урагшаа ахидаг. Дэлхий, мөн биднийг хүрээлэн буй орчин, өөрийгөө ч өөрчлөхөд зориулсан ачааг бид бүхний нуруунд тэгш хувааж үүрүүлдэг гэдгийг санаарай.

Миний бие АНУ-ын Тэнгисийн цэргийн тусгай хүчний дайчин, “Далайн хав” (АНУ-ын Тэнгисийн цэргийн тусгай хүчний дайчдыг “Далайн хав” гэж нэрлэдэг) болоод 36 жил өнгөрчээ. Энэ бүхэн Техасын Их Сургуулийг төгсөөд Калифорни мужийн Коронадо руу Тэнгисийн цэргийн “Далайн хав”-ын анхан шатны сургалтад хамрагдсанаар эхэлсэн. “Далайн хав”-ын анхан шатны сургалт гэдэг нь нуранги элсэн дээрх зүдэргээтэй гүйлт, шөнийн цагаар “Сан Диего” дахь хүйтэн усанд хийдэг сэлэлт, саадын зурвас, хэзээ ч дуусдаггүй биеийн тамирын дасгалууд, нойргүй урт шөнүүд, дандаа хүйтэн, нойтон, дутуу гачуу байдалтай үргэлжилдэг 6 сарын хугацааг хэлдэг. Сургалт нь мэргэжлийн тусгайлан бэлтгэгдсэн сургагч багш нарын байнгын дарамт, шахалт дор явагдах ба тэд үргэлж биеийн хатуужил, тэвчээр болоод сэтгэлийн хатгүй хэн нэгнийг олж, Тэнгисийн цэргийн тусгай хүчний “Далайн хав”-уудын эгнээнд орохоос нь өмнө хасах ажлыг гүйцэтгэдэг юм. Гэхдээ энэ сургалт нь байнгын стресс, дарамт, үймээний орчин нөхцөл, уналт болон хүнд цагийн байдлаас бусдыгаа манлайж, удирдан гарч чадааг оюутныг олж, нээн илрүүлдэг сайн талтай. Миний хувьд “Далайн хав”-ын анхан шатны сургалтын 6 сар амьдралыг минь бүрмөсөн өөрчилсөн билээ. Ингээд “Далайн хав”-ын анхан шатны сургалтаас сурсан 10 туршлага, сургамжийг та нөхөдтэй хуваалцаж. Амьдралаа урагшуулахад энэхүү зөвлөгөө тус нэмэр болно хэмээн найдаж байна.

### ХЭРВЭЭ ЧИ ДЭЛХИЙГ ӨӨРЧЛӨХИЙГ ХҮСЭЖ БАЙГАА БОЛ ЭХЛЭЭД ОРОО ХУРААЖ СУР

“Далайн хав”-ын анхан шатны сургалтын үед Вьетнамын дайнд оролцсон туршлагатай сургагч багш нар өглөө бүр цэргийн казармд ирж, хамгийн түрүүнд бидний унтдаг орыг шалгадаг байв. Орыг дүрмийн дагуу тэгш ирмэг гаргаж хураах ба бүтээлгийг чанга ороож, дэрийг яг голлуулж байрлуулна, харин нэмэлт бүтээлгийг хөлийн хэсэгт шоо дөрвөлжин хэлбэртэй эвхэж тавьсан байх ёстой. Тун хялбар даалгавар шүү дээ, ердийн л байдаг зүйл. Гэвч багш нар биднээс өглөө бүр ороо төгс хураахыг шаардана. Энэ бүхэн эхэндээ хөгтэй санагддаг байлаа. Ялангуяа бид чинь жинхэнэ дайчин болж, дайнд ялалт байгуулахаар бэлтгэгдэж буй “чанга гар”-ууд болох “Далайн хав”-ууд шүү дээ. Гэвч энгийн энэ үйлдэл гайхамшиг авчирдаг гэдгийг надад олон удаа харуулсан юм шүү. Хэрвээ та өглөө бүр ороо хурааж сурвал тухайн өдрийн хамгийн эхний даалгавраа ажилттай биелүүлээ гэж бодоорой. Ингэснээр таны өөртөө итгэх итгэл бага ч гэсэн нэмэгдэх ба энэ нь танд дараа, дараагийн даалгавар биелүүлэх урам зоригийг өгөх болно. Өдөр дуусахад ороо хураах жижигхэн даалгаврыг биелүүлсэндээ урамшсан та дараагийн олон даалгаврыг биелүүлж амжсан байна. Мэдээж бодит байдал дээр ороо хураах нь чиний амьдралын бусад том асуудлын хажууд жижиг мэт санагдана. Гэхдээ чи жижиг зүйлсийг зөв хийж чадахгүй юм бол том зүйлийг хэзээ ч зөв хийж чадахгүй.

Амьдрал баялаг учраас хэзээ нэгэн цагт чамд хүнд өдөр тохиолдож, гэртээ харихад хураасан ор угтах ба та цэвэрхэн оронд унтаж амарснаар “маргааш илүү дээр байх болно” гэсэн урам зоригийг сэргээж өгөх нь дамжиггүй. Хэрвээ та дэлхийг өөрчилмөөр байгаа бол яг маргааш өглөөнөөс эхлээд өөрийнхөө орыг хурааж эхлээрэй.

### СЭЛҮҮРДЭХЭД ЧИНЬ ТУСЛАХ ХЭН НЭГНИЙГ ОЛ

“Далайн хав”-ын анхан шатны сургалтад оюутнууд завины бүлэгт хуваагддаг. Нэг завины экипаж нь 7 хүнтэй, жижиг резинэн завины хоёр талд 3, 3 хүн, нэг хүн чиглүүлэгч буюу залуурчин хийнэ. Далайн эрэг дээр өглөө бүр завины бүрэлдэхүүн жагсаж, далайд орж давлагааг сөрөн эргээс хэдэн километрийн зайд сэлүүрдэж очих сургууль хийдэг. Сан Диегод өвлийн цагаар далай 2-3 метрийн өндөр хүчтэй давлагаалдаг учраас хүн бүр сэлүүрдэхгүй бол үүнийг давах тун амаргүй. Залуурчны дохиогоор бүх хүн нэгэн зэрэг сэлүүрдэх ёстой. Завинд байгаа хүн бүр хүчтэй давлагааны эсрэг тэнцүү хүч, чармайлт гаргахгүй бол эрэг рүү буцаад шидэгдэнэ. Завины хувьд зорьсон газартаа хүрэхийн тулд бүх хүн сэлүүр болж хувирах ёстой. Чи ганцаараа дэлхийг өөрчилж чадахгүй, чамд хэн нэгний тусламж үргэлж хэрэг болно. Эхлэх цэгээс хүссэн газраа очихыг үнэхээр хүсэж байвал анд нөхөд, найзууд, алсын бодолтой хэн нэгэнтэй хамт явах хэрэгтэй болох ба мэдээж тэднийг хүчтэй чиглүүлэгч залуурдаж явах шаардлагатай.

### ХҮНИЙГ СЭТГЭЛИЙН ХЭМЖЭЭГЭЭР НЬ ХЭМЖИЖ БАЙГААРЫЙ

Анх 150 хүнтэй эхэлсэн “Далайн хав”-ын хүнд, хэцүү сургалтын эхний хэдэн 7 хоног өнгөрсний дараа оюутнууд хасагдсаар 35 хүн үлдлээ. Үлдсэн биднийг 6 завинд хуваав. Миний хувьд өндөр залуустай хамт нэг завинд таарчээ. Гэхдээ хамгийн сайн экипаж нь дунджаар 167 см өндөртэй нөхөд багтсан завь байлаа. Ийм нэг завинд Америкийн индиан, африк болон итали гаралтай Америк, Америкийн баруун эргээс ирсэн 2 “чанга жаал” багтсан байв. Тэд бусад завины экипажийг сэлүүрдэлт, гүйлт, сэлэлтээрээ үргэлж тэргүүлдэг байв. Далайд сэлэх болгоны өмнө том биетэй нөхөд өөрсдийн сэлүүрийг тэдний жижиг хөлтэй зэрэгцүүлэн тэднийг шоолж, харжоонтойгоор инээд наргийн хийдэг боловч намхан залуус хамгийн уурдан сэлж, эрэгт бусад завинаас дандаа хамгийн түрүүнд ирдэг байсан юм.

“Далайн хав”-ын сургалт бол үнэхээр аугаа тэнцвэржүүлэгч. Энд ямар ч “арын хаалга” гэсэн ойлголт байхгүй ба хэн байх чинь энэ сургалтыг давж гарахад огт хамаагүй. Чиний арьсны өнгө, шашин шүтлэг, баян хоосон, боловсролын түвшин, нийгмийн статус огт нөлөөгүй.

### “ЭЛСЭН ЧИХРЭЭР ХУЧИГДСАН ЖИГНЭМЭГ” ХЭВЭЭР ҮЛДЭХИЙГ ХҮСЭХГҮЙ БОЛ УРАГШЛАХ ХЭРЭГТЭЙ

Хэдэн 7 хоногийн дараа сургагч багш нар оюутнуудыг жагсааж, хувцасны үзлэг хийдэг. Үзлэгийн үеэр хувцсыг өр бусын нарийн шалгана. Малгайг төгс цардсан байх, дүрэмт хувцсыг нямбай индүүдлэг гаргаж индүүдэх, тэлээний толь нь ямар нэгэн толбогүй, гялалзтал өнгөлсөн байх ёстой. Гэвч чи хувцасны үзлэгт яаж ч хичээл зүтгэл гарган бэлдэж, малгайгаа төгс цардаж, дүрэмт хувцсаа нямбай индүүдэж, тэлээнийхээ толийг гялалзтал өнгөлсөн ч энэ бүхэн зүгээр л хангалтгүй гэдгийг ойлгох болно. Сургагч багш нар “ямар нэгэн” буруу зүйл заавал олдог.

Хувцасны үзлэгт унасан оюутан далай руу гүйж ороод бүх хувцсаа норгож, эрэг дээр өнхөрч бүх бие, хувцсаа элсээр бүрэх ёстой. Үүнийг бид “элсэн чихрээр хучигдсан жигнэмэг” хэмээн хочилж нэрлэдэг ба хүйтэн, нойтон, элстэй хувцастайгаа өдөржингөө байх шийтгэл оногдуулж байгаа нь тэр юм. Олон оюутан өөрсдийнх нь хичээл зүтгэлийг үл тоомсорлохыг хүлээн зөвшөөрч чадаагүй ч харамсалтай нь энэ бол үнэн юм. Тэд дүрэмт хувцасны үзлэгт яаж ч сайн бэлдсэн, тэр нь багш нар огт хамаагүй бөгөөд ингэлээ гээд талархал ч илэрхийлдэггүй. Ийм үзэл бодолтой оюутнууд сургалтыг энэ үеийг давж чадалгүй хасагдах ба тэд энэхүү дасгалын цаад санаа, зорилгыг ойлголгүй үлддэг юм. Чи хэзээ ч байнга амжилтанд хүрч чадахгүй. Чи хэзээ ч төгс дүрэмт хувцастай байж чадахгүй ээ. Зарим үед та хэчнээн сайн төлөвлөж бэлдсэн, ажлаа сайн хийсэн ч гэсэн төгсгөлд нь “элсэн чихрээр хучигдсан жигнэмэг” болж дуусдаг юм. Зүгээр л амьдрал заримдаа ийм байдаг. Хэрвээ чи дэлхийг өөрчилж, “элсэн чихрээр хучигдсан жигнэмэг” хэвээр үлдэхийг хүсэхгүй байгаа бол урагшлах хэрэгтэй.

### “ЦИРК”-ЭЭС АЙХ ХЭРЭГГҮЙ

Сургалтын үед өдөр бүр биеийн тамирын хэд хэдэн дасгал, нормативыг биелүүлэх шаардлагатай болдог. Үүнд холын гүйлт, холын сэлэлт, саадын зурвас, олон цаг үргэлжилдэг биеийн тамирын дасгалууд зэрэг чиний зан, ааш араншин шалгах зорилготой дасгалууд багтдаг. Бүх дасгалууд норматив болон хугацаатай байх ба заавал биелүүлэх ёстой. Хэрвээ дасгалын стандартыг биелүүлж чадахгүй бол нэр чинь самбарт бичигдэх ба өдрийн төгсгөлд эдгээр нөхдийг “цирк”-д урьдаг. “Цирк” бол хоёр цагийн туршид үргэлжилдэг биеийн тамирын нэмэлт дасгалууд бөгөөд зорилго нь чамайг туйлдуулах, сэтгэл санааг чинь хүчээр унагаах, улмаар сургалтаас хасах явдал юм. Мэдээж хэн ч “цирк”-т зочлохыг хүсэхгүй. “Цирк” бол тухайн өдрийн даалгавраа биелүүлж чадаагүйн төлөөх өр төлбөр, төлөөс юм. “Далайн хав”-ын сургалтын үеэр бүх оюутан ямар нэгэн байдлаар нэр нь самбарт бичигдэж, “цирк”-т зочилсон байдаг. Харин самбарт нэр нь байнга бичигддэг нөхдийн хувьд сонирхолтой үр дүн гарсан. Дээрх нэмэлтээр хоёр цагийн биеийн хүчний дасгал хийж байсан оюутнууд цаг өнгөрөх тусам улам хүчирхэг болж байлаа. “Цирк”-т байхдаа авч байсан ачаалал, шаналал нь тэднийг сэтгэлийн хаттай болгож, бие махбод нь түргэн хугацаанд өөрчлөгдөн хөгжих болов. Амьдрал бол ийм “цирк”-үүдээр дүүрсэн байдаг. Чиний амьдрал уналтад орж болно, магадгүй бүтээлгийг зүйл ойр ойрхон ч тохиолдож болох юм. Мэдээж уналт бүр чамд гашуун бус хүчтэй өвдөлтийг мэдүүрлж, урам зоригийг чинь мохоодог. Ийм хүнд цаг үе чиний дотоод мөн чанарыг шалгаж байгаа юм. Хэрвээ чи дэлхийг өөрчлөхийг хүсэж байгаа бол “цирк”-ээс айх хэрэггүй шүү.

### ОЛСОН ДЭЭР НЬ ГАРААД ҮЗ

14 хоног бүрд оюутнууд саадын зурвасаар гүйх ёстой. Саадын зурваст элдэв төрлийн 25 саад багтах ба тухайлбал, 3 метрийн өндөртэй хана, 10 метрийн урттай ачааны тор, доогуур нь мөлхдөг өргөст торон саад гэх мэтчилэн. Гэхдээ хамгийн хэцүү нь дүүжин олс. 10 метрийн өндөртэй 2 шонгийн хооронд 60 гаруй метрийн урттай олс дүүжлээстэй. Оюутнууд нэг шон руу авирч гараад олсны дор зүүдэж яваад нөгөө үзүүрт нь хүрэх ёстой. Мэдээж өмнө нь энэ дасгалын рекордыг тогтоосон амжилтыг бидний сургалт эхэлсэн 1977 он хүртэл нэг ч хүн эвдэж чадаагүй байсан юм. Рекордыг эвдэх боломжгүй мэт санагдаж байтал харин нэг өдөр нэгэн оюутан олсны дор дүүжлэгдэж явах бус олсны дээр тогтож явахаар шийдээд тэнцвэрээ олоод

явж эхэлжээ. Энэ нь осолтой бөгөөд тэнэг үйлдэл юм. Хэрвээ амжилтгүй болбол тэр өдрөөс доош унах, бүр сургалтаас ч хасагдаж магадгүй. Гэвч нөгөө оюутан амжилттай урагшилсаар уламжлалт байдлаар уг дасгалыг туулахад зарцуулдаг хугацааны хагаст нь хүрэхгүй хугацаанд нөгөө талд нь гарснаар барахгүй, сургалтын төгсгөлд хувийн рекорд тогтоож чадсан юм. Хэрвээ чи дэлхийг өөрчлөхийг хүсвэл олсны доор бус дээр нь гараад нэг үзээрэй.

### МАХЧИН ЗАГАСТАЙ УЧРАА ОЛ

Газрын байлдааны ажиллагааны сургалтын үеэр оюутнуудыг Сан Диегогийн эргийн эсрэг талд орших “Сан Слементе” арал руу онгоцоор хүргэдэг. “Сан Слементе” арал бол аварга цагаан махчин загас амьдардаг бүс нутаг билээ. “Далайн хав”-ын сургалтыг давахын тулд хэд хэдэн холын зайд усанд сэлэх ёстой ба түүний нэгд нь шөнийн цагаар сэлнэ. Усанд орохын өмнө сургагч багш нар хөгжилтэйгөөр “Сан Слементе” арлын ойролцоох усанд амьдардаг махчин загаснууд болон бусад амьтдын талаар ярьж өгнө. Мэдээж тэд ямар ч оюутан одоогоор махчин загасанд идүүлж байгаагүй гэдгийг хэлэхээ мартахагүй ээ. Гэхдээ багш нар бидэнд дараах зөвлөгөөг өгдөг. Хэрвээ махчин загас чам руу довтлохоор эзэхэ, чамайг тойрч эхэлбэл тухайн газартаа бат зогсох хэрэгтэй. Зугтах үйлдэл гаргаж, сэлж болохгүй. Айж сандарч бүр болохгүй. Хэрвээ махчин загас чамайг “зооглох”-оор дайрвал гараа зангидаж байгаад бүх хүчээрээ загасны хоншоор луу нь цохих хэрэгтэй, ингэвэл тэр буцах болно. Дэлхий дээр маш олон махчин загас бий. Хэрвээ эдгээр сэлэлтийн дасгалыг давахыг хүсвэл махчин загастай учраа олох л хэрэгтэй болно.

### БАЙДАГ ЧАДЛААРАА ХИЧЭЭ

Тэнгисийн цэргийн “Далайн хав”-ынхаа хувьд бидний хийдэг ажил бол дайсны усан онгоцны эсрэг усан дороос довтлох явдал юм. Зогсоолдоо зогсож буй дайсны усан онгоцны устгахын тулд “Далайн хав”-ын хш шумбагч завинаас гарч луужин, усны гүн хэмжигчээс өөр багажгүй, усан доогуур 3 километр сэлсээр байндаа хүрэх ёстой. Бид усан онгоцны доогуур шумбаж, онгоцны хамгийн төв цэг болон гүнд байрлах ёроолыг нь олж, тэсрэх бөмбөг суурилуулах ёстой. Энэ бол чиний даалгаврын зорилго юм. Онгоцны ёроол бол хамгийн харанхуй газарт, хамгийн гүнд байрладаг тул тэнд хүрэхэд эргэн тойронд юу ч харагдахгүй болох ба онгоцны механизм, хөдөлгүүрээс гарах хүчтэй чимээ, шуугиан нь чиний байр зүйн баримжааллыг алдагдуулж, улмаар ажиллагааг нурааж ч болох аюултай юм. Бүх “Далайн хав”-ууд усан онгоцны ёроолд байх цаг үе хамгийн харанхуй гэдгийг мэддэг. Энэ л чиний тайван байж, өөрийнхөө сурсан мэдсэн тактикийн бүх үр чадвараа гаргаж, биеийн болон дотоод сэтгэлийн бүхий л хүчин чадлаа нээж, дайчилж ажиллах ёстой цаг үе юм шүү.

### ХҮЗҮҮГЭЭ ДАЛД ОРТОЛ ШАВАРТ ЗООГДСОН Ч ГЭСЭН ДУУЛ

Ес дэх долоо хоногийг “Тамын 7 хоног” гэж нэрлэдэг. Энд 6 хоног унталгүй, байнгын биеийн болон сэтгэл зүйн дарамт, дайралтад өртөх ба нэг өдрийг бүтэн шавранд зоолттой өнгөрүүлдэг. Сан Диего болон Тижуан хоёрын дунд маш их шавар, намагтай хөндий бий. “Тамын 7 хоног”-ийн Пүрэв гарагт биднийг шаварт хөндийд тууж оруулах ба тэнд дараагийн 15 цагийг хүйтэн шавар, хүчтэй салхин дунд өнгөрүүлж байхад хажуугаар нь сургагч багш нар биднийг ингэж зөвж ядарч байхаар сургалтаас гарч, гэртээ сайхан амрахыг тасралтгүй ятгана. Пүрэв гараг дуусаж, нар жаргахын алдад манай анги сургалтын дүрмийг зөрчсөн “булай” хэрэг өдүүлсэн юм.

Шаварт бидний толгой л цухуйлж бусад хэсэг шигдэн оржээ. Сургагч багш нь зөвхөн 5 оюутан хасагдвал биднийг шавраас гаргаж амраахаа амлаж байв. Зарим оюутны толгой нь шаварт далд орох нь холгүй, хүнд байдалтай байгаа нь ойлгомжтой. Үүр цайтал яс янгинасан 8 цагийн хүйтэн хүлээж байв. Голдоо ортол даарсан оюутнуудын эрүү тачигнаж, сургагч багш нарын чанга хаширах чимээ тасралтгүй сонсогдоно. Гэвч шөнийн тэнгэрт хан нэгтэйгээс хэн нэгэн оюутан дуу дуулах сонсогдоно. Удалгүй дуу дуулж байсан хүний тоо хоёр болсон болох хоёр нь гурав, цаашлаад бүхэл бүтэн ангиараа тэр дууг түрэн дуулж байлаа. Сургагч багш нар биднийг дуу дуулсаар байвал шаварт байх хугацааг сунгана хэмээн сүрдүүлж байсан хэдий ч бид зогсолтгүй дуулсаар байсан билээ. Дуу дуулсны дараа хүйтэн шавар арай л дулаахан ч болсон юм шиг, хүчтэй салхи бага ч гэсэн намуухан болж, үүр цайхад ойрхон мэт санагдаж байсан.

Хэрвээ би дэлхийд амьдрах хугацаандаа ямар нэгэн зүйлийг сурсан гэж бодвол тэр нь хэн нэгэнд итгэж, найдах хүч юм. Нэг хүний хүч, жишээ нь АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Вашингтон, А.Линколн, М.Кинг, Африкийн Манделагаас эхлээд Пакистаны жаахан охин Малала хүртэл ганцхан хүн бусад хүмүүст итгэл найдвар өгснөөр дэлхийг өөрчилж болдог гэдгийг харуулсан. Хэрвээ чи дэлхийг өөрчлөхийг хүсвэл, хүзүүгээ далд ортол шаварт зоогдсон ч гэсэн дуу дуулж эхлээрэй.

### ХЭЗЭЭ Ч, БҮР ЯАЖ Ч БАЙСАН ХӨНХ ЦОХИЖ БОЛОХГҮЙ

Хамгийн сүүлд нь хэлэхэд “Далайн хав”-ын сургалтын төвд нэг хонх бий. Зэсээр хийсэн уг хонх нь сургалтын талбайн төвд бүх оюутан харж болохоор байрласан байдаг. Сургалтын явцад шантарч, хасагдаж буй бүх оюутан уг хонхыг цохиод юм. Хонхыг цохисноор чи өглөөний 5 цагт босох хэрэггүй болно. Хонх цохисноор чи хөлдөж үхмээр хүйтэн усанд дахиж шумбах шаардлагагүй болно. Хонх цохисноор чи дахин гүйхгүй, саадын зурвасыг туулахгүй, биеийн тамирын дасгал хийхгүй, сургалтын үед тулгарах ямар ч бэрхшээлтэй дахин нүүр тулахгүй. Зүгээр л тэр хонхыг цохиод л болно. Хэрвээ чи дэлхийг өөрчлөхийг хүсвэл, хэзээ ч бүр яаж ч байсан, тэр хонхыг цохиж болохгүй.

Та бүхэн бол дараагийн зуунд 800 сая хүний амьдралд нөлөөлж чадах хүмүүс юм шүү. Амьдралынхаа өдөр бүрийг ямар нэгэн даалгавар биелүүлэн эхлүүлж байгаарай. Чиний амьдралд чинь тус болох хэн нэгнийг олж нөхөрлөөрэй. Хүн бүрийг хүндэлж яваарай. Амьдрал бол шударга бус, заримдаа удаа дараалсан бүтэлгүйтэлтэй учирна гэдгээ мэддэг байх хэрэгтэй. Гэхдээ зарим үед эрсдэл хүлээж, хүнд цаг үе тулгарахад нэр төртэй даван туулж, ядарсныг өргөж, задарсныг дарж, ямар ч бэрхшээлийн өмнө хэзээ ч, яасан ч бууж өгөлгүй амьдрах ёстой. Хэрвээ чи эдгээр зүйлийг хийж чадвал, чиний дараагийн үе, тэрний дараагийн үе одоогийн дэлхийг бодвол хавьгүй илүү сайхан дэлхий дээр амьдарч чадах болно. Мэдээж энд эхлүүлсэн зүйл дэлхийг өөрчилж, илүү сайн сайхныг авчрах болно.

Та бүхэнд баярлалаа.

*Тодруулга: АНУ-ын Тэнгисийн цэргийн 4-одтой адмирал Виллиам МагРавен нь 1955 онд төрсөн. Техасын Их Сургууль, Тэнгисийн цэргийн офицерын сургууль, Тэнгисийн цэргийн дипломын дараах сургуулийг тус тус төгссөн. Тэр бээр 2006-2008 онд Европ дахь Тусгай хүчний командлагч, 2008-2011 онд Тусгай хүчний нэгдсэн командлалын командлагч, 2011-2014 онд АНУ-ын Тусгай хүчний командлалын командлагчаар тус тус ажиллаж байгаад завьяаныхаа амралтад гарчээ.*

**Орчуулсан цэргийн ухааны доктор (Ph.D),  
хурандаа Р.ЭНХБОЛД**